



АШУҮИС

Анагаахын Шинжлэх Ухааны Үндэсний Их Сургууль

1942

**АНАГААХ УХААНЫ СУРГУУЛИЙН
СУРГАЛТЫН АЛБА**

**ДАДЛАГАЖУУЛАХ
ЭМНЭЛЗҮЙН СУРГАЛТЫН
УДИРДАМЖ**

Анагаах Ухааны Сургуулийн 6-р дамжааны оюутнуудад зориулав.

2015 ОН

БАТЛАВ: Анагаах Ухааны Сургуулийн захирал АУ-ны доктор,
Профессор С.Мөнхбаярлах

ДАДЛАГАЖИГЧ ЭМЧИЙН СУРГАЛТЫН УДИРДАМЖ

Зохиогчид:	Л.Баярхүү	АУ-ны магистр
	Н.Баярмаа	АУ-ны доктор
	Н.Баясгалан	АУ-ны магистр
	Л.Ганболд	АУ-ны доктор, дэд профессор
	Б.Гомбосүрэн	АУ-ны доктор, дэд профессор
	Г.Мэндсайхан	АУ-ны доктор
	Д.Мягмарцэрэн	АУ-ны доктор
	Ц.Сарантуяа	АУ-ны доктор, дэд профессор
	Ж.Сувд	АУ-ны доктор, профессор
	О.Сэргэлэн	АШУ-ны доктор, профессор
	Р.Сандуйжав	АУ-ны доктор, профессор
	Г.Чойжамц	АУ-ны доктор, профессор
	О.Батсүх	АУ-ны магистр
	Х.Чингэрэл	АУ-ны доктор
	Д.Удвал	АУ-ны магистр
	Б.Балжинням	АУ-ны магистр
	М.Ундрэм	АУ-ны магистр
	Э.Хангай	MD
	Б.Уянга	MD
	Э.Мандуул	MD

Эмхэтгэн нэгтгэсэн: Э.Хангай АУС-ийн СА-ны Мэргэжилтэн

Хянасан: С.Мөнхбаярлах АУС-ийн захирал, АУ-ны доктор, профессор

Зөвшөөрсөн: Н.Эрдэнэхүү ЭМШУИС-ийн Сургалтын бодлого зохицуулалтын
газрын дарга, АУ-ны доктор

Зохиогчдын зөвшөөрөлгүйгээр хэвлэх, хувиан олшруулахыг хориглоно.

АШУУИС-ийн Эрхэс хэвлэх үйлдвэрт хэвлэв

Товчилсон үгийн жагсаалт

АУ	Анагаах ухаан
АУС	Анагаах ухааны сургууль
БЗХӨС	Бэлгийн замын халдварт өвчин судлал
БС	Бөөр судлал
БиоАС	Биоанагаах ухааны сургууль
ДШС	Дотоод шүүрэл судлал
ДЭС	ДАДЛАГАЖУУЛАХ ЭМНЭЛЗҮЙН СУРГАЛТ
ЗС	Зүрх судлал
ИСМУС	Их сургуулийн мэдээлэл удирдлагын систем
МЗӨС	мэс заслын өвчин судлал
МХҮ	мэргэшүүлэх хичээлийн үнэлгээ
НҮЭМ	Нөхөн үржихүйн эрүүл мэнд
НЭМС	Нийгмийн эрүүл мэндийн сургууль
ӨАУ	Өрхийн анагаах ухаан
СБЗГ	Сургалтын бодлого зохицуулалтын газар
СС	Сүрьеэ судлал
УС	Уушиг судлал
ХАУ	Хүүхдийн анагаах ухаан
ХБЭС	Хоол боловсруулах эрхтэн судлал
ХӨС	Халдварт өвчин судлал
ЦС	Цус судлал
ЭМН	Эрүүл мэндийн нэгдэл
ЭМТҮ	Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ
ЭМШУИС	Эрүүл мэндийн шинжлэх ухааны их сургууль
ЭМЯ	Эрүүл мэндийн яам
ЭЭС	Эмнэлзүйн эм судлал
ЯТСА	Яаралтай тусламж сэхээн амьдруулах
MD	Medical doctor
OSCE	Objective structured clinical exams
OSPE	Objective structured practical exams

ДАДЛАГАЖУУЛАХ ЭМНЭЛЗҮЙН СУРГАЛТЫН ХӨТӨЛБӨР

Нийт судлах кредит: 31

Сургалтын хэлбэр

Лекц	Эмнэлзүйнлекц
Дадлага	Эмчийг дагалдан бие даан дадлагажих хичээл
Семинар	Жижигбүлгийн хичээл
Бие даалт	Өвчнийтүүх хамгаалалт, эмч нарын хуралд оролцох, эмнэлэгт жижүүр хийх,олон нийтэд зориулсан сургалтанд оролцохг.м

Хичээлийн тодорхойлолт, зорилго, зорилт

ДАДЛАГАЖУУЛАХ ЭМНЭЛЗҮЙН СУРГАЛТ (ДЭС) нь “Хүний их эмч” мэргэжлээр анагаах ухааны бакалаврын суурь боловсрол олгох сургалтын нэгдмэл хөтөлбөрийн I-V дамжаанд эзэмшсэн онолын мэдлэг, эмнэлзүйн ур чадварыг бататган хөгжүүлэх, танхимын болон ажлын байран дах дадлагажих хичээл хосолсон, мэргэшүүлэх хичээлийн сургалт юм.

Зорилго

Анагаах ухааны бакалаврын суурь боловсрол олгох сургалтын нэгдмэл хөтөлбөрийн мэргэшүүлэх хичээлээр дамжуулан суралцагчдад хүний их эмч мэргэжилтэнд тавигдах шаардлагад заагдсан мэдлэг, чадвар, хандлагыг бататган хөгжүүлж, төлөвшүүлэх зорилготой.

Монгол улсын ЭМЯ-наас төгсөгчдөд тавигдах шаардлагад тодорхойлсоноор анагаах ухааны бакалаврын боловсрол эзэмшсэн их эмч нь хувь хүн, гэр бүл, хамт олонд зонхилон тохиолдох өвчин эмгэгийг оношлох, эмчлэх, сэргээн засах, өвчний төгсгөлийн шатанд орсон өвчтөнд хөнгөвчлөх тусламж үйлчилгээ үзүүлэх болон аливаа өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэхэд чиглэгдсэн нийгмийн эрүүл мэндийн арга хэмжээг гардан зохион байгуулах, биечлэн хэрэгжүүлэхэд шаардагдах мэдлэг, чадвар, хандлага эзэмшсэн мэргэжилтэн байхыг заажээ.

Зорилт

- Ерөнхий мэргэжлийн эмчийн түвшинд эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлэх мэдлэг, ур чадвар, харилцаа хандлагыг төлөвшүүлэх,
- Хүмүүнлэг энэрэнгүй ёс, өвчтөний аюулгүй байдал, халдашгүй эрхийг эрхэмлэж ажиллахад суралцах,
- Байгууллагын болон үйлчлүүлэгчдийн нууцыг сахинхамгаалах чадварт суралцах,
- Эмч, эмнэлгийн ажилтан, мэргэжил нэгт нөхөдтэйгээ багаар ажиллах чадварт суралцах,
- Эрхзүйн хүрээнд шийдвэр гарган үйл ажиллагаа явуулах чадвар эзэмших,
- Мэргэжлийн үнэ цэнэ, нийгэмд хүлээх үүрэг хариуцлагаа ухамсарлан, тасралтгүй бие даан суралцах арга барил, чадварт суралцахад чиглэгдэх болно.

Сургалтын нөхцөл, тавигдах шаардлага

Суралцагч сургалтын нэгдмэл хөтөлбөрийн ерөнхий суурь хичээл, мэргэжлийн суурь хичээл болох 21 блок ба эмнэлзүйн ур чадвар олгох шугаман сургалт, зуны үйлдвэрлэлийн дадлагын хичээлийг дүүргэсэн байна.

Хичээлийн залгамж холбоо

ДЭС-ын хөтөлбөр нь сургалтын нэгдмэл хөтөлбөрт тусгагдсан хичээлүүдийн босоо болон хэвтээ интеграцийн залгамж холбоогоор оюутны мэдлэг, чадвар, хандлагыг хөгжүүлнэ.

Босоо интеграцчилал Эзэмшсэн байх суурь мэдлэг, чадвар	Хэвтээ интеграцчилал Өргөжүүлэн хөгжүүлэх мэдлэг, чадвар, хандлага
• Хүний биеийн бүтэц зүй • Эрүүл болон эмгэг үйл судлал • Эмгэг судлал • Клиник биохими • Клиник бичил амь судлал • Клиник дархлаа судлал • Клиник эм судлал • Анагаах ухааны удам зүй • Эрүүл мэндийн эрх зүй • Нийгмийн эрүүл мэндийн үндэс • Эрүүл мэндийн статистик • Тархвар судлал • Гадаад хэл • Компьютер	• Хүүхдийн өвчин судлал • Дотрын өвчин судлал • Эх барих, эмэгтэйчүүдийн өвчин судлал • Настан судлал \геронтолог, гериатри \ • Мэс заслын өвчин судлал • Гэмтэл, согог, хордлого судлал • Халдварт өвчин судлал • Чих хамар хоолойн өвчин судлал • Нүдний өвчин судлал • Мэдрэлийн өвчин судлал • Сэтгэл зүй, сэтгэцийн эмгэг судлал • Хавдар судлал • Сэргээн засал судлал • Лаборатори • Дүрс оношилгоо • Эрүүл мэндийн эдийн засаг • Харилцааны ур чадвар • Анагаах ухааны ёс зүй

Сургалтын орчин

- Лекцийн танхим
- Мэргэжлийн тэнхмүүдийн хичээлийн өрөө
- Эмнэлзүйн ур чадварыг хөгжүүлэх төв
- АШУҮИС-ийн сургалтын түшиц эмнэлгүүд:

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний (ЭМТҮ) II шатлалын эмнэлэг: АШУҮИС-ийн нэгдсэн эмнэлэг, Баянгол, Баянзүрх, Сонгинохайрхан, Сүхбаатар, Чингэлтэй, Хан-Уул дүүргийн эрүүл мэндийн нэгдэл (ЭМН) ба эмнэлэгүүд, Ачтан, Гурван гал эмнэлэг.

ЭМТҮ-ний III шатлалын эмнэлэг: Улсын нэгдүгээр төв эмнэлэг, Улсын хоёрдугаар төв эмнэлэг, Улсын гуравдугаар төв эмнэлэг, Төрийн тусгай албан хаагчдын нэгдсэн эмнэлэг, Хавдар судлалын үндэсний төв, Халдварт өвчин судлалын үндэсний төв, Эх хүүхдийн эрүүл мэндийн үндэсний төв, Клиникийн нэгдүгээр амаржих газар.

Хичээлийн багтаамж, оролцох тэнхим

14 мэргэжлийн тэнхим оролцсон 15 мэргэшүүлэх хичээлээр 2 тойролт бүхий нийт 28 багц цагийн багтаамжтай сургалт. ДЭС-ын нэг тойролт нь хичээлийн жилийн нэг улирал үргэлжилнэ. Оюутан долоо хоногт 20 цагийн (лекц 2-4 цаг, дадлага 16-20 цаг, семинар 2-4 цаг) хичээл, 20 цагийн бие даалтын хичээлд хамрагдана.

Хичээлийн багтаамж, бүтэц

ТОЙРОЛТ 1	Багц цаг	Цаг	Лекц	Семинар	Дадлага	Бие даалт
Бөөр судлал	2	52	4	8	8	32
Дотоод шүүрэл судлал	1	20	2	4	4	10
Зүрх судас, үе судлал	2	52	4	8	8	32
Уушги судлал	2	52	4	8	8	32
Хоол боловсруулах эрхтэн судлал	3	78	6	12	12	48
Цус судлал	1	26	2	4	4	16
Хавдар судлал	1	20	2	4	4	10
Эх барих эмэгтэйчүүд судлал	4	104	8	16	16	64
ТОЙРОЛТ 2	Багц цаг	Цаг	Лекц	Семинар	Дадлага	Бие даалт
Ерөнхий мэргэжил, урьдчилан сэргийлэх анагаах ухаан	3	100	4	16	16	64
Хүүхдийн анагаах	3	80	8	16	16	40
Халдварт өвчин судлал	2	52	4	8	8	32
Яаралтай тусламж, сэхээн амьдруулах	1	26	2	4	4	16
Гэмтэл согог судлал	2	52	4	8	8	32
Мэс засал	2	70	6	12	12	40
ШУГАМАН СУРГАЛТ	Багц цаг	Цаг	Лекц	Семинар	Дадлага	Бие даалт
Клиник эм судлал	2	40	24	16		

ДЭС-ын мэргэшүүлэх хичээлээр тойролт хийх загвар

Бөөр судлал (2дх)	Дотоод шүүрэл судлал (1дх)	Зүрх судас судлал (1дх)	Уушиг судлал (2дх)	ХБЭС (2дх)	Цус судлал (1дх)	ЭБЭС (4дх)
Өрхийн анагаах (4дх)			Мэс засал (3дх)	Халдварт (2дх)	Яаралтай тусламж (1дх)	Хүүхдийн анагаах (4дх)

дх: долоо хоног

ДЭС хариуцсан зохицуулагч багш, аргазүйчид

Зохицуулагч багш Эрдмийн зэрэг цол

Мэргэжлийн чиглэл

О.Сэргэлэн	ШУ-ны доктор, профессор	Мэс заслын өвчин судлал
Г.Чойжамц	АУ-ны доктор, профессор	Эмнэлзүйн эм судлал
Р.Сандуйжав	АУ-ны доктор, профессор	Хавдар судлал
Т.Ариунаа	АУ-ны доктор, дэд профессор	Бөөр судлал
Л.Ганболд	АУ-ны доктор, дэд профессор	Яаралтай тусламж, сэхээн амьдруулах
Х.Чингэрэл	АУ-ны доктор	Зүрх судас, үе мөч судлал
Г.Мэндсайхан	АУ-ны доктор	Эх барих, эмэгтэйчүүд судлал
Д.Мягмарцэрэн	АУ-ны доктор	Өрхийн анагаах ухаан
Ц.Маналжав	АУ-ны доктор	Уушиг судлал
О.Баатархүү	АУ-ны доктор	Халдварт өвчин судлал
М.Энхзол	АУ-ны доктор	Хүүхдийн өвчин судлал
Н.Баярмаа	АУ-ны доктор	Хоол боловсруулах эрхтэн судлал
А.Эрдэнэбилэг	Магистр	Гэмтэл согог судлал
Б.Оюунтөгс	Магистр	Дотоод шүүрэл судлал
О.Пүрэвжал	Магистр	Цус судлал

Зохицуулагч аргазүйч

Эрдмийн зэрэг цол

Мэргэжлийн чиглэл

Э.Хангай	MD	АУС-ийн мэргэжилтэн
Б.Уянга	MD	АУС-ийн зохион байгуулагч
Э.Мандуул	MD	АУС-ийн зохион байгуулагч

Сургалтын хөтөлбөрт оролцогчдын хүлээх үүрэг

Багшийн үүрэг

- Сургалтын хөтөлбөрийн хэрэгжилтэнд хяналт тавих, үнэлгээ өгөх, шинэчлэн боловсруулах
- Оюутны дадлага хийх тасаг, хэсгийг хувиарлан өгч, сургалтын үйл ажиллагааг танилцуулах
- Оюутанд эмчийн удирдлаган дор дадлагажин суралцах боломжийг олгох, дэмжих, сурах идэвхийг өрнүүлэх
- Дадлагажигч оюутны дадлагын үйл ажиллагаанд хяналт тавих

- Хичээлийн төгсгөлд оюутны мэдлэг, чадвар, хандлагыг үнэлж, оюутны үнэлгээний хуудсанд тэмдэглэх

Оюутны хүлээх үүрэг

- Сургалтын хөтөлбөрийн дагуу лекц, дадлага, семинар, бие даалтын хичээлд идэвхи санаачлага, мэрийлттэй суралцаж, сургалтын кредитийг биелүүлэх,
- Мэргэшүүлэх хичээл бүрийн төгсгөлд эзэмшсэн мэдлэг чадвараа багшаар үнэлүүлж, оюутны дүнгийн хуудсыг цаг хугацаанд нь багшдаа өгч дүгнүүлэх
- Эмнэлэгт ажиллах хувийн бэлтгэлийг бүрэн хангаж, дүрмийн дагуу хувцаслан, энгэрийн тэмдгийг байнга зүүх, чагнуур, даралт хэмжих аппарат, маск, бээлий зэрэг шаардлагатай сургалтын хэрэгсэлтэй байх,
- Сургалт явагдаж буй эмнэлэгийн дотоод журмыг даган мөрдөх
- Эмч, багш нарын хяналт, удирдамжийн доор бие даан суралцах
- Эмчийн зөвшөөрөл болон хяналтан дор өвчтөн үзэж, шинжлэх, гардан ажилбарт оролцох замаар дадлагажих, эмчлэх, оношлох, урьдчилан сэргийлэх арга барил эзэмших
- Дадлагын явцад шийдвэрлэсэн эмнэл зүйн тохиолдлын талаар шинэ мэдээллийг уншиж судлан, мэдлэгээ байнга баяжуулах, бусадтай хуваалцах
- Хамт олон ба үйлчлүүлэгчтэй хүндэтгэлтэй, ёсзүйтэй харилцах
- Үйлчлүүлэгч, байгууллагын нууцыг хадгалах
- Сургалтын хөтөлбөрийн талаар хичээлийн төгсгөлд үнэлгээ өгөх, санал дэвшүүлэх

ДАДЛАГАЖУУЛАХ ЭМНЭЛЗҮЙН СУРГАЛТЫН СТАНДАРТ

АГУУЛГЫН СТАНДАРТ

АШУҮИС-ийн “Хүний их эмч” мэргэжлээр бакалаврын боловсрол олгох сургалтын нэгдмэл хөтөлбөрт тусгагдсан “хүний их эмч” мэргэжилтний эзэмшвэл зохих мэдлэг, чадвар, хандлага болон ЭМЯ-ны сайдын “хүний их эмч” мэргэжлээр бакалавр зэрэгтэй төгсөгчдөд тавигдах нийтлэг ба үндсэн шаардлагад нийцүүлж, ДЭС-аар оюутанд дараах мэдлэг, чадвар, хандлагыг эзэмшүүлнэ.

Оюутны зайлшгүй эзэмшвэл зохих мэдлэг

- Монгол улсын хүн амын дунд зонхилон тохиолдох дотор, хүүхэд, халдварт өвчин, эх барих эмэгтэйчүүд, мэс засалийн эмгэгийг оношлох, ялган оношлох, эмчлэх, зөвлөгөө өгөх, хянах, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх, сэргээн засах, хөнгөвчлөх болон сэхээн амьдруулах яаралтай тусламж үйлчилгээг (өрх ба сумын эмчийн ажлын байрны тодорхойлолтонд заагдсан) ерөнхий мэргэжлийн эмчийн түвшинд үзүүлэх мэдлэг эзэмших,

Оюутны зайлшгүй эзэмшвэл зохих чадвар

- Өвчтөн судлах судалгааны аргад тулгуурлан үзлэг хийх, үндсэн хам шинжүүдийг илрүүлэх, урьдчилсан онош тавих,
- Зонхилон тохиолдох эмгэгийн үед зайлшгүй хийгдэх лаборатори, багажийн шинжилгээг төлөвлөх, дүгнэлт хийх,
- Зонхилон тохиолдох эмгэгийн хам шинж, шинжилгээний дүгнэлтэд тулгуурлан, оношийн үндэслэл гаргах, онош тавих, эмчилгээг төлөвлөх, зөвлөгөө өгөх, хянах, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх, сэргээн засах, хөнгөвчлөх тусламж үйлчилгээг төлөвлөх,
- Үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн байдлыг үнэлж, яаралтай тусламж шаардлагатай амь тэнссэн эгзэгтэй үед сэхээн амилуулах тусламж үйлчилгээ, анхны тусламж үзүүлэх,
- Эмнэлзүйн үндсэн гардан ажилбарыг гүйцэтгэх,
- Эрүүл мэндийн тусламж үйлчилгээнд шаардлагатай бичиг баримтыг хөтлөх, үйлчлүүлэгчийг II ба III шатлалын тусламж үйлчилгээнд илгээх дүгнэлт гаргах

Оюутны зайлшгүй эзэмшвэл зохих хандлага

- Үйлчлүүлэгчийн бие, нийгэм болон сэтгэл зүйн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг илрүүлэн шийдвэрлэх,
- Өвчтөн, өвчтөний ар гэр болон эмч эмнэлгийн ажилтнуудтай ёс зүйтэй харилцах, багаар ажиллах чадвар эзэмших,
- Өвчтөний талаарх мэдээлэл, баримтыг үнэн зөвөөр хөтлөх, нууцыг хадгалах

АРГАЗҮЙН СТАНДАРТ

Хичээлийн хэлбэр	Хичээлийн зорилго, сурах үйл ажиллагаа	Сургалтын үр дүн
Ажлын байранд дадлага хичээл	Эмчийн өдөр тутмын үйл ажиллагаанд оролцон туслах	ЭМТҮ-ний I, II, III шатлалын эмнэлэгт ажиллах чадвар,

Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний I, II, III шатлалын эмнэлэгт эмчийг дагалдан дадлагажих (Долоо хоногт 4-5 өдөр)	• Эмнэлгийн зохион байгуулалттай танилцан, байгууллагын дотоод дүрэм журмыг хүндэтгэн мөрдөх • Үйлчлүүлэгчийг шинжлэн судлах арга барилд суралцах • Эмнэлгийн бичиг баримтыг хөтөлж сурах • Шинжилгээний үзүүлэлтэнд дүгнэлт өгч сурах • Эмнэлзүйн ажилбар хийхэд суралцах • Үйлчлүүлэгч ба эмнэлгийн ажилчидтай харилцаж сурах • Эмнэл зүйн ажилд туслах	хандлага төлөвшинө • Эмнэлзүйн мэдлэг, чадвар, хандлага хөгжинө
Лекц, Интерактив лекц (долоо хоногт 1 удаа)	• Эмнэлзүйн тохиолдлын талаар тойм багц мэдээлэл өгөх • Сэдвийг баяжуулан судлах удирдамж, зөвлөгөө өгөх	• Шинэ мэдээллийн тойм, эх сурвалж олж авна
Жижиг бүлгийн хичээл: семинар (долоо хоногт 1 удаа)	• Сэдвийг баяжуулан бие даан судлах • Лекц, дадлагын хичээлээр олсон мэдлэгээ өргөжүүлэх, дүгнэх, баталгаажуулах • Багаар хамтарч ажиллах • Мэдээллийг солилцох • Дүрд (стандарт өвчтөн бэлтгэх) тоглох, эмнэлзүйн асуудал шийдвэрлэх	• Асуудалд дүн шинжилгээ хийх чадвар эзэмшинэ • Багаар ажиллах чадвар эзэмшинэ • Сурах арга барил сайжирна • Бие дааж сурах чадвар хөгжинө.
Ур чадвар бататгах дадлага хичээл Эмнэлзүйн ур чадварын төвд (долоо хоногт 1 удаа)	• Гардан үйлдлийн ур чадвараа хөгжүүлэх, бататгах • Дууриамал орчинд эмнэлзүйн ажилбар хийх • Амилуулах тусламж үзүүлэх кредит сургалтанд хамрагдах • Компьютерт суурилсан эмнэлзүйн тохиолдлыг шийдвэрлэх	• Үзлэг, шинжилгээний аргууд, гардан үйлдэл, эмнэлзүйн ажилбаруудыг гүйцэтгэх чадвар эзэмшинэ • Амилуулах тусламж үзүүлэх чадвар эзэмшинэ • OSPE, OSCE шалгалтанд бэлтгэнэ
Бие даалт	• Эмнэлзүйн судалгаа, шинжилгээний ажилд оролцох • Номын сан, интернэтээс шинэ мэдээлэл хайх, хэрэглэх арга барилд суралцах • Нийгэмд чиглэсэн сургалт сурталчилгаанд оролцох • Өвчний түүх бичих	• Бие даан суралцах чадвар хөгжинө • Хэрэгцээт мэдээллийг хайж, ашиглаж сурна • Нийгмийн идэвх сайжирна • Харилцааны ур чадвар хөгжинө • Өвчний түүх хөтөлнө

- Мэдээлэл зүйн дэвшилтэт технологи эзэмших

ҮНЭЛГЭЭНИЙ СТАНДАРТ

ДЭС-аар оюутны эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг УЛИРАЛЫН ДҮН болон OSPE шалгалтын үнэлгээгээр жилд 2 удаа дүгнэнэ. АШУҮИС-ийн “Оюутныг үнэлэх журам”-ыг баримтлан оюутны мэдлэг, чадвар, хандлагын түвшинг үнэлнэ.

Хичээл ба шалгалтын ерөнхий тойм

Сар	IX	X	XI	XII	I	II	III	IV	V	VI
Хичээлийн явц	Лекц, Дадлага тойролт 1				Лекц, Дадлага тойролт 2				Давтлага	Төгсөлт
Үнэлгээ	OSPE1				OSPE2				Төгсөх шалгалт	Лиценз шалгалт

УЛИРЛЫН ДҮН

Улирлын төгсгөлд ДЭС-ын мэргэшүүлэх хичээлийн тойролтуудын явцын дүнг нэгтгэн УЛИРЛЫН ДҮН гаргана. Улирлын дүн тооцуулсан оюутан OSPE шалгалтанд орох эрхтэй болно.

Улирлын дүнг АУС-ийн ДЭС хариуцсан аргазүйч нэгтгэн, оюутны үнэлгээг гаргах ба 70 дээш үнэлгээ авсан оюутан нь OSPE шалгалтанд орох эрхтэй болно. ДЭС-ын улирлын дүнг дараах удирдамжийн дагуу үнэлэнэ.

ДЭС-ын улирлын дүнг үнэлэх удирдамж

- Лекцийн хичээлийн оролцоо** Лекцийн хичээл заах тэнхим болон сургалтын албанаас оюутны ирц, оролцоог бүртгэж, үнэлгээ өгнө.
- Мэргэшүүлэх хичээлийн үнэлгээ (МХҮ)** Тухайн улиралд орсон мэргэшүүлэх хичээл бүрийн үнэлгээг нэгтгэнэ. Мэргэшүүлэх хичээл бүрийн тойролт дууссахад багшаасаа дүнгээ авна.

Мэргэшүүлэх хичээлийн үнэлгээг гаргахдаа оюутны эзэмшсэн мэдлэг, чадвар, хандлагыг **дадлагын хичээлийн үнэлгээ** болон **семинар, бие даалтын хичээлийн үнэлгээ** хэмээх 2 үнэлгээний дунджаар дүгнэнэ. Дүнгийн дундаж 70-аас дээш бол тус хичээлийн тойролтыг дүүргэсэнд гэж үнэлнэ.

Мэргэшүүлэх хичээлийн тойролтыг тооцохгүй, хөтөлбөр хангахгүй байх нөхцөл:

- 1) МХҮ-ний оноо 70-д хүрэхгүй байх.
- 2) Оюутан нь хичээлд суугаагүй байх

Дадлагын хичээлийн үнэлгээ

Дадлагын тойролтудирдсан багш хичээлийн төгсгөлд үнэлнэ. Авбал зохих нийт оноо 100 байх ба үүнд:

- | | |
|---|---------|
| • Оюутан бие даан өвчний түүх бичсэн байдал | 30 оноо |
| • Семинарын хичээлд оролцсон байдал | 30 оноо |
| • Оюутныг дүгнэх эмчийн хуудас | 30 оноо |
| • Гардан үйлдэл | 10 оноо |

III. Мэргэжлийн хандлага, төлөвшлийн үнэлгээ АШУҮИС-ийг хүний эмч мэргэжлээр төгсөгч оюутнуудад бие хүний төлөвшил, мэргэжлийн хандлагыг тодорхойлох, оюутан өөрийгөө болон бусдыг үнэлэх зорилготой. Оюутан өөрийгөө өөрчлөн, хөгжүүлэх, сонгосон мэргэжлээрээ ажиллаж суралцахад нэн шаардлагатай оюуны үнэт зүйлсээ танин мэдэх, урам зориг өгөхөд чиглэгдэнэ. Оюутны харилцааны соёл, ёсзүй, хувь хүний төлөвшил, хариуцлага хүлээх чадвар, хүнлэг энэрэнгүй сэтгэл, багаар ажиллах чадвар, мэргэжлийн үнэ цэнийн талаарх хандлагыг эссэ бичилт болон ярилцлагын аргаар үнэлнэ. Оюутанд мэргэжлийн хандлага, төлөвшил **ХАНГАЛТТАЙ** ба **ХАНГАЛТГҮЙ** хэмээх үнэлгээг өгнө.

IV. Эссэ бичлэг Орчин үеийн шинжлэх ухааны техник, технологийн дэвшил, хүн төрөлхтөний түүхэн хөгжлийн даяаршлийн нөхцөлд анагаах ухааны уламжлалт ёс зүйд шинээр урган гарч буй асуудлуудын талаар ирээдүйн эмч нарт шинэ мэдлэг хандлага олгох, төлөвшүүлэх зорилготой. Тогтоосон хугацаанд эссе бичлэгээ АУС-ийн сургалтын албанд өгнө. АУС-ийн анагаахын хөтөлбөр хөгжүүлэх багийн бүрэлдхүүн тус ажлыг үнэлж, шилдэг ажлыг шалгаруулна. Эх 1000 үгэнд багтсан, оюутны нэр, дугаар, анги хэсэг, сэдвийн нэр, товч агуулга, зорилго, зорилт, үндсэн санаа, дүгнэлт, ишлэл номзүй хэсгийг тусгасан, А4 цаас, Arial, 12 хэмжээтэй, 1,15 зайтай бичсэн бүтээл хүлээн авна.

OSPE ШАЛГАЛТ

1998 оноос OSPE-ыг ДЭС-нд оюутны мэдлэг, чадвар, хандлагыг үнэлэхэд хэрэглэж байна. Энэ шалгалтаар оюутны эмнэл зүйн гардан үйлдлийн гүйцэтгэл болон эргэцүүлэн бодох, шийдвэр гаргах, нэгтгэн дүгнэх ур чадварыг үнэлдэг. Оюутан нь эмнэлзүйн ярилцлага хөтлөх, өвчтөнд үзлэг хийн шинжлэх, оношийг тогтоох, эмчилгээний зарчмыг боловсруулах, уг өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгөх мэдлэг, чадвар, хандлагаа эмнэлзүйн нэг тохиолдол дээр иж бүрэн шийдвэрлэн харуулна.

Оногдсон хугацаанд оюутан нь эмнэл зүйн дуураймал орчинд сургалтын муляж, манекен, багаж тоног төхөөрөмжийг ашиглан, асуумж авах, бодит үзлэг хийх, онош тавих, эмчилгээ зөвлөгөө өгөх өртөөг дамжин эмнэлзүйн нэг тохиолдлыг цогцоор нь шийдвэрлэнэ. Өртөө бүрт тохирсон стандарт хариулт бүхий шалгах хуудсаар багш үнэлгээ өгч, 4 өртөөний нийлбэр дүнгээр шалгалтын дүн гарна.

Шалгалтанд орж буй оюутан оногдсон эмнэлзүйн тохиолдлыг уншиж танилцсаны дараа зохих даалгаврыг гүйцэтгэнэ.

Асуумжийн өртөө

- Харилцааны ур чадвар
- Өвчтөнөөс анамнез цуглуулах ур чадвар
- Цуглуулсан асуумждаа дүгнэлт өгөх

- Цаашдын арга хэмжээ шинжилгээ төлөвлөх, дараагын шатлалд илгээх ур чадварыг харуулна.

Бодит үзлэг, гардан үйлдлийн өртөө

- Харилцааны ур чадвар
- Өвчтөнд бодит үзлэг хийх ур чадвар
- Эмгэг шинжүүдийг илрүүлэх тухайн тохиолдлын өөрчлөлтийг хэлэх
- Бодит үзлэгт гарсан өөрчлөлтийг дүгнэх чадвар
- Цаашдын арга хэмжээ шинжилгээ төлөвлөх, дараагын шатлалд илгээх үндэслэлийг гаргах ур чадварыг харуулна.

Оношилгооны өртөө

- Шинжилгээг хийх ур чадвар
- Шинжилгээний өөрчлөлтийг нэгтгэн дүгнэх чадвар
- Өвчтөний анамнез, бодит үзлэг, шинжилгээнд эмнэл зүйн дүгнэлт өгч, оношийн үндэслэлийг гаргаж, оношийг тавих ур чадвар

Эмчилгээ, зөвлөгөөний өртөө

- Оношийн дагуу өвчний талаарх ойлголт, амьдралын хэв маягийн өөрчлөлт, буруу хэв маягийн өөрчлөлтийн сэдээлт өгөх, өрхийн эмчийн хяналт, анхдагч сэргийлэлтийн талаар зөвлөгөө өгөх ур чадварыг харуулна
- Эмийн эмчилгээг төлөвлөх, эмийн тун хэмжээ, хэрхэн яаж хэрэглэх талаар тодорхой бичих ур чадварыг харуулна.
- Оношийн дагуу эрүүл мэндийн тусламж үйлчилгээний шатлалд тохирсон шийдвэр гаргах ур чадвар

Оюутны нийтлэг гаргадаг алдаа

- Өөрийгөө танилцуулахаа мартаж, өвчтөний нэрийг асуухгүй байх, өвчтөнд үзлэг хийж дуусаад ерөөл дэвшүүлэх болон давтан үзлэгийг товлдохгүй байх
- Үйлчлүүлэгчтэй зохисгүй харилцах
- Таагүй мэдээг хүргэхдээ алдаа гаргах
- Өвчтөнөөс хаалттай асуултыг их асууж хугацаа алдах
- Өвчтөнөөс зөвшөөрөл авалгүй шууд үзлэг хийх, гардан үйлдлийг гүйцэтгэх
- Өвчтөнөө буруу байрлуулан үзлэгийг хийх
- Өртөөн дээр гүйцэтгэх даалгаврыг буруу ойлгох

Шалгалтанд ирэхдээ авчрах хэрэгсэл

1. Шалгалтаас 30 минутын өмнө ирсэн байх
2. Сурлагын дэвтэр
3. Эмнэлгийн иж бүрэн хувцастай байх
4. Чагнуур, даралтын аппараттай байх
5. Бээлий маск

6. Үзэг, бал
7. Нэг удаагын тариур

ДОТРЫН ӨВЧИН СУДЛАЛ

Хичээлийн зорилго

Монгол улсад зонхилон тохиолдох дотор өвчин, тухайлбал бөөр, дотоод шүүрэл, зүрх судас, уушиг, хоол боловсруулах, цусны өвчний талаарх хүний их эмч мэргэжлээр төгсөгчдөд тавигдах шаардлагад заагдсан мэдлэг, чадвар, хандлагыг бататган хөгжүүлж, төлөвшүүлнэ.

Дотрын өвчин судлалын мэргэшүүлэх хичээлийн танилцуулга

Оролцох тэнхим:

- Бөөр судлал
- Дотоод шүүрэл судлал
- Зүрх судас үе судлал
- Уушги судлал
- Хоол боловсруулах эрхтэн судлал
- Цус судлал

Хичээлийн багтаамж: 10 долоо хоног үргэлжилнэ. Долоо хоногт 1 удаа лекцийн хичээл, 1 удаа семинарын хичээлд оролцоно.

Дадлагын хичээлийн удирдамж

1. Эмнэлгийн байгууллагад дадлага хийх явцад удирдагч эмч, багшийн шууд хяналтан дор захирагдан ажиллана. Оюутан бие даан, өөрийн дураар үйлчлүүлэгчийн эрүүл мэндийн талаарх аливаа дүгнэлт, шийдвэр гаргах эрхгүй.
2. Монгол оронд зонхилон тохиолддог дотор өвчний үед үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээ, эмнэлзүйн асуудлыг шийдвэрлэх,
3. Ярилцлага болон бодит үзлэг хийх, урьдчилсан онош тавих,
4. ЭМТҮ-ний шатлалд тохирсон дотор өвчнийг оношлох шинжилгээ төлөвлөх
5. Шатлалд тохирсон эрүүл мэндийн маягт, бичиг баримт хөтлөх, бүрдүүлэх,
 - Амбулаторийн карт
 - Өвчний түүх
 - Өвчний оношийг шифрээр тэмдэглэх
 - Магадлагаа , эмнэлгийн хуудас бичих
 - Дуудлага хүлээн авах
 - Эмнэлэгт хэвтэх бичиг
 - 36 А маягт
 - Эмч нарын зөвөлгөөнд (ВКК, ВТЭК-т) танилцуулга бүрдүүлэх: хөдөлмөрийн чадвар алдсан тухай дүгнэлт, хөдөлмөрийн чадвар алдалтын хувь тогтоох, хүндрэлтэй холбоотой бичиг баримтын бүрдүүлэх, өвчтөнийг бэлдэх
 - Дуудлагын хуудас
 - Амбулаторийн эмчийн тайлан
 - ЭМН-д хөтөлдөг анхан шатны баримт маягт
5. Эрүүл мэндийн байгууллагын дотоод үйл ажиллагаанд оролцох

- ЭМН, өрхийн ба клиникийн эмнэлгийн бүтэц, зохион байгуулалттай танилцах
- Эмч , ажилчдын яриа, лекц
- Зөвлөх эмчийн үзлэг
- Эмч нарын зөвлөгөөн
- Эмгэг анатомийн хамтарсан хурал
- Эмч нарын тойрон үзлэг
- Жижүүрийн эмчийн хүлээлцэх тайлан

6. Стационарт ажиллах

7. Амбулаторид ажиллах

8. Клиникт жижүүр хийх

Амбулаторт ажиллах зураглал

- Амбулаторийн эмч-багшийн хяналт дор 3 - 5 эмнэлзүйн тохиолдлыг бие даан шийдвэрлэх
- Шаардлагатай бичиг баримтыг хөтлөх, бүртгэх
- Шинжилгээний хариуг уншиж, дүгнэлт өгөх
- Үйлчлүүлэгчид урьдчилан сэргийлэх, өвчтөнд сэдрэлээс урьдчилан сэргийлэх зөвлөгөө өгөх, нөхөн сэргээх үйл ажиллагааг төлөвлөх
- Гэрийн дуудлаганд явж тусламж үзүүлэх

Стационарт ажиллах зураглал

- Тасгийн эмч-багшийн хяналт дор 3 - 5 эмнэлзүйн тохиолдолд бие даан үзлэг хийх, оношлох, эмчилгээний төлөвлөгөө гаргах, хяналт тавих, эмнэлгээс гарахад нь зөвлөх,
- Үйлчлүүлэгчдийг шинжилгээнд бэлтгэх, шинжилгээний явцад биечлэн оролцох
- Шинжилгээний хариунд дүгнэлт өгөх
- Шаардлагатай бичиг баримтыг хөтлөх, бүртгэх
- Эмчлүүлэгчдэд урьдчилан сэргийлэх, өвчний сэдрэлээс сэргийлэх зөвлөгөө өгөх
- Шийдвэрлэсэн эмнэлзүйн тохиолдлоор өвчний түүх бичиж, багшид болон ангийн оюутнуудад танилцуулж хамгаалах

Клиникт жижүүр хийх зураглал

- Жижүүрийг 16.20 - 8.00 хүртэл хугацаанд, жижүүр эмчийн хамт гүйцэтгэнэ.
- Клиникт тойрон үзлэг 2-3 удаа хийх
- Өвчтөний түүх (2 -3) нээх
- Амбулаторид тохиолдоогүй эмгэгтэй хүний өвчтөний түүхтэй танилцаж, үзлэг хийх
- Сэхээн амьдруулах тасгийн үйл ажиллагаатай танилцах
- Жижүүрийн үйл ажиллагаагаа хөтөлж, тэмдэглэх
- Жижүүрийн мэдээг багш болон тухайн хэсгийн оюутнуудад илтгэж танилцуулах

Семинарын хичээлийн удирдамж

- Семинарын хичээлд идэвхитэй оролцох
- Номын сан, интернет, бие даалтын төв дээр семинарт бэлтгэх
- Семинарын сэдэвтэй холбоотой эмнэл зүйн тохиолдол бэлтгэх, танилцуулах
- Семинарыг багшийн удирдлага дор удирдан зохион байгуулах
- Онолын сэдэв болон тохиолдлыг багаар ажиллан шийдвэрлэх

Бие даалтын хичээлийн удирдамж

Өвчний түүх бичилт Дадлагын үед шийдвэрлэсэн эмнэлзүйн тохиолдлоор “Өвчний түүх” бичилт хийж, танилцуулна. Өвчний түүх бичилтэд дараах мэдээлэл, дүгнэлтийг бүрэн тусгасан байна: асуумж, өвчний түүх, бодит үзлэг, шинжилгээний дүгнэлт, оношийн үндэслэл, ялган оношлогоо, эмчилгээ төлөвлөгөө, зөвлөгөө, өвчний явц динамик тусгасан өдрийн тэмдэглэл, эпикриз бичнэ.

1. БӨӨР СУДЛАЛ

Хичээлийн зорилго

Дадлагажигч оюутан нь бөөрний эмгэгтэй үйлчлүүлэгчээс асуумж авах, үзлэг хийх, зонхилон тохиолдох бөөрний эмгэгийг илрүүлэн шинжилгээ төлөвлөх, оношлох, ялган оношлох, эмчилгээг төлөвлөх, хэрэгжүүлэх, яаралтай тусламж үзүүлэх, зөвлөгөө өгөх, бөөрний өвчин эмгэгийг урьдчилан сэргийлэх талаар “Бөөр ба дотоод орчин” блок, шугаман сургалтаар олж авсан онолын мэдлэг, эмнэл зүйн ур чадвар, эмнэл зүйн харилцаа, хандлагаа бататган суралцана.

Зайлшгүй эзэмшвэл зохих мэдлэг

- Зонхилон тохиолдох бөөрний эмгэгийн оношлогоо эмчилгээний стандартыг судлаж эзэмших
- Яаралтай тусламж шаардлагатай эмгэгүүд, тэдгээрийн үед авах арга хэмжээнд суралцан яаралтай ба анхан шатны тусламж үзүүлэх мэдлэгтэй болох
- Бөөрний өвчний анхдагч хоёрдогч урьдчилан сэргийлэлтийн талаар мэдлэгтэй болох

Зайлшгүй эзэмшвэл зохих чадвар

- Өвчтөн судлах судалгааны аргад тулгуурлан үзлэг хийж, бөөр шээс ялгаруулах эмгэгийн үндсэн хам шинжүүдийг илрүүлэх, урьдчилсан онош тавих
- Бөөрний эмгэгтэй өвчтөнд зайлшгүй хийгдэх лабораторийн болон багажийн шинжилгээг төлөвлөх, тэдгээрт гарах өөрчлөлтийг уншиж дүгнэлт хийх
- Яаралтай тусламж шаардлагатай үед анхны тусламж үзүүлэх
- Өвчтөнд шаардлагатай бичиг баримтыг эрүүл мэндийн байгууллагын шатлалын дагуу зөв бүрдүүлж эмчийн үйл ажиллагаанд шаардагддаг бичиг баримтыг хөтөлж сурах
- Өвчтөн болон үйлчлүүлэгчид эмч эмнэлгийн ажилчидтай харилцах харилцаа хандлагаа төлөвшүүлэх

Зайлшгүй эзэмших дадал хандлага

- Бөөрний эмгэгтэй өвчтөн болон тэдний ар гэртэй харьцаж, тэдний тулгамдсан асуудлыг илрүүлэн шийдвэрлэх
- Эмнэл зүйн тохиолдолд ярилцан үзлэг хийж шинжилгээг оновчтой төлөвлөн асуудлыг зөв шийдвэрлэх чадвар эзэмших
- Өвчтэй хүний биеийн, нийгмийн болон сэтгэл зүйн эрүүл мэндийн тулгамдсан асуудлыг илрүүлэн шийдвэрлэх арга эзэмших
- Өвчтөний ар гэр болон эмч эмнэлгийн ажилтнуудтай зөв соёлтой харьцах харилцааг төлөвшүүлэх багаар ажиллах чадвартай болох
- Өвчтөний талаарх мэдээлэл шинжилгээний өөрчлөлт, баримт зэргийг үнэн зөвөөр хөтөлж, өвчтөний нууцыг хадгалах

Бие даалтын сэдэв

1. Бөөр шээс дамжуулах замын халдварын хам шинж
2. Бөөрөөр өвдөх
3. Артерийн даралт ихдэх
4. Шээсний хам шинж

5. Нефроз хам шинж,
6. Бөөрний дутагдлын хам шинж
7. Бөөрний эдийн гэмтлийн хам шинж

Уншиж судлах ном, гарын авлага

1. Бөөрний өвчний үндсэн хам шинжүүд Ц.Цэцэгмаа 1998 он х
2. Руководство по нефрологий под ред И.Е.Тареева 2000
3. Патафизиология почки Джеймс А. Шмидт 1999 стр 52-54
4. Бөөр судлал, Х.Гэлэгжамц бусад 2012, 9-25х
5. Нефрология А.И.Шилов 2008
6. Б.Гомбосүрэн. Дотрын өвчин судлал 2012
7. Т.Ариунаа Дотрын эмчийн гарын авлага 2014

2. ЗҮРХ СУДАС

Хичээлийн зорилго

Дадлагажигч оюутаннь зүрх судасны эмгэгтэй үйлчлүүлэгчээс асуумж авах, үзлэг хийх, манай оронд зонхилон тохиолдох хам шинж, өвчин эмгэгийг оношлох, ялган оношлох, эмчлэх, зөвөлгөө өгөх, хянах, урьдчилан сэргийлэх талаар "Зүрх судас XI" блок, шугаман сургалтаар олсон онолын мэдлэг, эмнэл зүйн ур чадвар, эмнэл зүйн харьцаа хандлагаа бататган дадлагажиж суралцана.

Зайлшгүй эзэмшвэл зохих мэдлэг

1. Монгол оронд зонхилон тохиолддог өвчний үед илрэх хам шинжийг таних, илрүүлэх, эмчилгээний тактик боловсруулах:

- Артерийн даралт ихдэлт
- Артерийн гипертензийн хямрал
- Цээжээр өвдөх өвдөлт
- Цээжний хурц өвдөлт
- Үеэр хавдах, өвдөх

2. Зүрх судасны өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвөлгөө өгөх

- Таргалалт
- Хөдөлгөөн багадалт
- Хорт зуршил
- Удамын нөлөөний талаар мэдлэгтэй байх
- Давс усны хэрэглээ
- Амьсгалын дээд замын архаг голомтыг зрүүлжүүлэхийн ач холбогдол

3. Яаралтай тусламжийн байдлуудын үед авах анхны арга хэмжээ

Зайлшгүй эзэмшвэл зохих чадвар

1. Зүрх судасны эмгэгтэй өвчтөнтэй ярилцаж, асуумж авах, эмчийн үзлэг хийх, урьдчилсан онош тавих
2. Тухайн хүний эрүүл мэндийн асуудлаас гадна нийгмийн, сэтгэл санааны тулгамдсан асуудлыг илрүүлэн, шийдвэрлэх арга барил эзэмших
3. Өвчтөнд тухайн тохиолдолд тохирсон шинжилгээний төлөвлөгөө зохиох, шинжилгээний хариуг уншиж, дүгнэлт хийх
4. Тухайн тохиолдолд тохирсон шаарлагатай эмчилгээ, зөвөлгөө өгөх
5. Яаралтай тусламж шаардсан байдлуудын талаархи мэдлэгээ бататган, гардан хийх
6. Үйлчлүүлэгчийг эрүүл мэндийн байгууллагын шатлалын дагуу арга хэмжээ авах, бичиг баримт бүрдүүлэх
7. Зүрх судасны эмгэгүүдээс сэргийлэх талаар зөвлөлгөө өгөх /таргалалт, хөдөлгөөн багадалт, стресс, тамхи, архи, ажлын нөхцөл/
8. Эмч, эмнэлгийн ажилтаны болон эмч ар гэрийнхэнтэй харьцах харилцаа, хандлагаа төлөвшүүлэх /Багаар ажиллах чадвартай болох /

Зайлшгүй эзэмшсэн байвал зохих дадал:

1. Зүрх судасны эмгэгтэй өвчтөн болон эрүүл хүмүүстэй харьцаж, тэдний тулгамдсан асуудлыг илрүүлэн, шийдвэрлэхэд туслах, тэдэнтэй харьцах харилцаа, хандлагаа төлөвшүүлэх
2. Эмч, эмнэлгийн ажилтаны болон эмч ар гэрийнхэнтэй харьцах харилцаа, хандлагаа төлөвшүүлэх, багаар ажиллах чадвартай болох

Семинар

Асуудал дэвшүүлсэн илтгэл /эмнэл зүйн тохиолдол/ бэлтгэж хэлэлцүүлэх хэлбэрээр семинар явуулна.

Оюутан бүр хөтөлбөрийн хүрээнд, дадлагажих хичээлийн явцад практикт тохиолдож буй эмнэл зүйн тохиолдлыг бие даан шийдвэрлэхэд гарч байгаа бэрхшээлтэй асуудлыг дэвшүүлсэн илтгэл бэлтгэж хэлэлцүүлэх, харилцан ярилцах, мэтгэлцэх, жижиг бүлгийн сургалтын хэлбэрээр семинар явагдана. Оюутан бүр (багаар) бэлтгэсэн илтгэлээ тайлагнаж, тухайн хэсэгт хэлэлцүүлэн, багийн системээр ажиллан, үзэл бодлоо нэгтгэн тайлагнах хэлбэрээр явуулах.

Семинарийг 2 оюутан удирдан зохион байгуулах ба 3 баг болж ажиллана. Үүнд: багаар ажиллах арга барилд суралцахдаа ажлаа төлөвлөх, хуваарилах, бэлтгэх, зохион байгуулах (цаг хугацаа, шийдвэрлэх арга хэлбэрээ тогтоох).

Семинарт үзүүлэн, шинжилгээний хариу, эмчилгээ оношлогооны шинэлэг мэдээлэл, манай оронд мөрдөгдөж байгаа стандарт, хууль тогтоомж, эмчийн ёс зүйн арга барилыг голлон хэрэглэнэ.

Бие даалт

- Семинарт бэлтгэх онолын мэдээлэлээ цугдуулах, номын санд суух, интернет мэдээлэл цуглуулах
- Өвчтөний талаар асуудал хэлэлцүүлэх бол өвчтөний талаархи мэдээллээ бэлтгэх, түүнтэй холбоотой онолын мэдээллийг бэлтгэх

Уншиж судлах ном, гарын авлага

1. Б.Цэрэндаш “Дотор өвчний онош зүй үзлэгийн аргын үндэс 2003 ху 90-122
2. А.Өлзийхутаг ба бусад “Зүрх судас судлал” ху 22-50, 92-168,182-234,408-570
3. Д.Зулгэрэл бусад “Зүрх судас судлал” -2010 он
4. Довгялло О.Г, Сипарова Л.С "Руководство к практическим занятиям по пропедевтике внутренних болезней" Минск 1986
5. Шулутко Б.И Внутренние болезни 1994
6. В.И. Маколкин, С.И.Овчаренко “ Внутренние болезни” 2000
7. А.Н. Окороков "Диагностика болезней внутренних органов " 2 том, 2000
8. Артерийн гиертензийн удирдамж ДЭМБ, ЭМЯ, ЭМШУИС, МЗССН 2011
9. Хэрэх өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөмж ДЭМБ, ЭМЯ, ЭМШУИС 2010
10. Энциклопедия клинического обследования больного 1997
11. Оюутны ур чадварын төвд"ЭМЧИЙН ҮЗЛЭГ" сургалтын кино 2002 он, Гардан үйлдлийн видео бичлэг 2001 он

3. УУШИГ СУДЛАЛ

Хичээлийн зорилго

Дадлагажигч оюутан нь амьсгалын эрхтний эмгэгтэй өвчтнөөс асуумж авах, үзлэг хийх, манай оронд зонхилон тохиолдох хам шинж, өвчин эмгэгийг оношлох, ялган оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх

зөвлөгөө өгөх, хяналт тавихад блок болон шугаман сургалтаар олж эзэмшсэн онолын мэдлэг, эмнэл зүйн ур чадвартаа түшиглэн бие даан асуудал шийдвэрлэх арга барилд суралцах, эмчийн ёс зүйг төлөвшүүлэх

Дадлагын хичээлээр явагдах сургалт:

1. Монгол оронд зонхилон тохиолддог өвчнийг стационар, ЭМН-ийн түвшинд оношлох, эмчлэх, хянах, урьдчилан сэргийлэх, эмчийн мэргэжлийн ёс зүйг төлөвшүүлэх, бие даан асуудал шийдвэрлэх арга барилд суралцах

Үүнд: Гардан үйлдэл - эмчийн үзлэг

- Уушгины үрэвсэл, уушгины буглаа
- УАБӨ
- Гуурсан хоолойн багтраа
- Гуурсан хоолой тэлэгдэх өвчин
- Уушгины эмфизем
- Гялтангийн үрэвсэл
- Уушгин зүрхний хам шинж
- Цагаан мөгөөрсөн хоолой, гуурсан хоолойн хурц үрэвсэл

2. Амьсгалын эрхтэний өвчнөөс урьдчилан сэргийлэх зөвлөгөө: Тамхи татахтай тэмцэхийн ач холбогдол, Агаарын бохирдол, Ажлын нөхцөл байдал, Удмын өвчний талаар мэдлэгтэй байх, Хувийн ариун цэвэр сахих (цэр, салстыг нулимаж хаяхгүй байх), Амьсгалын дээд замын архаг голомтыг зрүүлжүүлэхийн ач холбогдол

3. Монгол оронд зонхилон тохиолддог архаг өвчний сэдрэлээс урьдчилан сэргийлэх талаар зөвлөгөө өгөх

- өвчнийг эмчлэх эмчийн тактик, зааврыг мөрдөх, эмчилгээний үр дүнг эмчтэй хамтран хянах (цэрний гарц, шинж чанарыг ажиглах, халуурсан үед халуун хэмжих, диуретик хэрэглэх үед уусан шингэн, шээсний гарц хэмжих г. м.)
- Биеэ зөв авч явах байдал (даарч хөрөхөөс зайлсхийх - хувцаслалт, ажил амралтын дэглэм)
- Зөв ханиалгах, зөв амьсгалах талаар
- Эмчилгээний үр дүнг пикфлоуметр ашиглан хянах
- Аэрозоль, дисктэй эмийг зөв хэрэглэх
- Амьсгалын дасгал, чийрэгжилт, нар, ус, агаараар эмчлэх ерөнхий мэдээлэл өгөх

4. Шинжилгээ төлөвлөх, шинжилгээ унших

1. Шинжилгээнд дүгнэлт хийх:

- Цусны ерөнхий шинжилгээ, Шээсний ерөнхий шинжилгээ,
- Коагулограмм, Биохимийн шинжилгээ
- Цэрний ерөнхий болон бактериологийн шинжилгээ
- Гялтангийн шингэний шинжилгээ
- Флюорограмм, Рентгенограмм, Бронхограмм, Компьютерийн томографи
- Спирографийн шинжилгээ
- Сүрьеэгийн сорил, харшлын сорилын шинжилгээ

Уншиж судлах ном, гарын авлага

А. Үндсэн ном сурах бичиг, гарын авлага

1. Д. Рагчаа "Дотрын өвчний онош зүй"

1964

2. Василенко В.Х Пропедевтика внутренних болезней 1982
3. Довгялло О.Г, Сипарова Л.С "Руководство к практическим занятиям по пропедевтике внутренних болезней " Минск 1986
4. Шулутко Б.И Внутренние болезни 1994
5. Б.Батсэрээдэнэ, Ц. Найдансүрэн "Өвчтөний түүх" 1998
6. Б.Батсэрээдэнэ "Уушигны эмгэг судлал" сурах бичиг 2000
7. А.Н. Околоков "Диагностика болезней внутренних органов " 3т., 2000
8. Б.Батсэрээдэнэ, Ц. Найдансүрэн "Уушигны хурц үрэвсэл" 1998
9. Д.Ичинноров "Амьсгалын эрхтний зарим эмгэг" сурах бичиг 2001
10. В.Н. Палеев "Болезни органов дыхания" 2001
11. Б.Гомбосүрэн, Д.Солонго "Уушигны өвөрмөц бус өвчнүүдийн оношлогоо, эмчилгээний стандарт" 2001
12. Б. Цэрэндаш Дотор өвчний онош зүй үзлэгийн аргын үндэс 2003
13. Б.Гомбосүрэн 'Амьсгалын эрхтний эмгэг судлал' 2012

Б. Нэмэлт:

1. Дж.Крофтон, А.Дуглас "Заболевания органов дыхания" 1974
2. Г.Цогт, А.Н.Лаптев "Клиническая пульмонология" 1994
3. Энциклопедия клинического обследования больного 1997

Сургалтанд хэрэглэгдэх материал:

1. Сэдэвчилсэн үзүүлэн, видео бичлэг, СД
2. ЭМШУИС интернет, оюутны бие даалтын төвд "Эмчийн үзлэг" сургалтын кино 2002 он, УЭС-ын гардан үйлдлийн видео бичлэг 2001 он

4. ЦУС СУДЛАЛ

Хичээлийн зорилго

Дадлагажигч оюутан нь цусны эмгэгтэй хүмүүсээс анамнез авах, үзлэг хийх, элбэг тохиолдох хам шинжүүдийг илрүүлэх, зонхилон тохиолдох цусны эмгэгтэй хүнд зайлшгүй шаардлагатай шинжилгээг төлөвлөх, үнэлэх, анхан шатны түвшний тусламж үзүүлэх, урьдчилан сэргийлэх чадвар, хандлагатай болох, дадал, ур чадвараа сайжруулахад оршино.

Эзэмшвэл зохих мэдлэг

- Цусны дэлгэрэнгүй шинжилгээ, гемостазын болон ясны чөмөгний эсийн шинжилгээний аргууд, хэвийн хэмжээ, эмнэл зүйн ач холбогдол
- Манай орны нөхцөлд элбэг тохиолддог цусны зарим эмгэгийн шалтгаан, эмгэг жам, эмнэл зүй, оношлогоо, эмчилгээний зарчим, ялгэн оношлогоо
- Цусны болон цусны бус эмгэгүүдийн үед захын цусанд гарч болох өөрчлөлтүүд
- Цус, цусны бүтээгдэхүүний зохистой хэрэглээ

Эзэмшвэл зохих чадвар:

- Цусны эмгэгтэй өвчтөнөөс анамнез бүрэн цуглуулах
- Цусны эмгэгтэй өвчтөнд үзлэг хийх, элэг, дэлүү, тунгалагын зангилааг тэмтрэх, шинж байдлыг тогтоох.
- Захын цус болон ясны хэмийн шинжилгээнд үнэлэлт өгөх, түүнийг өөрсдийн судалсан түвшинд оношилгоо, эмчилгээнд ашиглах чадвартай болох
- Цусны зарим эмгэгээс сэргийлэх, эрт илрүүлэлтийн талаар сурталчилгаа, таниулга хийх чадвар эзэмших

- Цус багадалтуудын өвөрмөц хэлбэрүүдийг илрүүлэх, шинжилгээ төлөвлөх, эмчлэх
- Антиагегант, антикоагулянт эмүүдийг хэрэглэх
- Цус гоожимтгой эмгэгүүдийг илрүүлэх, шинжилгээ төлөвлөх, яаралтай болон барих эмчилгээг хийх
- Цусны хавдаруудын үед барих эмчилгээ хийх чадвар
- Цусны хавдаруудын төгсгөлийн шатанд халдварын эсрэг, өвчин намдаах, цус тогтоох, арга хэмжээг авах чадвар эзэмшинэ.
- Цус, цусны бүтээгдэхүүнүүдийг хадгалах, тээвэрлэх, сэлбэх, холбогдох баримт, маягтыг хөтлөх

Эзэмшвэл зохих хандлага

- Цусны эмгэгтэй хүмүүс болон тэдний ар гэрийнхэнтэй ёс зүйн хүрээнд харилцах эв дүй эзэмших,
- Цусны эмгэгтэй, цусны хавдартай хүмүүс болон тэдний ар гэрийнхэнд өвчний тавилан, оношлогоо, эмчилгээний талаар үнэн зөв мэдээлэлийг, өгөх, муу мэдээг зөв хүргэх
- Эмч эмнэлэгийн ажилтантай зөв боловсон харьцах харьцааны ёс зүйг эзэмших
- Эмчийн ёс зүйд суралцах
- Эмнэлгийн бичиг баримтын нууцлал, тэдгээрийн гамтай хэрэглээнд сургах
- Цусны хавдартай хүмүүст амьдралын төгсгөлийн шатанд өвчтөнд хөнгөвчлөх тусламж үзүүлэх чадвар, хандлагыг эзэмшүүлнэ.
- **Бие даалт**

Бие даалтын сэдвийг багш оюутан тус бүрт өгөх ба оюутан тухайн сэдэвтэй холбоотой материалыг мэргэжлийн сэтгүүл, интернетээс судалж, реферат, эссе бичиж багшаар үнэлүүлнэ.

Бие даалтын сэдвүүд

1. Цус задралын цус багадалт
2. Лимфогрануломатоз
3. Лимфомын ангилал, оношлогоо
4. Тромбоцитопати
5. Коагулопати
6. Судсан дотор цус түгмэл бүлэгнэх хам шинж
7. Антиагегант, антикоагулянт эмүүд
8. Гемостастик эмүүдийн хэрэглээ

Уншиж судлах ном, гарын авлага

1. Ч. Цэрэннадмид. Өрхийн эмчийн эмнэл зүйн давтан сургалтын материал, II боть: Цусны эмгэг судлалын лекцүүд.
2. Ц. Одгэрэл, А. Отгонбат. Дотрын өвчин судлалын сурах бичиг. Цусны эмгэгүүд бүлэг, 2005 он.
3. Н. Оюундэлгэр, Д. Нэргүй. Цус, цусны бүтээгдэхүүний зохистой хэрэглээ, гарын авлага. 2008 он.
4. Аркадьевич В.И. Анемий 2000 М.
5. Баркаган З.С. Геморрагические синдромы и заболевания 1985 М.
6. Баркаган З.С. Основы диагностики нарушения гемостаза 1999 М.
7. Воробьев А.И. Руководство по гематологии 2000 М.
6. Огороков А. Н. Диагностика и лечение заболеваний внутренних органов. Том 4, 5.2000 он.
7. J. Beck Haematology 1995
8. Wintrobe's clinical hematology, 2005
9. Онлайн эх сурвалжууд, тухайлбал:
www.hematology.org
www.emedicine.com
www.nlm.nih.gov
www.blood.jr.com

4.

ДОТООД ШҮҮРЭЛ СУДЛАЛ

Хичээлийн зорилго

Дадлагажигч оюутан нь дотоод шүүрлийн эмгэгтэй үйлчлүүлэгчээс асуумж авах, үзлэг хийх, манай оронд зонхилон тохиолдох эмгэгийг оношлох, ялган оношлох, эмчлэх, зөвлөгөө өгөх, хянах, урьдчилан сэргийлэх талаар “Биозохицуулалт ба бодисын солилцоо VII” блок, шугаман сургалтаар олсон онолын мэдлэг, эмнэл зүйн ур чадвар, харьцаа, хандлагаа бататган дадлагажиж суралцана.

Зайлшгүй эзэмшвэл зохих мэдлэг

- Монгол оронд зонхилон тохиолддог дотоод шүүрлийн эмгэгийн үед илрэх хам шинжийг таних, илрүүлэх, эмчилгээний тактик боловсруулах
- Яаралтай тусламжийн байдлуудын үед авах анхны арга хэмжээ

Зайлшгүй эзэмшвэл зохих чадвар

- Дотоод шүүрлийн эмгэгтэй өвчтөнтэй ярилцаж, асуумж авах, эмчийн үзлэг хийх, урьдчилсан онош тавих
- Тухайн хүний эрүүл мэндийн асуудлаас гадна нийгмийн, сэтгэл санааны тулгамдсан асуудлыг илрүүлэн, шийдвэрлэх арга барил эзэмших
- Өвчтөнд тухайн тохиолдолд тохирсон шинжилгээний төлөвлөгөө зохиох, шинжилгээний хариуг уншиж, дүгнэлт хийх
- Тухайн тохиолдолд тохирсон шаардлагатай эмчилгээ хийх, зөвлөгөө өгөх
- Яаралтай тусламж шаардсан байдлуудын талаархи мэдлэгээ бататган, гардан хийх
- Үйлчлүүлэгчийг эрүүл мэндийн шатлалын дагуу арга хэмжээ авах, бичиг баримт бүрдүүлэх
- Дотоод шүүрлийн эмгэгүүдээс сэргийлэх талаар зөвлөгөө өгөх /таргалалт, стресс, зохисгүй хооллолт, хөдөлгөөн хомсдол, архи, тамхи, ажлын нөхцөл г.м/
- Эмч, эмнэлгийн ажилтны болон эмч ар гэрийхэнтэй харьцах харилцаа, хандлагаа төлөвшүүлэх /багаар ажиллах чадвар эзэмших/

Зайлшгүй эзэмшсэн байвал зохих дадал:

- Дотоод шүүрлийн эмгэгтэй өвчтөн болон эрүүл хүмүүстэй харилцаж, тэдний тулгамдсан асуудлыг илрүүлэн, шийдвэрлэхэд туслах, тэдэнтэй харилцах харилцаа, хандлагаа төлөвшүүлэх
- Практикт тохиолдож буй эмнэл зүйн тохиолдлыг /ярилцлага, эмчийн үзлэг, шинжилгээ хийх замаар/ оновчтой зөв шийдвэрлэх
- Тухайн үйлчлүүлэгчид шинжилгээнд бэлтгэх, шатлалын дагуу бичиг баримтыг бүрдүүлж туслах, хөтлөх шаардлагатай бичиг баримттай ажиллах
- Эрүүл хүн, өвчтөн, өвчний улмаас тахир дутуу болсон өвчтөнд ялгавартай зөвлөгөө өгөх эмнэл зүйн ур чадварт суралцах
- Эмч, эмнэлгийн ажилтны болон, эмч ар гэрийхэнтэй харьцах харилцаа, хандлагаа төлөвшүүлэх, багаар ажиллах чадвартай болох

Дадлагын явцад оюутны хийж гүйцэтгэх ажлын жагсаалт

1. Монгол оронд зонхилон тохиолдох дотоод шүүрлийн эмгэгүүдийг эрт илрүүлэх, оношлох, эмчлэх, урьдчилан сэргийлэх

- ЧШХШ2-ын эрсдэлт хүчин зүйлсийг эрсдлийн шалгуураар үнэлэх
- ЧШХШ2-ын урьдчилан сэргийлэлт – амьдралын хэв маягийн өөрчлөлтийн зөвлөгөө өгөх
- ЧШХШ2-ын эрт илрүүлэлт хийх, оношлогооны алгоритм ашиглах
- ЧШХШ2-ын эмийн ба инсулин эмчилгээ
- ЧШХШ2-ын хүндрэлээс урьдчилан сэргийлэх
- ЧШХШ2-ын хүндрэлийн оношлогоо эмчилгээ
- Тархмал хордлогот бахуугийн оношлогоо, эмчилгээ
- Анхдагч гипотиреозын оношлогоо, эмчилгээ
- Бамбайн үрэвсэлт өвчнүүдийн оношлогоо, эмчилгээ

2. Шинжилгээ төлөвлөх, шинжилгээний бичиг хийх, шинжилгээ унших

- Эмчийн үзлэгийн кабинетэд үзлэг хийж, шинжилгээ төлөвлөх, хариуг уншиж сурах. Үүнд:
 - Дааврын шинжилгээ Т3,Т4, ТТГ, Инсулин, С пептид
 - Глюкозжсон гемоглобин
 - Микроальбуминури
 - Бамбайн хэт авиан шинжилгээ
 - Сканировани
 - Иод 131-ийн шингээлт

Семинар

Асуудал дэвшүүлсэн илтэл /Эмнэл зүйн тохиолдол/ бэлтгэж, хэлэлцүүлэх хэлбэрээр семинар явуулна.

Оюутан бүр хөтөлбөрийн хүрээнд дадлагажих хичээлийн явцад практикт тохиолдож байгаа эмнэл зүйн тохиолдлыг бие даан шийдвэрлэхэд гарч байгаа бэрхшээлтэй асуудлыг дэвшүүлсэн илтгэл бэлтгэж хэлэлцүүлэх, харилцан ярилцах, мэтгэлцэх, жижиг бүлгийн сургалтын хэлбэрээр семинар явагдана.

Оюутан бүр /багаар/ бэлтгэсэн илтгэлээ тайлагнаж, тухайн хэсэгт хэлэлцүүлэн, багийн системээр ажиллан, үзэд бодлоо нэгтгэн тайлагнах хэлбэрээр явуулах.Семинарыг 2 оюутан удирдан зохион байгуулах ба 3 баг болон ажиллана. Үүнд: багаар ажиллах арга барилд суралцахдаа ажлаа төлөвлөх, хувиарлах, бэлтгэх, зохион байгуулах / цаг хугацаа, шийдвэрлэх арга хэлбэрээ тогтоох/

Семинарт үзүүлэн, шинжилгээний хариу, эмчилгээ оношлогооны шинэлэг мэдээлэл, манай оронд мөрдөгдөж байгаа стандарт, хууль тогтоомж, эмчийн ёс зүйн арга барилыг голлон хэрэглэнэ.

Бие даалт

- Семинарт бэлтгэх онолын мэдээллээ цуглуулах, номын санд суух, интернет мэдээлэл цуглуулах
- Өвчтөний талаар асуудал хэлэлцүүлэх бол өвчтөний талаархи мэдээллээ бэлтгэх, түүнтэй холбоотой онолын мэдээллээ бэлтгэх

Уншиж судлах ном, гарын авлага

- Василенко В.Х. *Пропедевтика внутренних болезней*. 1982, 1990, 1995
- Окорочков А.Н. *Диагностика болезней внутренних органов*. 2000
- Потемкин В.В. *Эндокринология*. 1999
- Балаболкин М.И. *Эндокринология*. 2003
- *Интенсивная и неотложная терапия в эндокринологии*. 2001
- Браверман Л.И. *Болезни щитовидной железы*. 2000
- Jean D. Wilson & Daniel W. Foster. *Williams Textbook of Endocrinology*. Seventh edition

- Francis S. Greenspan & David G. Gardner *Basic and clinical endocrinology*. Seventh edition
- Алтайсайхан.Х, Золзаяа.Х - *Чихрийн шижин өвчний эмнэл зүйн удирдамж*. 2004
- Б. Чихрийн шижингийн эмнэлзүйн удирдамж 2011, ЭМЯ, Улаанбаатар хот
- Чихрийн шижингийн оношлогоо, эмчилгээний стандарт, 2012, УБ хот
- www.Uptodate.com reviewed materials
- Oxford text book of endocrinology and diabetes, 2nd edition, 2011

6. ХООЛ БОЛОВСРУУЛАХ ЭРХТЭН СУДЛАЛ

Хичээлийн зорилго

Дадлагажигч оюутан нь “Хоол тэжээл ба бодисын солилцоо” блок, шугаман сургалтаар олж авсан хоол боловсруулах эрхтний онош зүйн үндэс, манай оронд зонхилон тохиолдох хоол боловсруулах эрхтний эмгэгийн оношлогоо, эмчилгээ, яаралтай тусламж байдлууд ба авах арга хэмжээний талаар эзэмшсэн мэдлэг, ур чадвар, өвчтөнтэй харьцах харьцаа хандлагаа бататган төлөвшүүлж суралцана.

Зайлшгүй эзэмшвэл зохих мэдлэг

- Монгол оронд зонхилон тохиолддог хоол боловсруулах эрхтэн системийн эмгэгийн оношлогоо, эмчилгээний зарчмууд (стандарт)
- Хоол боловсруулах эрхтэний өвчний үеийн яаралтай тусламж, авах арга хэмжээ

Зайлшгүй эзэмшвэл зохих чадвар

- Хоол боловсруулах эрхтэний эмгэгтэй өвчтөнтэй ярилцаж, асуумж авах, эмчийн үзлэг хийх, урьдчилсан онош тавих
- Тухайн хүний эрүүл мэндийн асуудлаас гадна нийгмийн, сэтгэл санааны тулгамдсан асуудлыг илрүүлэн, шийдвэрлэх арга барил эзэмших
- Өвчтөнд тохирсон нэн шаардлагатай эмчилгээ, зөвлөгөө өгөх
- Яаралтай тусламж шаардсан байдлуудын талаархи мэдлэгээ бататган, гардан хийх
- Үйлчлүүлэгчид Эрүүл мэндийн байгууллагын шатлалын тусламж үйлчилгээ үзүүлэх, бичиг баримт бүрдүүлэх
- Хоол боловсруулах эрхтэний эмгэгүүдээс сэргийлэх талаар зөвлөгөө өгөх
- Хоол боловсруулах эрхтэний архаг эмгэгтэй өвчтөний амьдралын чанарыг дээшлүүлэх арга барил, өвчтөн, түүний ар гэрийнхнийг сургах сургалтын үйл ажиллагаанд оролцох
- Эмч, эмнэлгийн ажилтантай болон эмч ар гэрийхэнтэй харьцах харилцаа, хандлагаа төлөвшүүлэх /Багаар ажиллах чадвартай болох/

Зайлшгүй эзэмшсэн байвал зохих дадал

- Хоол боловсруулах эрхтэний эмгэгтэй өвчтөн болон эрүүл хүмүүстэй харьцаж, тэдний тулгамдсан асуудлыг илрүүлэн, шийдвэрлэхэд туслах, тэдэнтэй харьцах харилцаа, хандлагаа төлөвшүүлэх
- Практикт тохиолдож буй эмнэл зүйн тохиолдлыг (ярилцлага, эмчийн үзлэг, шинжилгээ хийж) оновчтой зөв шийдвэрлэх
- Тухайн үйлчлүүлэгчид шинжилгээнд бэлтгэх, шатлалын дагуу бичиг баримтыг бүрдүүлж туслах, хөтлөх шаардлагатай бичиг баримттай ажиллах
- Эрүүл хүн, өвчтөн, өвчний улмаас тахир дутуу болсон өвчтөнд ялгавартай зөвөлгөө өгөх эмнэл зүйн ур чадварт суралцах

- Эмч эмнэлгийн ажилтаны болон эмч ар гэрийнхэнтэй харьцах харилцаа хандлагаа төлөвшүүлэх, багаар ажиллах чадвартай болох

Бие даалт

- Семинарт бэлтгэх онолын мэдээллээ цуглуулах, номын санд суух, интернет мэдээлэл цуглуулах
- Өвчтөний талаар асуудал хэлэлцүүлэхэд мэдээллийг бэлтгэх
- Өвчний тархалтын талаар асуудал дэвшүүлэх бол архивын баримт материалыг зөвшөөрөл авч, танилцаж, дүгнэлт хийх, тодорхой үндэсний хөтөлбөрийн дагуу судалгаа хийж, илтгэхдээ судалгааны арга, онолын тойм материалыг бэлтгэн, харьцуулан дүгнэх, илтгэх г.м

7. ӨРХИЙН АНАГААХ УХААН

Хичээлийн зорилго

Дадлагажигч оюутан нь дүүргийн эрүүл мэндийн төв, өрхийн эмнэлэгт ажиллахдаа хувь хүн, гэр бүлийн гишүүд, хамт олонд зонхилон тохиолдох өвчний хам шинж, өвчин эмгэгийг оношлох, ялган оношлох, эмчлэх, зөвлөгөө өгөх, хянах, урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх, сэргээн засах, хөнгөвчлөх эмчилгээний талаар “Хүний их эмч” бэлтгэх сургалтын нэгдмэл хөтөлбөрөөр эзэмшсэн онолын мэдлэг, эмнэл зүйн ур чадвар, эмнэл зүйн харьцаа хандлагаа бататган дадлагажиж суралцана.

Сургалтын зорилтууд

- Эрүүл мэндийн анхан шатны тусламж, үйлчилгээг зохион байгуулах мэдлэг олгох
- Нийгмийн эрүүл мэндийг зохион байгуулах талаар мэдлэг, чадвар, хандлагатай болгох, нийгэм хамт олонд тулгууралсан эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг зохион байгуулах.
- Хүн амын дунд эрүүл мэндийн боловсрол олгох, хүн амын буруу зан үйлийг өөрчлөх, анхдагч болон хоёрдогч урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах.
- Өрхийн эмчийн зөвлөгөө өгөх ур чадварыг сайжруулах.
- Хүүхдэд өрхийн эмчийн зүгээс үзүүлэх тусламж үйлчилгээ
- Охид эмэгтэйчүүдэд үзүүлэх анхан шатны тусламж үйлчилгээ
- Эрэгтэйчүүдэд үзүүлэх анхан шатны тусламж үйлчилгээ
- Настанд үзүүлэх анхан шатны тусламж үйлчилгээ
- Мэс заслын эмгэгтэй буюу гэмтэлтэй өвчтөнд анхан шатны яаралтай тусламж үйлчилгээ
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст жендерийн мэдрэмжтэйгээр анхан шатны тусламж үйлчилгээг үзүүлэх ба нийгэм –сэтгэцийн нөхөн сэргээх үйл ажиллагааг нийгэм хамт олонд болон гэрийн нөхцөлд удирдан зохион байгуулах.
- Сэтгэцийн анхан шатны тусламж үйлчилгээ .Психосоматик өвчинг эрт илрүүлэх, гэр бүл, нийгэм, хамт олонд суурилсан нөхөн сэргээх үйл ажиллагааг зохион байгуулах
- Хөнгөвчлөх тусламж үйлчилгээний талаар мэдлэг, чадвар, хандлагатай болгох.
- Халдварт өвчний үед өрхийн эмчийн зүгээс анхан шатанд авах арга хэмжээ, халдвар хамгаалалт, хяналт, голомтыг хязгаарлах талаар мэдлэг, чадвар, хандлагатай болгох.
- Архаг өвчний менежментийг хийх.

Хичээлийн агуулга

Хүүхдэд үзүүлэх тусламж үйлчилгээ, менежмент

Мэдлэг

- ХӨЦМ-ийн дагуу 5 хүртлэх насны хүүхдэд анхан шатны тусламж үйлчилгээг цогцоор үзүүлэх.
- Шилжилтийн насны хүүхдүүдэд эрүүл аж төрөх ёсыг хэвшүүлэх, аюулгүй бэлгийн харьцааны талаар сургах, хорт зуршлаас сэргийлэх
- Өсвөр үеийнхийн бие бялдарын хөгжил өсөлтийн хөгжилтөнд байнгын хяналт тавьж өсөлтийн хоцрогдлоос сэргийлэх

Чадвар

- Эрүүл ба өвчтэй хүүхдийг өрхийн эмч хянах, эцэг эхэд зөвлөгөө өгөх, анхан шатны тусламж үзүүлэх.
- Сургуулийн насны хүүхдийн эрүүл мэндийг хянан зохион байгуулах чадвар.
- Гэр бүлийн далд хүчирхийлэлд өртөж буй хүүхдийг илрүүлэх ба хүүхдийг хүчирхийлэлгүй орчинд амьдрах нөхцлийг бүрдүүлэх чадвар.

- Өсвөр үеийн хүүхдүүдийн насны болон сэтгэл зүйн онцлогт тохирсон хэрэгцээнд суурилсан үйлчилгээг явуулах
- Өсвөр үеийнхэнд гэр бүл төлөвлөлт жирэмслэлтээс сэргийлэх аргуудын талаар эрүүд мэндийн боловсрол олгох
- Өсвөр насны хүүхдүүдэд зонхилон тохиолддог өвчин эмгэгийн үед эмчилгээ оношлогооны болон урьдчилан сэргийлэх менежмент хийх чадвар

Хандлага

- Эрүүл ба өвчтэй нярай, хөхүүл, балчир, бага, өсвөр, идэр насны хүүхэдтэй насны онцлогыг харгалзан зөв харьцах хандлагатай болох.
- Эрүүл ба өвчтэй нярай, хөхүүл, балчир, бага, өсвөр, идэр насны хүүхдийн эцэг эхтэй хүүхдийн насны онцлогыг харгалзан зөв харьцах, зөвлөгөө өгөх хандлагатай болох.
- Хүүхдийг нас, хүйс харгалзахгүй, хайрлах, хүндэтгэх, хүчирхийллээс ангид өсгөн хүмүүжүүлэх, өвчин эмгэгээс урьдчилан сэргийлэх, төгс эмчлэн эрүүлжүүлэх хандлагатай болно.
- Өсвөр насны хүүхдэд зонхилон тохиолддог өвчин эмгэгийн үед өрхийн эмчийн эмчилгээ, анхдагч болон хоёрдогч урьдчилан сэргийлэлт, эмнэлгээс гарсны дараа нөхөн сэргээх арга хэмжээ, эцэг, эхэд зөвлөгөө өгөх

Халдварын бус архаг өвчний үед үзүүлэх тусламж үйлчилгээ, менежмент

Мэдлэг

- Халдварын бус архаг өвчний үед(цусны даралт ихсэх өвчин, зүрхний ишеми, шигдээс, ходоод, цөс, 12 хуруу гэдэсний архаг үрэвсэл, ходоод шархлаатах өвчин, бөөр, шээсний замын үрэвслүүд, архаг гепатит, үе, мөчний өвчин, чихрийн шижин, дотоод шүүрлийн эмгэг, г.м.) өрхийн эмчийн зүгээс үзүүлэх анхан шатны тусламж үйлчилгээ, эдгээр өвчнүүдийн үед урьдчилан сэргийлэх, нөхөн сэргээх арга хэмжээ авах.
- Насанд хүрэгчдэд зонхилон тохиолдох хам шинжүүдийг (толгой өвдөх, нуруу өвдөх, хэвлийгээр өвдөх, хоолны дуршил муудах, зүрх дэлсэх, хатгуулах, хэвлийгээр өвдөх г.м) ялган оношлох, өрхийн эмчийн зүгээс үзүүлэх тусламж, үйлчилгээ
- Чийрэгжүүлэх эмчилгээний жорууд мэдэх ба өвчтөнд зааж сургах
- Зонхилон тохиолдох архаг өвчнүүдийн эрсдэлт хүчин зүйлсийг эрт илрүүлж, урьдчилан сэргийлэх, хянах, өөрийн хяналтыг сайжруулахад туслах.

Чадвар

- Эрсдэлт хүчин зүйлсийг эрт илрүүлэх
- Зөвлөгөө өгөх /зан үйл өөрчлөх, сэдэлжүүлэх/
- Анхдагч, хоёрдогч урьдчилан сэргийлэлтийг хийх
- Дүрс оношлогооны болон лабораторийн шинжилгээнд үнэлэлт өгч дүгнэлт хийх
- Нүдний уг харах /Офтальмоскопи ашиглаж сурах/
- Глюкометр хэрэглэх /ашиглаж сурах/
- Эрсдэлийн үнэлгээ
- ЭКГ ашиглах
- Бие бялдарын үзүүлэлтүүд хэмжиж сурах
- Хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох хурлаар оруулах, танилцуулах
- Архаг өвчтэй хүмүүст гэрийн нөхцөлд нөхөн сэргээх үйл ажиллагааг зохион байгуулах чадвар

Хандлага

- Зөвлөгөө өгөх /Хоол хөдөлгөөн, стресс, хорт зуршил/
- Сэтгэл засал хийх
- Зан үйлийг өөрчлөх мотиваци хийх чадвартай болох

- Хянах, давтан үзлэгийг төлөвлөх, үр дүнг тооцох
- Гэр бүл, нийгэм хамт олонд тулгуурлан, тусламж үйлчилгээ сайжруулах
- Хороо даатгалын газартай хамтран ажиллах

Эмэгтэйчүүдэд үзүүлэх тусламж үйлчилгээ, менежмент

Мэдлэг

- Өрхийн эмчээс эрүүл жирэмсэн эмэгтэйг хянах
- Өрхийн эмчээс эрхтэн тогтолцооны эмгэгтэй жирэмсэнг хянах
- Өрхийн эмчээс эх барихын эмгэгтэй жирэмсэн эмэгтэйг хянах
- Нөхөн үржихүйн эрүүл мэнд. Гэр бүл төлөвлөлтийн үндэсний хөтөлбөр
- Бэлгийн замын халдвараас сэргийлэх, өрхийн эмчийн хүрээнд оношлох, эмчлэн эрүүлжүүлэх арга хэмжээ авах
- Цэвэршилтийн насны эмэгтэйчүүдэд өрхийн эмчээс үзүүлэх тусламж үйлчилгээ
- Эмэгтэйчүүдэд зонхилон тохиолддог хавдар, өмөн өвчнийг (хөхний, умайн хүзүүн) эрт илрүүлж, цаг алдалгүй дараагийн шатны мэргэжлийн тусламжинд шилжүүлэх
- Эх барих эмэгтэйчүүдийн яаралтай тусламж шаардагдах өвчин, эмгэгийн үед өрхийн эмчийн оношлогоо, үзүүлэх яаралтай тусламж үйлчилгээ

Чадвар

- Эрүүл ба өртөмтгий жирэмснийг хянах, иж бүрэн үзлэгт хамруулах, эмчлэн эрүүлжүүлэх
- Охидын эрүүл мэндийн талаар сургалт зохион байгуулах, эрүүлжүүлэх
- Цэвэршилтийн насны эмэгтэйчүүдийн эмгэг өөрчлөлтийг урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, зөвлөгөө өгөх, эмчлэн эрүүлжүүлэх.
- Гэр бүл төлөвлөх, жирэмснээс хамгаалах аргыг зөв хэрэглэх.
- Эмэгтэйчүүдэд зонхилон тохиолдох хавдараас сэргийлэх, эрт илрүүлэх, дараагийн шатанд илгээх.
- Эх барих, эмэгтэйчүүдийн яаралтай тусламжийг үзүүлэх.
- Хүчирхийлэлд өртсөн ба хүчиндүүлсэн эмэгтэйчүүдэд нийгэм-сэтгэлзүйн иж бүрэн тусламж үзүүлэх.

Хандлага

- Охид, нөхөн үржихүйн насны ба цэвэршилтийн насны эмэгтэйчүүдийн эрүүл мэндийг хамгаалах, урьдчилан сэргийлэх, эрт илрүүлэх, хянах, эмчлэн эрүүлжүүлэх, нөхөн сэргээх анхан шатны тусламж үйлчилгээг иж бүрэн үзүүлэх хандлагатай болох.

Эрэгтэйчүүдэд үзүүлэх тусламж үйлчилгээ , менежмент

Мэдлэг

- Фимоз, парафимозтой хүүхдийг эрт илрүүлэх, мэргэжлийн шатанд шилжүүлэх
- Эрэгтэйчүүдийн түрүү булчирхай томрох шинжийг эрт илрүүлэх, хүндрэлээс урьдчилан сэргийлэх ба менежмент
- Эрэгтэйчүүдэд зонхилон тохиолдох хавдрыг эрт илрүүлэх ба дараагийн шатанд шилжүүлэх.
- Эрэгтэйчүүдийн бэлгийн сулрал ба үргүйдэл
- Эрэгтэйчүүдийн бэлгийн замын халдвар
- Эрэгтэйчүүдийн цэвэршилт

Чадвар

- Хүүхэд ба насанд хүрсэн эрэгтэйчүүдийн эмгэгүүдийг эрт илрүүлэх, менежмент хийх чадвар

Хандлага

- Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн асуудалд жендэрийн мэдрэмжтэй хандах, хувийн нууцыг хадгалах, зөвлөгөө өгөх харилцаа, хандлагатай байх

Мэс засал, гэмтэл согогтой өвчтөнд үзүүлэх тусламж үйлчилгээ, менежмент

Мэдлэг

- Мэс заслын ба гэмтлийн яаралтай тусламж шаардаж буй өвчтөнг эрт оношлох, зөв тээвэрлэх, анхан шатны тусламж үзүүлэх
- Жижиг мэс ажилбарууд: буглаа нээх, хатиг, мастит, ганц хуруутах, хумс махруу ургах, цээжний хөндийн хатгалт, хэвлийн хөндийн хатгалт, давсганд хатгалт хийх арга барил ба анхан шатны тусламж.
- Ахуйн гэмтлийн үед үзүүлэх анхан шатны тусламж үйлчилгээ / Нохой, бусад гэрийн тэжээмэл амьтанд хазуулах, тогонд цохиулах, угаартах/ үед үзүүлэх анхан шатны тусламж
- Гэмтлийн шок.
- Хөлдөх, түлэгдэх, живэх үед үзүүлэх яаралтай тусламж.
- Түнхний мултрал, дутуу хөгжил, гилжгийг эрт илрүүлэх үзлэг хийх, рентген зураг унших, урьдчилан сэргийлэх.

Чадвар

- Мэс заслын яаралтай тусламж шаардаж буй өвчтөнг эрт оношлох, зөв тээвэрлэх, анхан шатны тусламжийг зөв үзүүлэх
- Түлэгдэлт, хөлдөлтийн үед яаралтай тусламж үзүүлэх
- Гэмтлийн шокын үед яаралтай тусламж үзүүлэх
- Түнхний мултрал, дутуу хөгжил, гилжгийг нярай ба хөхүүл хүүхдэд эрт илрүүлэх, түүнээс сэргийлэх, дараагийн шатанд илгээх чадвартай болох.

Хандлага

- Мэс заслын ба осол гэмтлийн үед яаралтай анхан шатны тусламж үзүүлэх хандлагатай болох.
- Согог гажгийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх хандлагатай болгох.

Халдварт өвчний үед үзүүлэх тусламж үйлчилгээ, менежмент

Мэдлэг

- Манай орны нөхцөлд зонхилон тохиолддог халдварт өвчнүүдийн үед өрхийн эмчээс үзүүлэх тусламж, үйлчилгээ
- Тууралтат халдварт өвчний ялган оношлогоо ба менежмент.
- Сүрьеэгийн зонхилон тохиолдох эмнэл зүйн хэлбэрүүд, тэдгээрийн үед өрхийн эмчээс үзүүлэх тусламж, үйлчилгээ
- Шинээр сэргэж буй халдварт өвчнүүдийн үед үзүүлэх анхан шатны тусламж үйлчилгээ

Чадвар

- Халдварт өвчний голомтын халдвар эсэргүүцэх арга хэмжээг зохион байгуулах
- Халдварт өвчинд өртөх эрсдэлтэй болон эмзэг бүлгийн хүмүүсийг хяналтанд авч үзлэг шинжилгээнд хамруулан эрүүлжүүлэх арга хэмжээ авах
- Бага насны хүүхэд, өндөр настанг тархвар зүйн заалтаар, аж ахуйн нэгж байгууллага иргэдийг сайн дурын үндсэн дээр урьдчилан сэргийлэх тарилгад хамруулах
- Халдвартын эмнэлэг тасагт эмчлүүлээд гарсан өвчтөнд мэргэжлийн эмчийн зөвлөмжийн дагуу эмчилгээг гэрээр үргэлжлүүлэх ба хяналт тавих
- Менингококкт халдварыг оношилж гарааны эмчилгээг эхлэн 3-р шатлалын эмнэлэгт яаралтай тээвэрлэх
- Боом, шувууны ханиад, SARS, шүлхий зэрэг амьтнаас хүнд халддаг буюу шинээр сэргэж буй халдварт өвчний эмнэлзүйн шинж, ялган оношлох, анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлэх, халдвар хамгааллын дэглэм сахих .
- Гоц халдварт өвчний үеийн тусгай хувцсыг өмсөх, тайлах аргыг эзэмших.
- Гоц халдварт өвчний сэжиг бүхий өвчний тохиолдол гарсан үед авах халдвар хамгаалал, хөл хорио тогтоох арга хэмжээ авах

Хандлага

- Аливаа халдварт өвчнөөс хүн ардыг сэргийлэх, эрт илрүүлэх, хянах асуудлыг зохион байгуулах, эмчлэн эрүүлжүүлэх хариуцлага, хандлагатай болгох.

Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ, менежмент

Мэдлэг

- Өвдөлтийн үнэлгээ, ангилал, ДЭМБ-ын зөвлөсөн өвдөлт намдаах эмчилгээний 5 зарчим, 3 шатлалын дагуу эмчлэх
- Хоолонд дургуй болох, турж эцэх, дотор муухайрах, бөөлжих, өтгөн хатах, амьсгаадах, шээс хаагдах, задгайрах, зэрэг шаналгаат шинжүүдийг хөнгөвчлөх
- Хэвтрийн холголт цооролтоос сэргийлэх буюу арьс салстын асаргааг хийх шинж тэмдгийн эмчилгээг зохистой хийх.
- Нас барах үеийн шинжүүд.

Чадвар

- Хөнгөвчлөх эмчилгээний өвчтөнд өвдөлт намдаах эмчилгээг ДЭМБ-ын зөвлөсөн 5 зарчим, 3 шатлалын дагуу хийх
- Амьдралын төгсгөлийн шатанд буй өвчтөний үхлийн айдас, сэтгэл гутрал, нойргүйдэл зэрэг сэтгэл санааны хямралыг илрүүлэх ба хөнгөвчлөх эмийн ба эмийн бус эмчилгээний арга хэмжээ авах
- Илаарших боломжгүй, тавилан хязгаарлагдмал өвчтөнд хоолонд дургуй болох, турж эцэх, дотор муухайрах, бөөлжих, өтгөн хатах, шээс хаагдах, задгайрах, амьсгаадах, ханиалгах шинжийг хөнгөвчлөх ба хэвтрийн өвчтөнийг асрах, эмийн ба эмийн бус эмчилгээний аргыг хэрэгжүүлэх

Хандлага

- Амьдралын төгсгөлийн шатанд буй өвчтөнийг хайрлах, хүндэтгэх, эдлэх ёстой эрхийг нь эдлүүлэхийг эрмэлзэх хандлагатай болно. Өвчтөнийн гэр бүлийнхний шантарсан, туйлдсан, гутарсан хандлагыг өөрчлөх чадвартай болно.
- Амьдралын төгсгөлийн шатанд буй өвчтөний амьдралын чанарыг дээшлүүлэхэд орчин үеийн эмчилгээ, асаргааны хэрэгсэл хэрэгтэй болохыг мэдрэх, түүнийг ашиглаж сурахыг эрмэлзэх хандлагатай болно.
- Амьдралын төгсгөлийн шатанд буй өвчтөн, түүний ар гэрт бүхий л талаас нь туслах хүсэл эрмэлзэл, энэрэнгүй, хүмүүнлэг үзэл бодол, хандлагатай болно.

Сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээ, менежмент

Мэдлэг

- Сэтгэцийн тулгамдсан асуудалтай өвчтөнд үзүүлэх анхан шатны тусламж үйлчилгээ
- Стресс менежмент.
- Психосоматик анагаах ухаан. Психосоматик өвчнийг эрт илрүүлэх ба эмчлэх эрүүлжүүлэх.
- Тахир дутуу болсон өвчтөнд нийгэм-сэтгэцийн дэмжлэгийг өрхийн эмчийн зүгээс үзүүлэх, удирдан зохион байгуулах
- Амьдралын төгсгөлийн шатанд буй эмчилгээгүй болсон өвчтөн ба түүний гэр бүлийн сэтгэл санааны талаас гарч буй хямрал ба өрхийн эмчийн зүгээс үзүүлэх сэтгэл заслын эмчилгээ
- Гэр бүлийн гишүүдэд жендерийн тэгш эрхийг төлөвшүүлэх ба гэр бүлийн хүчирхийллээс сэргийлэх.
- Архичин ба архидалтай тэмцэх.
- Оюуны хомсдолыг эрт илрүүлэх арга барилд суралцах, IQ зэрэглэл.

Чадвар

- Сэтгэцийн тулгамдсан асуудалтай өвчтөнийг илрүүлэх, нөхөн сэргээх, эмийн ба эмийн бус аргаар эмчлэх.
- Бухимдлыг тайлах ур чадвар эзэмших.
- Психосоматик өвчнийг эрт илрүүлэх ба эмчлэх эрүүлжүүлэх.

- Шилжилтийн насны хүүхдэд сэтгэлзүйн тусламж үзүүлэх.
- Архидалттай тэмцэх, архи хэтрүүлэн хэрэглэгчийг эрт илрүүлэх, архи хэрэглэгчийн гэр бүлийнхэнд үзүүлэх нийгэм сэтгэлзүйн тусламж үйлчилгээ
- Оюуны хомсдолтой хүүхдэд ба гэр бүлд нийгэм-сэтгэлзүйн тусламж үйлчилгээг үе шаттай үзүүлэх.
- Хүчиндүүлсэн эмэгтэйд сэтгэлзүйн тусламж үйлчилгээ үзүүлэх.
- Настан, тахир дутуу ба илаарших боломжгүй хүнд өвчтөнд сэтгэлзүйн тусламж үйлчилгээг жендерийн мэдрэмжтэйгээр үзүүлэх.

Хандлага

- Хүн амын дунд нас, хүйс, нийгмийн байдлыг харгалзан жендерийн мэдрэмжтэйгээр сэтгэцийн эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг зохион байгуулах, сэтгэцийн эрүүл мэндийн боловсрол олгох, зонхилон тохиолдох сэтгэцийн өвчнөөс сэргийлэх ба эмчлэн илааршуулах хандлагатай болгох.

Настны эрүүл мэнд, настанд үзүүлэх тусламж үйлчилгээ, менежмент

Мэдлэг

- Эрүүл урт удаан наслах увидас
- Настанд зонхилон тохиолддог өвчин эмгэгийн талаар мэдэх:
- Сэтгэл гутрал
- Түрүү булчирхай томрох
- Шээс задгайрах
- Цэвэршилтийн үеийн хямрал
- Настны чихрийн шижин
- Настны даралт ихсэх эмгэг
- Настны остеохондроз өвчнөөс сэргийлэх, эмчлэх, нөхөн сэргээх
- Настны титэм судасны хомсдол
- Настны тархины цусан хангамжийг цочмог ба архаг хомсдол
- Яс сийрэгжиж өвдөх шижинтэх г.м үед өрхийн эмчийн зүгээс зөв хандаж, зохих туслалцааг үзүүлэх
- Настны аюулгүй хөдөлгөөний дэглэм, орчин, хооллолт, чийрэгжүүлэлт, гоо сайхнаа хамгаалах талаар өрхийн эмчээс өгөх зөвлөмж
- Настанд нийгэм-сэтгэцийн талаас үзүүлэх тусламж үйлчилгээнд өрхийн эмчийн үүрэг роль
- Настанд эмийн эмчилгээ хийх онцлог, эмийн тунг настны архаг өвчин, эрхтэн тогтолцооны архаг дутмагшлын байдлыг харгалзан тохируулах
- Настанд үзүүлэх тусламж үйлчилгээний талаарх хууль тогтоомж захирамж тогтоолуудтай танилцаж хэрэгжүүлэх
- Настны эрүүл мэндийн талаар настны олон нийтийн байгууллага засаг захиргааны нэгжүүдтэй хамтарн ажиллах талаар суралцах

Чадвар

- Настны аюулгүй хөдөлгөөний дэглэм, орчин, хооллолт, чийрэгжүүлэлт, гоо сайхнаа хамгаалах, эрүүл, урт удаан наслах талаар өрхийн эмчээс зөвлөгөө өгөх
- Настанд нийгэм-сэтгэцийн талаас тусламж үйлчилгээ үзүүлэх
- Настанд эмийн эмчилгээ хийх онцлог, эмийн тунг настны архаг өвчин, эрхтэн тогтолцооны архаг дутмагшлын байдлыг харгалзан тохируулах
- Настанд зонхилон тохиолдох өвчин эмгэгийн үед менежмент хийх чадвар

Хандлага

- Хүн ардын дунд эрүүл урт удаан наслах талаар байнга сургах, зөвлөх, мотивац хийх
- Настангийн эрхийг хамгаалах үүднээс түүнд зонхилон илрэх өвчин, эмгэгийг эрүүлжүүлэх, нөхөн сэргээх, хөнгөвчлөх хандлагыг баримтлах
- Өрхийн харьяа хүн ардын дунд настангийн хүчирхийлэлтэй тэмцэх, тэдгээрт үзүүлэх нийгэм-сэтгэлзүйн тусламж үйлчилгээг зохион байгуулах

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст үзүүлэх тусламж үйлчилгээ, менежмент

Мэдлэг

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нийгэм сэтгэлзүйн талаас үзүүлэх тусламж үйлчилгээг зохион байгуулах
- Хөдөлмөрийн чадвар алдалтыг тогтоох
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст нийгэм хамт олонд тулгуурласан тусламж үйлчилгээг үзүүлэх

Чадвар

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст жендерийн мэдрэмжтэйгээр нийгэм сэтгэлзүйн талаас үзүүлэх тусламж үйлчилгээг зохион байгуулах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг гэр бүл ба нийгмийн хүчирхийллээс хамгаалах
- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүст ажлын байр олоход туслах

Хандлага

- Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийг хүн ёсоор хүндэтгэх, гэр бүл, нийгмийн хүчирхийллээс ангид орчинд, амьдрах, ажиллах орчныг бүрдүүлэх үйл ажиллагааг төрийн ба төрийн бус байгууллагуудтай хамтран зохион байгуулах хандлагатай болгох.

Бие даалт

Аудиовизуаль бичлэг: Дадлагажигч оюутан нь өрхийн эрүүл мэндийн төв дээр өвчтөн үзэж, тодорхой сэдвээр видео бичлэг хийсэн байна. Семинарын хичээлийн үед видео бичлэгийг хамтарч үзээд тухайн өвчтөнд асуумжийг хэрхэн авсан, үзлэг хэрхэн хийсэн, оношийг яаж тавьсан, эмчилгээг хэрхэн хийсэн, зөвлөгөөг яаж өгсөн, жор яаж бичсэн, давтан үзлэг товлот, нарийн мэргэжлийн эмч нарт явуулсан эсэх зэрэг өрхийн эмчийн үйлчлүүлэгчид тулгамдаж буй асуудлыг цогцоор шийдвэрлэсэн байдлыг ярилцаж, асуудлыг шийдвэрлэн, үнэлгээ авна.

ИСААТ сорил: компьютерт суурилсан ХӨЦМ-ийн (ICAAT) хичээлийн эмнэлзүйн тохиолдол дээр ажиллаж, 100% гүйцэтгэнэ.

Уншиж судлах ном, гарын авлага

1. Мури Лонморе, Ян Б. Вилкисон, Сапраж Р. Ражагопалан “Эмнэлзүйн анагаах ухааны Оксфордын гарын авлага” 2007.
2. “The learning and teaching guide” EURACT, Royal College of General Practitioners, 2008.
3. Heidi –Ingrid Maaros, “Family medicine. Basic course, residency and doctorate” University of Tartu, Dept. of Family Medicine, 2000.
4. Оргил Б. Өрхийн эмчийн эмнэл зүйн давтан сургалтын материал. 1-3-р боть. УБ., 2000, 2002 он
5. Б. Оргил “Өрхийн анагаах ухаан” УБ, 2009
6. Д. Одонтуяа “Өрхийн эмчийн үйл ажиллагааны менежмент ба зөвлөмжүүд” 2010.
7. ДЭМБ-ын удирдамж, хүснэгтэн товхимол. ХӨЦМ УБ, 2001
8. Д. Одонтуяа “Өвчтөн асарч буй хүнд зориулсан гарын авлага” УБ, 2007
9. “Асрамжлагч сайн дурынхны гарын авлага” УБ, 2009.
10. Нинжээ Д. “Сумын эмнэлэгт үзүүлэх мэс-засал гэмтлийн анхны тусламж” УБ, 2000.
11. Солонго “Уушгины өвөрмөц өвчний оношлогоо эмчилгээний стандарт”. УБ 2000 он
12. Ж.Сэржээ “Зонхилон тохиолдох зүрх судасны өвчний эмчилгээ оношлогооны үндсэн баримтлал”. УБ 2000 он
13. Одонтуяа Д. Нарангэрэл Г. “Хүүхдэд үзүүлэх өрхийн эмчийн тусламж үйлчилгээ”. УБ., 2000

14. Д. Одонтуяа, Д. Дүнгэрдорж, ба бусад /С. Бямбасүрэн, Д. Цэрэндагва, Ш. Оюунхүү, Ш. Сүхбаатар, Д. Мягмарцэрэн, Ш. Тамир, С. Сэвжид, Д. Жаргалсайхан, Л.. Мягмар “Хөнгөвчлөх эмчилгээ” УБ, 2002.
15. Одонтуяа Д. “Зонхилон тохиолддог өмөнгөөс сэргийлэх, түүнийг хянах тухай гарын авлага” УБ, 2002.
16. Д. Одонтуяа, Б. Оргил, ба бусад “Хөнгөвчлөх тусламж үйлчилгээ” УБ, 2003.
17. Д. Одонтуяа ба бусад “Хөнгөвчлөх анагаах ухаан” УБ, 2005.
18. Одонтуяа Д. “Гэр бүлийн хүчирхийлэл” УБ, 2001
19. Одонтуяа Д. “Нийгэм сэтгэл зүйн эмчилгээний хөтөлбөр” УБ, 2001
20. Пүрэвсүх С. Одонтуяа Д. Сүхбаатар Ш. Оюунхүү Ш. Нарангэрэл Г. Мягмарцэрэн Д. “Өрхийн эмчийн цуврал лекцүүд-1” УБ, 2003
21. Шижирбаатар Б. “Эх барих” УБ., 2001
22. Эрдэнэчимэг Б. “Амьдралын төгсгөлийн шатны хам шинжүүдийг хөнгөвчлөх” УБ, 2000.
23. Лури Лонморе, Ян Б. Вилкинсон. “Эмнэлзүйн анагаах ухааны Оксфордын гарын авлага”
24. Теодоре Х., Тулчински, Елена А. Ваварикова “Шинэ нийгмийн эрүүл мэнд ” 21-р зууны удиртгал, УБ, 2005.
25. “Сэтгэцийн өвчнүүд” С. Бямбасүрэн УБ, 2008.
26. Г. Цагаанхүү “Мэдрэлийн өвчнүүд”, УБ, 2008.
27. “Өсвөр үеийн эрүүл мэнд , хөгжлийн асуудлаар чиг баримжаа олгох хөтөлбөр” УБ, 2004.

8. ХҮҮХДИЙН АНАГААХ УХААН

ХҮҮХДИЙН ДОТРЫН ӨВЧИН СУДЛАЛ

Хичээлийн зорилго

Монгол оронд зонхилон тохиолддог хүүхдийн эмгэгүүдийг ерөнхий мэргэжлийн эмчийн түвшинд оношлох, эмчлэх, хянах, зөвлөгөө өгөх, тусламж үйлчилгээ үзүүлэх, урьдчилан сэргийлэхэд шаардлагатай онолын мэдлэг, чадвар эзэмшүүлж, хандлага төлөвшүүлнэ.

Хичээлийн агуулга

Манай оронд зонхилон тохиолддог хүүхдийн эмгэгүүдийг оношлох, эмчлэх, тусламж үйлчилгээ үзүүлэх, хүүхдийн өсөлт хөгжилт, хооллолтын байдлыг үнэлэх, өрх болон сумын эмчийн түвшинд мөрдөгдөх тушаал шийдвэр, заавруудыг мэдэх, анхан шатны бичиг баримтыг хөтлөх, хүүхдийн амь тэнссэн төлөв байдалд анхан шатны яаралтай тусламж үзүүлж дараагийн шатлалын тусламжийн эмнэлэгт хүргэх, эрүүл ба өвчтэй хүүхдэд аливаа өвчнөөс сэргийлэх, зөв хооллох, эрүүл ахуйн зөв дэглэмд сургах талаар зөвлөгөө өгөх, эрүүл мэндийн хяналт тогтоох.

Сургалтын орчин

А. АШУҮИС-ийн Анагаах Ухааны Сургуулийн Хүүхдийн Анагаахын Тэнхим

Б. АШУҮИС-ийн түшиц эмнэлэг:

- Нийслэлийн дүүргийн нэгдсэн эмнэлгийн хүүхдийн тасгууд
- ЭХЭМҮТөвийн
 - Сэхээн амьдруулах-эрчимт эмчилгээний тасаг
 - Бөөр-булчирхай эмгэг судлалын тасаг
 - Зүрх, үе мөч-холбогч эдийн эмгэг судлалын тасаг
 - Ходоод-гэдэс, хоол боловсруулах эрхтэний эмгэг судлалын тасаг
 - Цус, цус бүтээх эрхтэний эмгэг судлалын тасаг

УУШГИ СУДЛАЛ

Хүүхдийн амьсгалын эрхтэн-тогтолцооны бүтэц-үйлийн онцлог, эмнэлзүйн ач холбогдол, хүүхдийн амьсгалын цочмог халдварын эмнэлзүйн онцлог, түүнийг зөв оношлох, эмчлэх мэдлэг чадвар эзэмшүүлэх зорилготой.

Эзэмшвэл зохих мэдлэг

- Хүүхдийн АЭТ-ны бүтэц-үйлийн онцлог, эмнэлзүйн ач холбогдол, судлах шинжлэх аргууд;
- Зонхилон тохиолдох эмгэгүүдийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйл, эмнэлзүйн шинж, эмчилгээ оношлогооны зарчим;
- АЦХ-ыг оношлох, эмчлэхэд шаардагдах багажийн болон лабораторийн шинжилгээнүүдийн үзүүлэлт, өөрчлөлт;
- Өвчтэй хүүхэд болон эцэг эхэд нь АЦХ-аас сэргийлэх, эмчилгээний талаар зөвлөгөө өгөх;

Эзэмшвэл зохих чадвар

- АЭТ-ны өвчтэй хүүхдийн өвчний түүхтэй танилцах, хэрхэн бичих талаар суралцах;
- Асуумжийн аргаар дээрх өвчнүүдийн үед хүүхдэд илрэх зовиур шаналгааг тогтоох, шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлийг илрүүлэх, оношийн үндэслэлд тусгах;

- Харж ажиглах аргаар биеийн ерөнхий байдал, арьс салстын байдал, өнгө, амьсгалын хэлбэр, амьсгалын тоо олшрох, хяхатнаа амьсгал, цээж хонхолзож байгаа эсэхийг үнэлэх;
- Цээжний уян чанар, дууны доргио, булчингийн өвдөлт байгаа эсэхийг тэмтрэх аргаар тодорхойлох;
- Чагнах аргаар тодорхойлогдох хүүхдийн уушгины эрүүл, эмгэг шуугиан, Пуэрил амьсгалын амьсгалын онцлогийг мэдэх эмгэгийг илрүүлэх;
- Асуумж, бодит үзлэг, шинжилгээнд тулгуурлан эмнэлзүйн урьдчилсан онош тавих;
- Шаардлагатай багажийн болон лабораторийн шинжилгээнүүдийн үзүүлэлт, өөрчлөлтөнд дүгнэлт хийх;
- Өвчтэй хүүхдийг асарч сувилах;
- Хүүхдийн хамар цэвэрлэх;
- Хамраар хүчилтөрөгч өгөх;
- Хэрэглэгдэж буй эм бэлдмэлийн эмийн үйлчлэл, хэрэглэх заалт, тун хэмжээ, гаж нөлөөг мэддэг байх;
- Судас, булчин тариа хийх;
- Эмнэлзүйн тохиолдолд тохирсон эмчилгээ, шинжилгээ төлөвлөн хүүхэд болон эцэг эхэд зөв тайлбарлан ойлгуулах;
- Өвчний байдал, нөлөөлөх хүчин зүйлээс сэргийлэх талаар зөвлөгөө өгөх;

Эзэмшвэл зохих хандлага

- Өвчтэй хүүхдүүд болон тэднийг асран харгалзагч нарыг хүндэтгэн хүнлэг харилцах;
- Тухайн тасгийн эмч эмнэлгийн ажилчидтай эвсэг, баг болон ажиллах;
- Эмчийн мэргэжлийн ёсзүйн хэм хэмжээг дагаж мөрдөж сурах;
- Өвчтэй хүүхэд ба түүний эцэг эх, асран хамгаалагчид итгэл, үнэмшил төрүүлэх;

ЗҮРХ СУДАС, ҮЕ СУДЛАЛ

Ерөнхий мэргэжлийн эмч бэлтгэх дипломын шатны сургалтанд хүүхдийн зүрх-судас, холбогч эдийн зонхилон тохиолдох эмгэгийн шалтгаан эмнэлзүй, оношлогоо, эмчилгээний талаар мэдлэг, чадвар олгож, мэргэжлийн хандлагыг зохих түвшинд төлөвшүүлэх зорилготой.

Эзэмшвэл зохих мэдлэг

- Хүүхдийн зүрх-судасны эрхтэн-тогтолцооны бүтэц-үйлийн онцлог, судлах шинжлэх аргууд;
- Хүүхдийн зүрхний төрөлхийн гажиг, хэрлэг, хэрлэг төст холбогч эдийн эмгэгүүдийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйл, эмнэлзүйн шинж, эмчилгээ оношлогооны зарчим;
- Хүүхдийн зүрх-судасны эрхтэн-тогтолцооны эмгэгүүдийг илрүүлэх, нотлоход шаардагдах багажийн болон лабораторийн шинжилгээнүүдийн үзүүлэлт, өөрчлөлт;
- Өвчтэй хүүхэд болон эцэг эхэд нь тухайн өвчнөөс сэргийлэх, эмчилгээний дэглэм сахих, хяналтын талаар зөвлөгөө өгөх;

Эзэмшвэл зохих чадвар

- Зүрх, үе мөч, холбогч эдийн өвчтэй хүүхдийн өвчний түүхтэй танилцах, хэрхэн бичих талаар суралцах;
- Өвчтэй хүүхэд болон асран хамгаалагчаас асуумжын аргаар шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлийг илрүүлэх, оношийн үндэслэлд тусгах;
- Харах, тэмтрэх, тогших, чагнах аргаар хэсэгчилсэн үзлэг хийн зүрхний хил хязгаар, зүрхний авиа өөрчлөлтэй эсэхийг тодорхойлох;
- Асуумж, бодит үзлэг, шинжилгээнд тулгуурлан эмнэлзүйн урьдчилсан онош тавих;
- Оношийг нотлоход шаардагдах багажийн болон лабораторийн шинжилгээнүүдийн үзүүлэлт, өөрчлөлтөнд дүгнэлт хийх;
- Өвчтэй хүүхдийг асарч сувилах;

- Пенициллин-Г хийх заалт, тариаг найруулах, тун хэмжээг тодорхойлох, тарих аргад суралцах;
- Зүрхний цахилгаан бичлэг хийх, өөрчлөлтийг дүгнэх;
- Рентген зургаар ЗЦИ тодорхойлох;
- Хэрэглэгдэж буй эм бэлдмэлийн эмийн үйлчлэл, хэрэглэх заалт, тун хэмжээ, гаж нөлөөг мэддэг байх;
- Судас, булчин тариа хийх;
- Эмнэлзүйн тохиолдолд тохирсон эмчилгээ, шинжилгээ төлөвлөн хүүхэд болон эцэг эхэд зөв тайлбарлан ойлгуулах;
- Өвчний байдал, нөлөөлөх хүчин зүйлээс сэргийлэх талаар зөвлөгөө өгөх;
- Эмч нарын өглөөний яриа, тасгийн яриа, эмгэг анатомийн хуралд оролцох.

Эзэмшвэл зохих хандлага

- Зүрх, үе мөч, холбогч эдийн эмгэгтэй янз бүрийн нас, хүйсийн хүүхдүүд болон тэднийг асран харгалзагч нарын сэтгэл санааг ойлгон чин сэтгэлээсээ хүндэтгэн хүнлэг харилцах;
- Тухайн тасгийн эмч эмнэлгийн ажилчидтай эвсэг, баг болон ажиллах;

ХООЛ БОЛОВСРУУЛАХ ЭРХТЭН СУДЛАЛ

Ерөнхий мэргэжлийн эмчийн түвшинд хүүхдийн ХБЭ-ний бүтэц үйлийн онцлог, зонхилон тохиолдох эмгэгүүдэд зохих шатны тусламж үзүүлэх мэдлэг, бага насны хүүхдийн хооллолтын талаар зөвлөгөө өгөх чадвар эзэмшүүлэх зорилготой.

Эзэмшвэл зохих мэдлэг

- Хүүхдийн ХГЗ-ын бүтэц-үйлийн онцлог, судлах шинжлэх аргууд;
- ХГЗ-ын зонхилон тохиолдох эмгэгүүдийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйл, эмнэлзүйн шинж, эмчилгээ оношлогооны зарчим;
- ХГЗ-ын эмгэгүүдийг илрүүлэх, нотлоход шаардагдах багажийн болон лабораторийн шинжилгээнүүдийн үзүүлэлт, өөрчлөлт;
- Өвчтэй хүүхэд болон эцэг эхэд нь тухайн өвчнөөс сэргийлэх, эмчилгээний дэглэм сахиx, хяналтын талаар зөвлөгөө өгөх;

Эзэмшвэл зохих чадвар

- ХГЗ-ын өвчтэй хүүхдийн өвчний түүхтэй танилцах, хэрхэн бичих талаар суралцах;
- Өвчтэй хүүхэд болон асран хамгаалагчаас асуумжийн аргаар шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлийг илрүүлэх, оношийн үндэслэлд тусгах;
- Харах, тэмтрэх, тогших, чагнах аргаар хэвлийн эмзэглэл, элэг, дэлүүний хэмжээ, цөс, нойр булчирхайн өвдөлтийн цэгийг тодорхойлж сурах;
- Асуумж, бодит үзлэг, шинжилгээнд тулгуурлан эмнэлзүйн урьдчилсан онош тавих;
- Оношийг нотлоход шаардагдах багажийн болон лабораторийн шинжилгээнүүдийн үзүүлэлт, өөрчлөлтөнд дүгнэлт хийх;
- Өвчтэй хүүхдийг асарч сувилах;
- Ходоод угаах;
- Цэвэрлэх болон эмчилгээний бургуй тавих;
- Дурангийн шинжилгээнд өвчтөнг бэлтгэх;
- Цөс угаах;
- ШСД найруулах, амаар шингэн сэлбэх;
- Эрүүл болон өвчтэй хүүхдэд хоололтын талаар зөвлөгөө өгөх;
- Хэрэглэгдэж буй эм бэлдмэлийн эмийн үйлчлэл, хэрэглэх заалт, тун хэмжээ, гаж нөлөөг мэддэг байх;
- Судас, булчин тариа хийх;

- Эмнэлзүйн тохиолдолд тохирсон эмчилгээ, шинжилгээ төлөвлөн хүүхэд болон эцэг эхэд зөв тайлбарлан ойлгуулах;
- Өвчний байдал, нөлөөлөх хүчин зүйлээс сэргийлэх талаар зөвлөгөө өгөх;
- Эмч нарын өглөөний яриа, тасгийн яриа, эмгэг анатомийн хуралд оролцох;

Эзэмшвэл зохих хандлага

- ХГЗ-ын эмгэгтэй хүүхдүүд болон тэднийг асран харгалзагч нарыг хүндэтгэн хүнлэг харилцах;
- Тухайн тасгийн эмч эмнэлгийн ажилчидтай эвсэг, баг болон ажиллах;
- Эмчийн мэргэжлийн ёсзүйн хэм хэмжээг дагаж мөрдөж сурах;

ЦУС СУДЛАЛ

Хүүхдийн цусны эрхтэн-тогтолцооны бүтэц-үйлийн онцлог, эмнэлзүйн ач холбогдол, хүүхдийн цусны өвчний явц, онцлог байдал хийгээд түүнийг зөв оношлох, эмчлэх мэдлэг, чадвар, хандлагыг эзэмшүүлнэ.

Эзэмшвэл зохих мэдлэг

- Хүүхдийн цус, цус бүтээх эрхтэн-тогтолцооны бүтэц-үйлийн онцлог, эмнэлзүйн ач холбогдол, судлах шинжлэх аргууд;
- Зонхилон тохиолдох эмгэгүүдийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйл, эмнэлзүйн шинж, эмчилгээ-оношлогооны зарчим;
- Хүүхдийн цусны эмгэгүүдийг илрүүлэх, нотлоход шаардагдах багажийн болон лабораторийн шинжилгээнүүдийн үзүүлэлт, өөрчлөлт;
- Өвчтэй хүүхэд болон эцэг эхэд нь тухайн өвчнөөс сэргийлэх, эмчилгээний дэглэм сахих, хяналтын талаар зөвлөгөө өгөх;

Эзэмшвэл зохих чадвар

- Цусны өвчтэй хүүхдийн өвчний түүхтэй танилцах, хэрхэн бичих талаар суралцах;
- Өвчтэй хүүхэд болон асран хамгаалагчаас асуумжын аргаар шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлийг илрүүлэх, оношийн үндэслэлд тусгах;
- Харах, тэмтрэх, тогших, аргаар хэвлийн эмзэглэл, дэлүүний хэмжээ, арьсан дээрх цусархаг тууралт, толбыг тодорхойлж сурах;
- Асуумж, бодит үзлэг, шинжилгээнд тулгуурлан эмнэлзүйн урьдчилсан онош тавих;
- Оношийг нотлоход шаардагдах багажийн болон лабораторийн шинжилгээнүүдийн үзүүлэлт, өөрчлөлтөнд дүгнэлт хийх;
- Өвчтэй хүүхдийг асарч сувилах;
- Хамраас цус гоожих үед арга хэмжээ авах;
- Шинжилгээнд өвчтөнг бэлтгэх;
- Хэрэглэгдэж буй эм бэлдмэлийн эмийн үйлчлэл, хэрэглэх заалт, тун хэмжээ, гаж нөлөөг мэддэг байх;
- Судас, булчин тариа хийх;
- Эмнэлзүйн тохиолдолд тохирсон эмчилгээ, шинжилгээ төлөвлөн хүүхэд болон эцэг эхэд зөв тайлбарлан ойлгуулах;
- Өвчний байдал, нөлөөлөх хүчин зүйлээс сэргийлэх талаар зөвлөгөө өгөх;
- Эмч нарын өглөөний яриа, тасгийн яриа, эмгэг анатомийн хуралд оролцох;

Эзэмшвэл зохих хандлага

- Цусны эмгэгтэй хүүхдүүд болон тэднийг асран харгалзагч нарыг хүндэтгэн хүнлэг харилцах;
- Тухайн тасгийн эмч эмнэлгийн ажилчидтай эвсэг, баг болон ажиллах;
- Эмчийн мэргэжлийн ёсзүйн хэм хэмжээг дагаж мөрдөж сурах;

БӨӨР СУДЛАЛ

Хүүхдийн шээс ялгаруулах эрхтэн, зүрх судас үе судлал, дотоод шүүрэл, амьсгалын тогтолцоо, цус судлалын эрхтэн -тогтолцооны онцлог, судлах шинжлэх арга, цочмог болон архаг үрэвслийн шалтгаан, эмнэлзүйн онцлогыг оношлох, тухайн тохиолдолд тохирсон эмчилгээ, шинжилгээ төлөвлөх, урьдчилан сэргийлэх, зөвлөгөө өгөх мэдлэг, чадвар эзэмшүүлэх, өвчтэй хүүхэд түүний эцэг эх, эмнэлгийн эмч, ажилчидтай эмчийн ёсзүйн хүрээнд зөв хандах хандлагыг оюутнуудад төлөвшүүлэх зорилготой.

Эзэмшвэл зохих мэдлэг

- Хүүхдийн шээс ялгаруулах эрхтэн-тогтолцооны бүтэц-үйлийн онцлог, судлах шинжлэх аргууд;
- Хүүхдийн шээс ялгаруулах эрхтэн-тогтолцооны эмгэгүүдийн шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлүүд, илрэх эмнэлзүйн шинжүүдийн онцлог;
- Тухайн эрхтэн-тогтолцооны эмгэгүүдийг илрүүлэх, нотлоход шаардагдах багажийн болон лабораторийн шинжилгээнүүдийн үзүүлэлт, өөрчлөлт;
- Өвчтэй хүүхэд болон эцэг эхэд нь тухайн өвчнөөс сэргийлэх, эмчилгээний дэглэм сахих, хяналтын талаар зөвлөгөө өгөх;

Эзэмшвэл зохих чадвар

- Бөөр болон шээс ялгаруулах эрхтэн-тогтолцооны өвчтэй хүүхдийн өвчний түүхтэй танилцах, хэрхэн бичих талаар суралцах;
- Өвчтэй хүүхэд тэдний асран хамгаалагч , эцэг эхээс асуумж, өгүүлэл цуглуулан шалтгаан нөлөөлсөн хүчин зүйл, өвчний байлыг тодорхойлох, дүгнэлт хийх, оношийн үндэслэлд тусгах;
- Хүүхдийн шээс ялгаруулах эрхтэн-тогтолцооны хэсэгчилсэн үзлэгийг харах, тэмтрэх, тогших аргаар хийн эмнэлзүйн эмгэг шинжүүдийг илрүүлэх;
- Эмнэлзүйн урьдчилсан онош тавих, үндэслэл бичих;
- Ялган оношлох өвчнүүдийг жагсаан нотлох шинжилгээ төлөвлөх, шинжилгээнд хэрхэн бэлтгэх талаар зөвлөх;
- Эмнэлзүйн тохиолдолд тохирсон эмчилгээ төлөвлөн динамик ажиглалт хийх;
- Бөөрний эмгэгтэй хүүхдийг судлах лабораторийн болон багажийн шинжилгээний аргыг мэдэх (шээс, биохими, захын цус, рентген, хэт авиан шинжилгээнд гарах өөрчлөлтүүдийг мэдэх, дүгнэлт хийх);
- Өвчтэй хүүхдийг асарч сувилах;
- Судас, булчин тариа хийх;
- Шинжилгээнд бэлтгэх;
- Давсганд гуурс тавих;
- Төлөвлөсөн шинжилгээ, эмчилгээний талаар хүүхэд болон эцэг эхэд тайлбарлах;
- Хэрэглэгдэх эм, тарианы онцлог тун хэмжээг мэдэх;
- Эмч нарын өглөөний яриа, тасгийн яриа , эмгэг анатомийн хуралд оролцох;
- Эмийн болон хоол эмчилгээ, эмчилгээний дэглэм сахих, хийгдэх шинжилгээ, урьдчилан сэргийлэх, хяналтын талаар хүүхэд түүний эцэг эхэд зөвлөх;

Эзэмшвэл зохих хандлага

- Шээс ялгаруулах эрхтэн-тогтолцооны эмгэгтэй янз бүрийн нас, хүйстэй хүүхдүүд болон тэднийг асран харгалзагч нарыг хүндэтгэн зөв харьцаж, хэрэгцээтэй мэдээллээ авах;
- Зөв үйлийг дэмжин урамшуулж, эдгэрэх итгэлийг төрүүлэх;
- Тухайн тасгийн эмч, эмнэлгийн ажилчидтай эвсэг, баг болон ажиллах;

СЭХЭЭН АМЬДРУУЛАХ - ЭРЧИМТ ЭМЧИЛГЭЭ

Хүүхдэд үзүүлэх яаралтай тусламж, амь тэнссэн төлөв байдал, олон эрхтний дутмагшлын шалтгаан эмнэлзүй, оношлогоо, эмчилгээний талаар мэдлэг, чадвар олгож, мэргэжлийн хандлагыг зохих түвшинд төлөвшүүлэх зорилготой.

Эзэмшвэл зохих мэдлэг

- Хүүхдэд үзүүлэх яаралтай тусламжийн ерөнхий зарчим;
- Амь тэнссэн төлөв байдал, олон эрхтний дутмагшлын шалтгаан, нөлөөлөх хүчин зүйл, эмнэлзүйн шинж, эмчилгээ оношлогооны зарчим;
- Шаардлагатай багажийн болон лабораторийн шинжилгээнүүдийн үзүүлэлт, өөрчлөлт;
- Өвчтэй хүүхэд болон эцэг эхэд нь биеийн байдал, өвчний явц, шаардлагатай авах арга хэмжээ, эмчилгээний үр дүнгийн талаар тайлбарлах, зөвлөгөө өгөх;

Эзэмшвэл зохих чадвар

- Хүнд өвчтэй хүүхдийн өвчний түүхтэй танилцах, хэрхэн бичих талаар суралцах;
- Өвчтэй хүүхэд болон асран хамгаалагчаас асуумжийн аргаар шалтгаан, нөлөөлсөн хүчин зүйлийг илрүүлэх, оношийн үндэслэлд тусгах;
- Харах, тэмтрэх, тогших, чагнах аргаар эмнэлзүйн эмгэг шинжүүдийг үнэлэх;
- Асуумж, бодит үзлэг, шинжилгээнд тулгуурлан эмнэлзүйн урьдчилсан онош тавих;
- Оношийг нотлоход шаардагдах багажийн болон лабораторийн шинжилгээнүүдийн үзүүлэлт, өөрчлөлтөнд дүгнэлт хийх;
- Өвчтэй хүүхдийг асарч сувилах;
- Амьсгалын замыг цэвэрлэх, хамар залгиурыг отсосоор угаах;
- Хүчилтөрөгч хамраар өгөх;
- Зүрхний үйл ажиллагааг кардиомонитроор хянах, өөрчлөлтийг дүгнэх;
- Хураагуур судсанд флексур тавих;
- Ходоод угаах;
- Зондоор хооллох;
- Гэдэсний дүүрэнгэ арилгах;
- Цэвэрлэх болон эмчилгээний бургуй тавих;
- Хэрэглэгдэж буй эм бэлдмэлийн эмийн үйлчлэл, хэрэглэх заалт, тун хэмжээ, гаж нөлөөг мэддэг байх;
- Судас, булчин тариа хийх;
- Эмнэлзүйн тохиолдолд тохирсон эмчилгээ, шинжилгээ төлөвлөн хүүхэд болон эцэг эхэд зөв тайлбарлан ойлгуулах;
- Хүүхдийн биеийн байдал, өвчний явц, эмчилгээний үр дүн, тавилан, авах арга хэмжээний талаар хүүхэд, эцэг эх болон эмч нартай харилцан саналаа солилцох, тайлбарлаж ойлгуулах, зөвлөгөө өгөх;
- Эмч нарын өглөөний яриа, тасгийн яриа, эмгэг анатомийн хуралд оролцох;

Эзэмшвэл зохих хандлага

- Хүнд өвчтэй хүүхдүүд болон тэднийг асран харгалзагч нарын сэтгэл санааг ойлгон чин сэтгэлээсээ хүндэтгэн хүнлэг харилцах;
- Тухайн тасгийн эмч эмнэлгийн ажилчидтай эвсэг, баг болон ажиллах;

Уншиж судлах ном, гарын авлага

А. Үндсэн :“Хүүхдийн өвчин сурах бичиг”, 2009 он

- “Хүүхдийн өвчний оношзүй”, 1999., Н.Сүмбэрзул, С.Гантуяа, Д. Одонтуяа
- “Детские болезни”, И.В.Шабалов, 2000, 2004, Санкт-Петербург
- “Пропедевтика детских болезней”, В.А.Мазурин, 1998 г.

- “Nelson Text book of Pediatrics”
- Хүүхдийн өвчин. Д. Малчинхүү. 2010

Б. Туслах:

- “Нярайн судлал”, З.Гэрэлмаа, 2003 он
- “ХӨЦМ-ийн оюутны гарын авлага”, 2002 он
- “Хүүхдийн өвчний ангилал ба ялган оношлогоо”, М. Сүхбаатар, 2004 он
- “Хүүхдийн өвчний үндсэн ба туслах шалгуур”, М. Сүхбаатар, С. Буянт, 2004 он
- “Хүүхдэд үзүүлэх яаралтай тусламж”, 1998 он
- “Хүүхдийн амьсгалын цочмог халдвар”, Д. Малчинхүү, Н. Жаргалсайхан, Г. Оросоо
- “Хүүхдэд хийх гардан ажилбарын дүрс бичлэг”

9. ЭХ БАРИХ ЭМЭГТЭЙЧҮҮД СУДЛАЛ

Сургалтын зорилго

Эх барих эмэгтэйчүүд судлалын блок сургалтаар олж авсан мэдлэгээ багшийн удирдпаган дор эх барих, эмэгтэйчүүдийн эмчийн үйл ажиллагаанд туслах, тэдэнтэй хамтран ажиллах замаар бататгаж, НҮЭМ-ийн үндсэн тусламж үзүүлэх чадвар эзэмшинэ.

Эзэмшвэл зохих мэдлэг чадвар хандалга

Эх барих, эмэгтэйчүүдийн болон НҮЭМ-ийн кабинетд ажиллах үеэр дараах зүйлд суралцана. Үүнд:

- Кабинетийн зохион байгуулалт, үйл ажиллагааны зарчим, тайлан мэдээ гаргалт
- Эмнэлгийн анхан шатны маягт хөтлөх /жирэмсний үзлэг, хяналтын карт ./
- НҮЭМ-ийн үндсэн тусламж үзүүлэх:
 - Гэр бүл төлөвлөлтийн тусламж (жирэмслэлтээс хамгаалах арга,)
 - Хэвийн болон өртөмтгий бүлгийн жирэмсний хяналт
 - Жирэмсний эрсдлийг тогтоох.(жирэмсний гестозыг эрт илрүүлэх,дутуу т ээлт, эрхтэн тогтолцооны эмгэг)
 - Пренаталь оношилгооны аргуудын тухай мэдлэг эзэмших
 - Жирэмсний эрүүл ахуй, хооллолт
 - Терсний дараах үеийн тусламж
- Эмэгтэйчүүдэд элбэг тохиолдох эмгэгийн үед тусламж үзүүлэх.
 - Үтрээн наац эс, эдийн шинжилгээ авах арга техникт суралцах

Төрөх тасагт ажиллах үед дараах зүйлд суралцана.

Үүнд:

Хүлээн авах, яаралтай тусламжын тасаг

- Төрөх газрын зохион байгуулалт, үйл ажиллагааны онцлог, ажиллах журамтай танилцах
- Эмнэлгийн анхан шатны маягт хөтлөх /төрөлтийн түүх./
- Жирэмсэн эмэгтэйг хүлээн авах
- Жирэмсэн эмэгтэйд эх барихын гадуур үзлэг хийх
- Жирэмсэн эмэгтэйн аарцаг хэмжиж, түүнд үнэлгээ өгөх
- Жирэмсэн эмэгтэйн өндөр ба жинг үзэх
- Ургийн урьдчилсан жинг тодорхойлох
 - Ургийн зүрхний цохилт чагнах
 - Жирэмсэн эмэгтэйн эрсдлийг үнэлэх
 - Эх барихын дотуур үзлэг хийх
 - Хэт авиа болон ургийн кардиотокографийн шинжилгээ хийх
- Эхийг биеийн байдлын талаар зөвлөх

Төрөх өрөөнд

- Төрлөгийн түүхэнд бичилт болон партограмм хөтлөх

- Жирэмсний болон төрөлтийн явцын хүндрэлийг оношлох
- Төрлөгийн I үеийг хянах, II ба III үеийн тусламжийг хамтран үзүүлэх
- Умайн хүзүү болон төрөх замын зөөлөн эдийг шалгах, эмчлэх
- Хүйн анхдагч цэгцлэлт, нярайг Апгарын баллаар үнэлэх
- Бүтэлттэй нярайд анхны тусламж үзүүлэх
- Төрсний дараах цус алдалтын үед бүрдмэл тусламж үзүүлэх
- Умайн хөндийг гараар шалгах, ихэс гардах үйлдлийг харах

Жирэмсний эмгэгийг эмчлэх тасагт

- Жирэмсэн эмэгтэйн эрсдлийг үнэлэх
- Жирэмсний элбэг тохиолдох эмгэгийг (жирэмсний гестоз, илүү, дутуу тээлт, ургийн буруу байрлал, ураг орчмын шингэн ихдэлт, багадалт, уйтан аарцаг, олон урагт жирэмсэн, ихсийн байрлалын эмгэг, умайд соривтой жирэмсэн) оношлож, эмчлэх
- Төрлөгийн эрсдлийг тогтоох

Төрсний дараах тасагт

- Төрсөн эхийн биеийн байдлыг үнэлэх
- Умайн агшилтыг үнэлэх
- Шавхарганд үнэлгээ өгөх
- Төрсний дараах үед яаралтай тусламж үзүүлэхэд хамтран оролцох
- Нярайн физиологийн онцгой байдлуудыг үнэлэх

Эмэгтэйчүүдийн тасагт ажиллах үеэр дараах зүйлд суралцана.

- Эмэгтэйчүүдийн тасгийн зохион байгуулалт, үйл ажиллагааны онцлог, ажиллах журам
- Эмнэлгийн анхан шатны маягт хөтлөх / өвчний түүх./
- Эмэгтэйчүүдэд элбэг тохиолдох эмгэгийг оношлох, эмчлэх зарчим
- Оношилгооны болон эмчилгээний зорилгоор хийгдэх жижиг мэс ажилбарт(умайн хөндийг багажаар цэвэрлэх, үтрээн дурандалт, арын хүнхрээнд хатгалт хийх, эдийн шинжилгээ авах) оролцох болон харах
- Мэс засалд өвчтөнг бэлтгэх
- Мэс заслын дараа хяналт тавих
- Эмэгтэйчүүдийн яаралтай тусламж зохион байгуулах зарчим

Төрөх, эмэгтэйчүүдийн тасагт жижүүр хийх үед

- Жижүүрийн хугацаанд баг болж ажиллах, шөнийн ажлын онцлог
- Эх барихын яаралтай тусламж зохион байгуулах, өвчтөнийг эрэмблэх
- Эх барихын яаралтай тусламж үзүүлэх
- Эмэгтэйчүүдийн яаралтай тусламж зохион байгуулах зарчим
- Эмэгтэйчүүдийн яаралтай тусламж үзүүлэх

Дадлагажигч оюутны тойролтын хугацаанд мөрдөх журам

Багшийн удирдлаганд эх барих, эмэгтэйчүүдийн мэргэжлийн эмчийг дагалдан нийт 4 долоо хоног хичээллэж, 4 кредит биелүүлэх ба дараах хэсгүүдэд ажиллана. Үүнд:

- Дүүргийн ЭМН-ийн НҮЭМ-ийн кабинет- 2 долоо хоног
- Төрөх тасагт-1 долоо хоног
- Эмэгтэйчүүдийн тасаг-1 долоо хоног

Хөтөлбөрийн хугацаанд 2-оос доошгүй удаа эмчийг дагалдан төрөх, эмэгтэйчүүдийн тасагт шөнө жижүүрлэнэ.

- Дадлагажигч оюутан тэнхимийн боловсруулсан хяналтын картыг дүүргийн НҮЭМ-ийн кабинет, төрөх тасаг, эмэгтэйчүүдийн тасгийн хариуцсан эмчийн гарын үсэг бүхий баталгаажуулалт авна.
- ДЭС хариуцсан багшийн үнэлгээ хийгдэнэ.

Уншиж судлах ном, гарын авлага

- Б.Жав. Эмэгтэйчүүдийн бэлэг эрхтний зарим өвчин. УБ, 1991
- Б.Жав, Т.Эрхэмбаатар. Эхийн эндэгдлийг бууруулах боломж. УБ, 1993
- Б.Жав, Т.Эрхэмбаатар, Ж.Лхагвасүрэн. Кесар хагалгаа ба төрлөгийн механизм. УБ, 1993
- Б.Жав. Эмэгтэйчүүд судлал дахь яаралтай тусламж, УБ, 1994
- Б.Жав. Перинаталь эндэгдлийг бууруулахад чиглэсэн тусламж. (гарын авлага) УБ, 1996
- Б.Жав. Бэлгийн замаар дамжин халдварладаг зарим халдварт өвчнүүд. УБ, 1996
- Б.Жав, Д.Сүхээ Үргүйдлийн онош, эмчилгээ. УБ, 2002
- Б.Жав. Жирэмслэлт, төрөлтийн хүндрэлүүдийг удирдах арга зүй. УБ, 2001
- Б.Жав, Ж.Лхагвасүрэн. Жирэмсэн эмэгтэйн төрлөг удирдах урлаг. УБ, 2002
- Т.Эрхэмбаатар Эх барих. УБ, 1998
- Б.Шижирбаатар Эх барих. УБ, 1999 Г.Мэндсайхан, Т.Эрхэмбаатар. Эмэгтэйчүүд судлалын хэт авиан оношлогоо. Улаанбаатар 2009 он
- Т.Эрхэмбаатар. Эх барихын тулгамдсан эмгэг. Улаанбаатар 2012,2013 он
- Т.Эрхэмбаатар, Э.Лхагва-очир. Эх барих эмэгтэйчүүд судлалын үйл оношзүй. Улаанбаатар 2007 он
- Жирэмслэлт, төрөлтийн хүндрэлийг удирдах арга зүй. ЭМЯ, ДЭМБ, УБ, 2012
- Ю.В.Цвелев, бусад. Анаэробная инфекция в акушерство- гинекологической практике. Санкт- Петербург, 1995
- Акушерство (справочник Калифорнийского универси-тета. Под редакцией. К.Нисвандера, А.Эванса перевод с английского)
- В.Л.Винокуров, бусад. Справочник практикующего гинеколога. Санкт- Петербург, 2001
- Д.Авирмэд, Д.Самбуупүрэв. Умайн хүзүүний өмөнг эрт илрүүлэх скрининг арга. УБ, 2000
- Под редакцией. АН.Стражакова и другие. Избранные лекции по акушерству и гинеко-логии. Медицина.М, 1998
- В.И.Краснопольский, Гнойные воспалительные заболевания придатков матки. М, 1999
- В.И.Бодяжина, К.Н.Жмакин, АП.Кирющенко Акушерство и гинекология. М,1998
- Под ред:А.Н.Стражакова, А.И.Давыдова, Л.Д.Белецер-ковцевой. Кпинические лекции по акушерству и гинекологии. М, 2000
- В.П.Сметник, Л.Т.Тумилович. Неоперативная гинекология. М, 1999 под ред: В.К.Кулакова и другие. Практическая гинекология. М, 2001
- Т.Я.Пшеничникова Бесплодие в браке. М, 1991

- 35, В.Н.Серов, В.Н.Прилепская, Т.Я.Пшеничникова. Практическое руководство по гинекологической эндокринологии. М, 1995
 - Поззолкова Н.М, Гладкова О.Л, Симптом Синдром диагноз дифференциальная диагностика в гинекологии. Москва 2005
- Williams Obstetrics 23 edition (October 29, 2009) F. Gary Cunningham, MD
 Current Diagnosis & Treatment Obstetrics & Gynecology, Eleventh Edition (LANGE CURRENT Series)
 Obstetrics, gynecology and infertility handbook for clinicians 6th edition
 Mayo Clinic Guide to a Healthy Pregnancy
 Glass' Office Gynecology Hardcover – April 25, 2014 by [Michele Curtis MD MPH MML](#) (Editor), [Silvia T. Linares MD](#) (Editor), [Leah Antoniewicz](#) (Editor)

10. МЭС ЗАСЛЫН ӨВЧИН СУДЛАЛ

ЕРӨНХИЙ МЭС ЗАСАЛ

Хичээлийн зорилго

Удирдагч багшийн хяналтан доор эмчийн хүлээн зөвшөөрөгдсөн үүрэг хариуцлагад сурган мэс заслын өвчний хичээлээр мэс заслын өвчтэй өвчтөнийг үзэж шинжлэх, оношлох, өвчний хүндрэлээс сэргийлэх, өвчлөгсдөд анхны тусламж үзүүлэх, эмчилгээний чиглэлийг тогтоож, нарийн мэргэжлийн эмчид цаг алдалгүй явуулах, шаардлагатай бол хүргэж өгөх мэдлэг чадвар эзэмшүүлэх. Мөн мэс заслын цочмог болон олонтоо тохиолдох архаг өвчнүүдийн шалтгаан, эмгэг жам, ангилал, эмнэлзүй, оношлогоо, тэдгээрт үзүүлэх анхны тусламжийг гардан хийж чаддаг, эмчлэх боломжтой зарим өвчний эмийн эмчилгээний зарчмуудыг мэдүүлж түүнийг хэрэгжүүлэх аргад сургах

Зорилт

- Өвчтөнөөс асуумж авч, үзэж шинжлэн урдчилсан онош тавьж чаддаг байх
- Эмнэлгийн анхны тусламж зөв үзүүлэх
- Хүндрэлээс урдчилан сэргийлэх арга хэмжээ авч сурах
- Нарийн мэргэжлийн эмчид цаг алдалгүй явуулах, хүргэж өгөх
- Сумын болон өрхийн эмчийн хөтлөх баримт бичгүүдийг хөтөлж сурах
- Эмч нарын зөвөлгөөн, хөдөлмөр магадлах комиссод өвчтөнийг бэлтгэн оруулах
- Харилцааны болон зөвөлгөө өгөх чадварыг хөгжүүлэх

Сургалтанд хэрэглэгдэх материал

- Сурах бичиг, гарын авлага
- Өвчтөн эсвэл стандарт өвчтөн
- Сургалтын видео үзүүлэн, кино
- Компьютерийн үзүүлэн диск, проектор
- Жижиг мэс засалд хэрэглэгдэх материалууд (спирт, иод, саван, хагалгааны цагаан хэрэглэл, шарик, сальфетка, 0,5%-ийн новокайны уусмал, шприц, хутга, гоожуурга, гуурс, мэс заслын багаж)

Хичээлийн агуулга

№	Агуулга
1.	Хэвлийн мэс заслын цочмог өвнүүдийн шалтгаан, эмгэг жам, эмнэл зүй, оношлогоо, ялгах онош, анхны тусламж авах арга хэмжээ.
2.	Бүдүүн шулуун гэдэсний олонтоо тохиолдох өвчнүүдийн оношлогоо, анхны тусламж, эмчилгээний зарчим
3.	Мэс заслын идээт өвчнүүдийн оношлогоо, тусламж, эмчилгээний зарчим
4.	Улаан хоолой, голт, цээж, уушигны цочмог өвчнүүдийн оношлогоо анхны тусламж, эмчилгээ
5.	Судасны зарим өвчний оношлогоо, эмчилгээний зарчим
6.	Мэс заслын дараа гарах хам шинж түүний оношлогоо, тусламж, зөвөлгөө
7.	Мэс заслын шарх, тавьсан гуурс, гэдэсний цоргыг арчилах арга

Семинар

Бага бүлгээр хичээллэн сумын болон өрхийн эмчийн төшинд оношлож, анхны тусламж үзүүлэн , нарийн мэргэжлийн эмчид явуулах буюу хүргэж өгөх шаардлагатай мэс заслын цочмог өвчнүүдийг асуудал дэвшүүлэн шийдвэрлэх аргаар үзэж судлах, ингэхдээ өвчтөн дээр эсвэл дүрд тоглох хэлбэрээр хичээллэнэ. Оюутнууд өөрсдөө зохион байгуулж хичээллэх бөгөөд багш хяналт тавина.

№	Агуулга	
1.	Ходоодны гархлаа цоорох эмгэгийн эмнэл зүй, оношлогоо, анхны тусламж, авах арга хэмжээ	4 цаг
2.	Ходоод цочмог сунах эмгэгийн шалтгаан, ангилал, эмнэлзүй, оношлогоо, анхны тусламж, эмийн эмчилгээ	4 цаг
3.	Хоол боловсруулах замын цус алдалтын шалтгаан, ангилал, эмнэлзүй, оношлогоо, анхны тусламж, цус тогтоох мэс заслын бус эмчилгээ	4 цаг

Дадлага

№	Агуулга	
1.	Хатиг, буглаа, нэвчээс, нэвчдэсийн эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ түүнээс урдчилан сэргийлэх	4 цаг
2.	Хөхний цочмон үрэвслийн оношлогоо, урдчилан сэргийлэлт, эмчилгээ	4 цаг
3.	Гөгийн шалтгаан, эмнэлзүй, сэргийлэлт, эмчилгээ, Хөлийн ургаж шигдсэн хумс авах	4 цаг
4.	Идээт шархны ангилал, эмнэлзүй, эмчилгээний зарчим	
5.	Хэвлий, цөсөн зам, цээжний хөндийд тавьсан гуурс, гэдэсний цоргын арчилгаа сувилгаа	
6.	Улаан хоолой гэнэт хагарах, шалтгаан, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ	

Оюутан бие дааж, уншиж мэдсэн байх сэдвүүд

1. Кардиоспазм, шалтгаан, эмнэлзүй, оношлогоо, анхны тусламж
2. Голтын цочмог үрэвслийн шалтгаан эмнэлзүй, оношлогоо
3. Уушгины буглаа, үхжил, шалтгаан, эмнэлзүй, оношлогоо, тусламж
4. Пневмоторакс оношлогоо, эмчилгээ
5. Плеврийн эмпием, шалтгаан, эмнэлзүй, оношлогоо, тусламж
6. Цөсний хүүдийн авсаны дараах хам шинж, шинж тэмдэг, авах арга хэмжээ
7. Хагалгаа хийлгэсэн ходоодны хам шинж, эмнэлзүй, оношлогоо, эмчилгээ
8. Хэвлийн наалдаст өвчний шалтгаан, ангилал, оношлогоо, тусламж
9. Хөлийн хөх судас өргөсөх өвчний шалтгаан, эмнэлзүй, оношлогоо, урьдчилан сэргийлэлт
10. Тромбофлебитийн дараах хам шинж, оношлогоо, тусламж
11. Бөглөрөх эндартерит, шалтгаан, үе шат, эмнэлзүй, оношлогоо, урдчилан сэргийлэх, эмийн эмчилгээ
12. Ясны цочмог үрэвслийн эмнэлзүй, оношлогоо, эмчилгээний зарчим
13. Амьсгалын болон хоол боловсруулах замд гадны гадны биет орсон үед үзүүлэх яаралтай тусламж, авах арга хэмжээ
14. Хүний бэтэгийн оношлогоо, эмчилгээ, бэтэг өвчнөөс урьдчилан сэргийлэх, ялгах онош

15. Шамбарамын шалтгаан, ангилал, цочмог болон цус алдсан шамбарамын эмнэл зүй, оношлогоо, урьдчилан сэргийлэх.
16. Цочмог парапроктитын шалтгаан, эмнэл зүй, оношлогоо, авах арга хэмжээ

Оюутны хийж гүйцэтгэх ажлын жагсаалт

1. Асуулга авч өвчтөнд үзлэг хийн урдчилсан оношийн үндэслэл гарган онош тавих
2. Шинжилгээ төлөвлөн бичиг хийх, хариуг нь унших (цус, шээсний ерөнхий шинжилгээ, биохимийн шинжилгээ, рентген, хэт авиа, дуран, компьютерт томограмм гм)
3. Эмнэлгийн анхан шатны маягт, бичиг баримт хөтлөх, бүрдүүлэх, амбулаторийн карт, эмчийн үзлэгийн бүртгэл хөтлөх, оношийн шифр тэмдэглэгээ, магадлагаа, эмнэлгийн хуудас бичих, эмнэлэгт хэвтэх бичиг үйлдэх, 13А маягт бичих, ВКК, ВТЭК-т өвчтөн оруулах).
4. Эмнэлгийн дотоод үйл ажиллагаанд оролцох (эмч, ажилчидын яриа, эмч нарын зөвөлгөөн, зөвлөх эмчийн тойрон үзлэг, эмгэг анатомийн хурал, гм)
5. Мэс залын тасагт жижүүр хийх
6. Хагалгааны цэвэр болон идээт шарх боох, эмчлэх
7. Янз бүрийн новокайны хориг хийхийг харах, боломжтойг гардан хийх
8. Хэсэг газрын мэдээ алдуулалтаар жижиг хагалгаа хийхийг харах хамтарч оролцох (жижиг буглаа, хатиг, өнгөц байрлалтай гөгий нээх, хумс авах гм)
9. Өвчтөн болон ар гэрийнхэнд өвчний байдал, явц, гарч болох хүндрэл, тавилан, баримтлах дэг журмын талаар зөвөлгөө өгөх
10. Буглаа нэвчээст хатгалт хийхийг харах хамтарч оролцох
11. Хэвлий, цээжний хөндий, үенд хатгалт хийхийг харах

Бие даалт:

Тасгийн эрхлэгч, эмч, нэгдсэн эмнэлгийн мэс заслын кабинет, дүүргийн мэс заслын кабинетийн эмчийн хяналтанд мэс заслын өвчтэн үзэх, рентген, дуран, хэт авиа, лабораторийн шинжилгээнүүдэд оролцож харах, тэдгээрийн хариуг уншиж дүгнэх, өвчтөн оношлох, жижиг хагалгаанууд (буглаа, хатиг, гөгий, мастит нээх гм) –ыг хэсгийн мэдээ алдуулалтын доор хийх, хатгалт хийх , хагалгааны шарх боох, амбулаторийн баримт бичиг хөтлөх, өвчтөнийг эмч нарын зөвөлгөөн , хөвөлмөр магадлалын комиссоор оруулах зэргээр бие даан суралцана.

Долоо хоногийн ажлын 20 цагаас доошгүй цагт энэ стандартын дагуу өөрөө бие дааж уншиж суран онолын мэдлэгийг сэдвийн дагуу уншиж бичиж тэмдэглэн, судлах хэлбэрээр эрэл хайгуул хийж суралцан багшдаа шалгуулан кредит биелүүлнэ.

Дадлагажигч эмчийн бие даалтын хугацаанд оюутан мэс заслын тасаг дээр 2 удаа албан ёсоор жижүүр хийж, тайлан бичиж шалгуулна.

Оюутан бие даалтаар мэс заслыг кабинетэд хийж гүйцэтгэх ажлын чиглэл

- Мэс заслын кабинетэд хөтлөгдөх бүх бичиг баримтыг үзэж түүнийг хөтлөж сурах
- Өвчтөнөөс асуумж авч, үзлэг хийн онош тавьж шинжилгээ, эмчилгээний төлөвлөгөө гарган эмчээр хянуулж, шинжилгээ бичиж өгөх , хаана яаж шинжлүүлэхийг зааж зөвлөнө
- Зарим багажит шинжилгээ эхографи, дуран, рентген зэрэгт очиж биечилэн оролцох
- Шинжилгээний хариунуудтай танилцаж, уншиж дүгнэлт өгч сурах

- Ирсэн өвчтөний оношийг тодруулсаны дараа эмчилэгээ, шинжилгээ хаана хийх талаар шийдвэр гаргах арга барилд суралцана
- Шархтай өвчтөнийг үзэж цэвэр ба идээт шарх боож эмчлэх
- Хатиг, буглаа, гөгий, нэвчээс зэргийг хэсгийн мэдээ алдуулалтаар нээх, хумс авах, жижиг өөхөн хавдар болон гигром, атером авах хагалгаа харах, эмчийн хяналтан дор бие дааж хийх
- Харсан, үзсэн, тусалсан, гардаж хийсэн бүх ажлынхаа талаар өдөр өөр тэмдэглэл хөтөлж эмчээр гарын үсэг зуруулж баталгаажуулсан байна

Мэс заслын тасагт жижүүр хийхдээ гүйцэтгэх ажил

- Жижүүр эмч нарийн хамт тасгаар обход хийж анхаарал татсан хүнд өвчтөнүүдийг үзэж, танилцах
- Хүлээн авахаар ирсэн өвчтөнг үзэж эмчийн хяналтын дор өвчөний түүх нээх, хагалгаанд бэлтгэх ажилд оролцох
- Янз бүрийн хатгалт, новокайн хориг хийхийг харах, эмчид туслах
- Яаралтай хагалгаа хийхийг харах, бололцоотой үед гар угааж хагалгаанд туслах
- Жижүүр хийсэн тухай тайлан бичиж жижүүр эмчээр гарын үсэг зуруулж баталгаажуулна

Уншиж судлах ном, гарын авлага

1. Б. Гоош нарын “ мэс заслын өвчин “ сурах бичиг. Улаанбаатар 2000. х. 37-40, 61-63, 67, 87-100,112-118,147,172-179,216,243-258,265-276, 292-312, 323, 330-334, 352-361, 387-395, 408- 417, 420-426, 441-450, 457,471-479.
2. Б. Мөнхтоого, Ж. Эрдэнэсүрэн “ Хэвлийн мэс заслын өвчин” Улаанбаатар.2003. хх 22,75
3. О.Сэргэлэн ,Б. Гоош “Ходоод дээрхи гэдэсний шархлаа, түүний хүндрэл” Улаанбаатар.2001.х 16-114, 215-230
4. Ч.Пунцаг , Ш. Сүхбаатар, С.Эрдэнэ, “ Өрхийн эмнэлгийн эмнэл зүйн давтан сургалтын материал II боть. Модуль-4” . Улаанбаатар. 2000.308-353
5. М.И. Кузин “Хирургическое болезни” Москва.1995. х. 11-25, 44-49. 76-100, 113-124, 128, 225-248, 270-282, 313-336, 346-380, 417-432, 452-464, 473-492, 496-502, 521-547, 551-565, 587-603.
6. В.И. Стручков “ Общая хирургия” Москва.1983. х. 349-488, 533-544, 562-568
7. В.С. Савилева “ Руководство по неотложной хирургии” Москвав 1980.
8. Seymour I. Schwartz ‘ Principles of Surgery I.IISeymour I. Schwartz ‘ Principles of Surgery I.II ” .New York.196,2000.p. 1-155,223-297, 441-601, 667-1715, 2145-2262.
9. Мэс заслын өвчний нэгдсэн сурах УБ.2009. Ч.Пунцаг
10. Ерөнхий мэс заслын үндэс УБ. 1995. С.Эрдэнэ, Г.Баяраа

11.ХАВДАР СУДЛАЛ

Удиртгал :

Хичээлийн цагийн багтаамж - Лекц 4 цаг, дадлага ба бие даалт 22 цаг,семинар 4 цаг

Хавдар судлалын хичээлийг хөтөлбөрт заагдсан сэдвүүдийн дагуу эмнэл зүйн дадлага хийж гүйцэтгэнэ.

Хичээлийн тодорхойлолт.

Манай оронд зонхилон тохиолдох хорт хавдрын шалтгаан, эрсдэлт хүчин зүйлс, хавдрын эрт үеийн шинж тэмдгүүд, эрт илрүүлэлт, оношлогоо, ялган оношлогоо, урьдчилан сэргийлэлт, эмчилгээ, хяналтын зарчмуудын талаар мэдлэг, чадвар, хандлага эзэмшүүлнэ.

Зорилго.

Манай оронд зонхилон тохиолдох хорт хавдрын шалтгаан, эрсдэлт хүчин зүйлс, хавдрын эрт үеийн шинж тэмдгүүд, эрт илрүүлэлт, оношлогоо, ялган оношлогоо, урьдчилан сэргийлэлт, эмчилгээ, хяналтын зарчмуудын талаар мэдлэг, чадвар, хандлага эзэмшүүлэх

Хичээлийн залгамж холбоо.

- Ерөнхий эрдмийн хичээлүүд
- Мэргэжлийн суурь хичээлүүд (хүний биеийн эрүүл ба эмгэг бүтэц, эс судлал, биологи, удам зүй, микробиологи, эрүүл ба эмгэг физиологи, клиникийн эм зүй, лаборатори, багажит шинжилгээ, дотрын онош зүй, XII блок, XV блок, XVII блок...гэх мэт)

Суралцах нөхцөл:

- Суралцагч нь АШУҮИС- ийн Анагаах Ухааны салбарын VI дамжааны дадлагигч эмч юм.
- Онол ба лекц: АШУҮИС- ийн лекцийн заал, хичээлийн өрөөнүүдийг ашиглан явуулна.
- Дадлагын хичээл: Хавдар судлалын үндэсний төвийн мэс заслын ба мэс заслын бус тасаг, сургалтын танхим, зөвлөх амбулаторт явуулна.

Агуулгын стандарт .

Сургалтаар олж авах мэдлэг :

- Хавдрын өвчлөл, нас баралт
- Хавдрын шалтгаан
- Хавдрын молекул биологи
- Хавдрын бүтэц зүй, эмгэг жам
- Хавдрын эрт илрүүлэлт, оношлогооны орчин үеийн аргууд
- Хавдрын стандарт эмчилгээний (мэс засал, туяа, хими) талаархи орчин үеийн зарчмууд
- Хорт хавдрын төгс ба хөнгөвчлөх эмчилгээний орчин үеийн ерөнхий зарчим\
- Химийн ба даавар, био эмчилгээ, таргет болон хавдрын судасжилтын эсрэг эмчилгээ, түүний эмнүүдийн үйлчлэх механизм, хэрэглэх аргууд, гажиг нөлөөнүүд, түүнээс урьдчилан сэргийлэх, эмчлэх онцлогуудын ерөнхий зарчмуудыг мэдэх
- Хавдрын ёс зүйн зарчмууд
- Манай орны хавдрын тусламж, зохион байгуулалтын онцлог
- Толгой хүзүүний хорт хавдрын тархалт, шалтгаан эмгэг жам, эмнэл зүй, оношлогоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэлт, онцлогуудыг мэдэх

- Бөөр ба шээсний замын хавдрын тархалт, эмнэл зүйн онцлого, эрт илрүүлэлт, урьдчилан сэргийлэх, эмчилгээний ерөнхий зарчмуудыг мэдэх
- Эмэгтэйчүүдийн хорт хавдрын тархалт, шалтгаан, эмнэл зүйн онцлого, эрт илрүүлэлт, урьдчилан сэргийлэх, эмчилгээний ерөнхий зарчмуудыг мэдэх
- Эмэгтэйчүүдийн элбэг тохиолддог хорт хавдар (умайн хүзүү, их бие, өндгөвч, гадна бэлэг эрхтэний) –ын тархалт, шалтгаан, эмнэл зүйн онцлого, эрт илрүүлэлт, урьдчилан сэргийлэлт, эмчилгээний ерөнхий зарчмуудыг мэдэх
- Олонтой тохиолддог хорт хавдрын дүрс оношлогооны мэдрэг, өвөрмөц чанар, эмнэл зүйн илрэл, практик ач холбогдолыг мэдэх
- Улаан хоолой буюу ходоодны өмөнгийн сэжиг бүхий өвчтэй өвчтөний шалтгаант хүчин зүйлийг мэдэх, ямар хүн илүү өртөмтгий болохыг мэдэх (удамдаа 2-3 хүн хорт хавдраар өвчилсөн, тамхи татаж, архи дарс, давс ихтэй, хэт халуун хоол идэж уудаг, өөх тостой, шарсан, хайрсан хоол байнга иддэг, дэглэм сахихгүй хооллодог, 45 наснаас дээш насны эрэгтэй гэх мэт) заавал нэмэлт шаардлагаар хийгдэх шинжилгээнүүдийг мэдэх өмөн гэж сэжиглэж болох тулгуур түгшүүрт шинж тэмдэг (хоол тээглэх, горойх, турах, ядрах, хоолонд дургүй болох ходоодны хямрал үүсэх, хоолны шингэц удаашрах, цанхайх гэх мэт) эрт үеийн шинж тэмдэг, шалтгаангүй турах, ядрах, хоолонд дургүй болох ялангуяа махан хоолонд цанхайх, нухах, хоол тээглэх, хар шүлс гоожих, хоолны шингэц муудах, бөөлжих, цус багадах, уур уцаартай болох, рентген болон дуранд илэрдэг хавдрын онцлого шинжүүд, ялгах оношлогоонд шарх өрөвсөх, полип, лейкоплакия, улаан хоолойн судасны өргөсөл, сүрьеэ мөөгөнцөр хоргүй хавдар) өвчний үе шат, TNM , урьдчилан сэргийлэлт.
- Элэгний өмөнгийн сэжиг бүхий буюу өвчтэй өвчтөнөөс асуумж авч, түүний шалтгаан, хүчин зүйлийг мэднэ. Сэжиг бүхий тулгуур сонгомол түгшүүрт болон эрт үеийн шинж тэмдгүүдийг илрүүлж шалтгааныг тогтооно, заавал нэмэлт шаардлагаар хийгдэх шинжилгээнүүдийн жагсаалт хийнэ, элэгний анхдагч өмөнг эрт илрүүлэх альфа фетапротейн, /АФП/ ЭХО –ийн дүгнэлт, түүнд илрэх өөрчлөлтүүдийг уншиж мэддэг болох, ЭХО хяналт дор элэгний хавдраас буюу элэгний эдээс шинжилгээ авах аргыг харж, түүний үндсэн зарчмуудыг мэднэ. Элэгний анхдагч өмөнгийн хавдрыг этанол ,RFA (түлэх гэх мэт) эмчлэх аргуудыг харах үндсэн зарчмыг мэдэх, хавдрын урьдал өвчтэй өвчтөнг хяналтанд авах арга болон урьдчилан сэргийлэх арга зарчмаас сурна.
- Уушигны өмөнгийн сэжиг бүхий буюу өмөнтэй өвчтөнөөс асуумж авч, үзэж шалтгаан, хүчин зүйлс, урьдал өвчин, өмөнгөөр өвчлөмтгий бүлгийг мэдэх, сэжиг бүхий тулгуур түгшүүрт болон эрт үеийн эмнэлзүйн шинжүүдийг илрүүлэн түүнд дүгнэлт өгнө, нэмэлт ба заалт шаардлагаар хийгдах шинжилгээний жагсаалтыг мэдэх, рентгешчны болон дурангийн үед илэрдэг хавдрын сонгомол өвөрмөгц шинж, өөрчлөлтүүдийг мэдэх, ялгах оношлогоо (архаг хатгалгаа, эмфизм, бэтэг, сүрье, хоргүй хавдар, захын байрлалтай хавдар)
- Бүдүүн ба шулуун гэдэсний өмөнгийн сэжиг бүхий эсвэл өвчтэй өвчтөнөөс асуумж авч, үзэж шалтгаант хүчин зүйлс, урьдал өвчнийг таньж мэдэх, хавдраар өвчлөмтгий бүлгийг мэдэх, урьдчилан сэргийлэх, гэдэсний баруун ба зүүн талд байрласан хавдрын эмнэлзүйн онцлого, хавдрын сэжиг бүхий түгшүүрт сэрэмжлүүлэг болон эрт үеийн шинж тэмдгүүд, заавал нэмэлт ба шаардлагаар хийгдэх шинжилгээ оношлогоонууд, ялгах онош, эмчилгээний зарчим .
- Хөхний хавдрыг ба өмөн үүсгэхэд нөлөөлөх хүчин зүйлс, урьдчилан сэргийлэх, дааврын нөлөө, хөхний эмгэгшлийн эмнэлзүй, эмчилгээний зарчмууд өмөн байж магадгүй гэх түгшүүрт сэрэмжлүүлэг, шинж тэмдгүүд өмөнгийн эрт үеийн шинж тэмдгүүд, заавал нэмэлт шаардлагаар

хийгдэх шинжилгээний аргуудыг мэдэх, ялгах, оношлогоо, өмөнг илэрхийлэгч сонгомол шинж тэмдгүүдийг мэдэх, эмчилгээний ерөнхий зарчмууд

Оюутаны зайлшгүй эзэмшвэл зохих чадвар:

- Хавдартай буюу сэжиг бүхий өвчтөнөөс асуумж авч, цуглуулах
- Түүндээ дүгнэлт өгч чаддаг болох
- Хавдартай өвчтөн түүний ар гэр, төрөл төрөгсөдтэй ярилцах, илэрч буй зовиур шаналгаа, түүний шинж байдалд (өвчтөний биеийн байдал, өөрчлөлтүүд, өвдөлтийн шинжүүд, эмгэг ялгадасууд, туралт, ядралт, хоолонд дургүй болох гэх мэт) дүгнэлтөгччаддаг болох
- Өвчтөний өвчний болон амьдралын түүхийг асууж авч чаддаг болох
- Хавдрын анхдагч голомт, захын тунгалагын булчирхай, алсын үсэрхийлэл, зэргийг үзэж илрүүлж чаддаг болох
- Хорт хавдрын сэжиг бүхий хүмүүсийг эмнэл зүйн болон багажит шинжилгээ хийх төлөвлөгөө зохиож чаддаг болох
- Лабораторийн, дүрс оношлогоо, дуран, эд эсийн болон бусад шинжилгээнүүдийг илэрсэн өөрчлөлтүүдэд дүгнэлт өгч чаддаг байх
- Хорт хавдар үүсгэдэг эрсдэл бүлгүүд болон хоргүй хавдрын сонор сэрэмж болгоомжлолыг эзэмшсэн байх
- Онош хожигдлын шалтгаанд дүгнэлт өгөх
- Өвчтөний талаархи хавдрын ёс суртахууны зарчмуудыг эзэмшсэн байх
- Хорт хавдрын эсрэг эм, даавар, био ба таргет эмчилгээ болон хавдрын судасжилтын эсрэг эмнүүдийг эмнэл зүйн практикт хэрэглэх заалт, эсрэг заалт, курс эмчилгээний тун хэмжээ, эмнүүдийг хавсруулан болон хослуулан хэрэглэдэг арга, гарах хүндрэлээс урьдчилан сэргийлэх ба түүнийг эмчлэх ерөнхий зарчмуудыг мэдэж, хийж чаддаг болох
- Манай оронд олонтой тохиолддог хорт хавдрын дүрс оношлогооны зайлшгүй эзэмшвэл зохих дадлага чадварыг эзэмших ямар нэг илэрэл гарвал хортой гэж үздэг, бусад өвчнөөс ямар онцлого шинжээрээ ялгаатай вэ гэдгийг мэдүүлж, практик дадлага чадвар эзэмшүүлэх
- Хүүхдийн олон тохиолддог хорт хавдар (нефробласома, нейробластома, яс, зөөлөн эд гэх мэт) – ын эрт илэрвэл эмнэл зүйн шинж болон скрининг шинжүүд, эрт илрүүлэх, оношлох, урьдчилан сэргийлэх, эмчлэх ерөнхий арга зачмыг дадлагажуулан чадвар эзэмшүүлэх, (эмнэл зүйн болон дүрс оношлогоо, дуран болон бусад шинжилгээнүүдийн дүгнэлтийг тайлбарладаг, эсийн болон эдийн шинжилгээ авдаг болох гэх мэт)
- Толгой, хүзүүний олонтой тохиолддог хорт хавдар (хэл, доод уруул, дээд эрүү, бамбай гэх мэт) – ын эмнэл зүйн өвөрмөц шинж, бодит илрэлүүд, өвчтөнг шинжлэх өвөрмөц арга, дуран, дүрс оношлогоог тайлбарлах мэдлэг чадвар эзэмших, эсийн болон эдийн шинжилгээ авах
- Умайн хүзүү, их бие, трофобласт, өндгөвчний болон гадна бэлэг эрхтэний хорт хавдрын эмнэл зүйн шинж тэмдэг, эрт илрүүлэлт, оношлогоо, урьдчилан сэргийлэлт, эмчилгээний ерөнхий зарчмуудыг эзэмших, чаддаг болох, Папийн, цууны хүчил, люголын уусмалын сорил тавих, HPV үзэх, кольпоскопи эс эдийн шинжилгээ авах
- Элэгний хавдартай буюу сэжиг бүхий өвчтөнөөс асуумж авч, бодит үзлэг хийж чаддаг болох, элэгийг Куроловын аргаар үзэж чаддаг болох. Хавдрын сэжиг бүхий түгшүүрт сэрэмжлүүлэг болон сонгомол шинж тэмдэг, өөрчлөлтүүдийг илрүүлэх чадвар эзэмшинэ. Элэгний анхдагч өмөнг эрт илрүүлэхэд зайлшгүй хийгддэг АФП болон чанд авиан үед илэрч гардаг

өөрчлөлтүүдийг уншиж чаддаг болох, элэгний жижиг хавдраас чанд авиан хяналтан дор эс эдийн шинжилгээ авах аргыг харсан байх. Ер нь элэгнээс эд эсийн шинжилгээ авдаг арга техникийг харж мэдэх. Элэгний хорт хавдраар илүү өвчлөмтгий бүлгийг мэдэж түүнийг хяналтанд авах чадвар эзэмших. Элэгний хорт хавдрыг хоргүй хавдар(судасны өөхний холбогч эдийн цөсний, булчирхайлаг болон бэтэг, уйланхай, сүрьеэ, үсэрхийлсэн хавдрыг ялган оношлох чадвар эзэмших, эмчилгээний ерөнхий зарчим мэдэх, этанол эмчилгээ хийдэг аргыг эзэмших.

- Ходоодны хорт хавдартай буюу сэжиг бүхий өвчтөнөөс асуумж авч, бодит үзлэг хийх чадвар эзэмших. Хавдрын сэжиг төрүүлсэн түгшүүрт сэрэмжлүүлэг ба эрт үеийн шинж тэмдгүүдийг олж илрүүлж чаддаг болох, ходоодны хавдрын дуран болон рентген, КТ ба ЭХО-дээр илэрч гардаг зайлшгүй өөрчлөлтүүдийг мэдэх чадвар эзэмших. Ходоодны өмөнгийн үед илэрдэг Вирхов, Крукенберг, Шницлерийн үсэрхийллийг илрүүлэх арга техникийг эзэмшүүлэх. Ходоодны өмөнгийн эрт үеийн хам шинж (Савицкийн) мэдүүлж эзэмшүүлэх, Ходоодны өмөнг бусад өвчинтэй ялган оношлох чадвар эзэмшүүлэх (ходоодны шарх, архаг өрөвсөл, полип, сүрьеэ мөөгөнцөр гэх мэт (архаг цус багадаал Пернциозная анемия гэх мэт) Ходоодны хавдраар илүү өвчлөмтгий бүлэгийг хяналтанд авах арга, зарчмыг эзэмшүүлэх.
- Улаан хоолойн хавдартай буюу сэжиг бүхий өвчтөнөөс асуумж авч, бодит үзлэг хийх чадвар эзэмшүүлэх, хавдрын сэжиг бүхий түгшүүрт сэрэмжлүүлэг болон, өвөрмөц онцлого шинж тэмдгүүдийг илрүүлэх чадвар эзэмшүүлнэ. Улаан хоолойн хавдрын дуран, рентген, КТ граммд гардаг өөрчлөлтийг уншиж чаддаг болгох. Вирховын томорсон булчирхайг илрүүлэх арга техникийг эзэмшүүлэх. Улаан хоолойн хавдрыг бусад өвчнөөс ялган оношлох эзэмшүүлэх (шарх, архагүрэвсэл, хоргүйхавдар, түлэгдэлтгэхмэтөвчнөөсаялгах) Улаан хоолойн хавдраар илүү өвчлөмтгий бүлгийг илрүүлэх хяналтанд авах.
- Уушигны хавдартай буюу сэжиг бүхий өвчтөнөөс асуумж авч, бодит үзлэгийг үзэх чадвар эзэмшүүлэх. Уушигны хавдрын сэжиг бүхий хүмүүст заавал шинжилгээ хийх, төлөвлөгөө боловсруулах чадвар эзэмшүүлнэ. Захын байрлалтай ба төвийн байрлалтай бусад байрлалын хавдрыг эрт илрүүлэх шинжилгээний аргыг эзэмшүүлнэ. Рентген, КТ грамм, дуран, гуурсан хоолойн шинжилгээний үед илрэх өөрчлөлтүүдийг унших чадвар эзэмшүүлнэ. Уушигны хавдрыг бусад өвчнөөс ялгах эмнэлзүйн ба рентген, КТ ын өөрчлөлтүүдийг уншиж, ялган оношлох, ялгах чадвар эзэмшүүлнэ. (уушигны архаг хатгалгаа, бронхит) бронхи тэлэх өвчин, уушигны хатуурал, сүрье, захын бугалаа, бэтэг, туберкулом, уйланхай, хоргүй хавдрууд, үсэрхийлсэн хавдруудаас ялгах чадвар эзэмшүүлнэ. Уушигны хавдраар өвчилж болзошгүй өвчтөнийг хяналтанд авах, арга техник эзэмшүүлнэ. Цэрнээс эдийн болон эсийн шинжилгээ авах арга эзэмшүүлнэ. Захын байрлалтай хавдраас рентгены хяналтын дор эсийн болон эдийн шинжилгээ авах чадвар эзэмшүүлнэ. Цээжний хөндийгөөс шингэн авах арга техникийг харуулна, оролцуулна.
- Бүдүүн ба шулуун гэдэсний хавдар өвчтэй буюу сэжиг бүхий өвчтөнөөс асуумж авч бодит үзлэгийг хийх чадвар эзэмшүүлнэ. Бүдүүн гэдэсний хавдрын түгшүүрт болон эрт үеийн шинж тэмдгийг эзэмшүүлж сургана. Рентген ба дурангийн үед илрэх сонгомол шинж тэмдгүүдийг мэдүүлж түүнийг уншуулж чаддаг болгох. Шулуун гэдэсийг хуруугаар үзэх, нүдээр харах аргад суралцуулж, дадлага, чадвар эзэмшүүлнэ. Шулуун гэдсэнд толь тавих аргыг харуулж эзэмшүүлнэ. Шулуун гэдэсний далд хэлбэрийн цус алдалтыг илрүүлэх шинжилгээний аргыг харуулна. Хавдрыг бусад өвчинтэй ялган оношлох чадвар эзэмшүүлнэ. (бүдүүн гэдэсний хоргүй хавдар, шарх, өрөвсөл, Кроны өвчин, сүрьеэ, шамбарам, долихо сигма, хошногны амсарын

язрал, удамшсан полипоз гэх мэт). Бүдүүн гэдэсний хавдрын удамшилтай, хавдраар өвчилж магадгүй өвчтөнийг хяналтанд авч, эмчлэх арга эзэмшүүлнэ.

- Хөхний хавдартай буюу сэжиг бүхий өвчтөнөөс асуумж авч, бодит үзлэгийг үзэх аргад дадлагажуулан чадвар эзэмшүүлнэ. Хөхөнд хатуу бэрсүү барьж үзэж илрүүлэх, арьсанд гарсан өөрчлөлт, шинж тэмдгүүдийг тодорхойлох, арьсанд таталт байгаа эсэхийг үзэх, хөхний товчинд өөрчлөлт орсон эсэхийг шалгах. Хөхөнд хатуу бэрсүүтэй, толгой нь татагдсан буюу арьс нь татагдсан бол хорт хавдар гэж үздэгийг мэдүүлж, чадвар дадлага эзэмшүүлэх, хөхөнд өмөн байж болзошгүй түгшүүрт сэрэмжлүүлэг шинж тэмдгийг мэдүүлж эзэмшүүлэх, хөхний хавдрыг бусад өвчнөөс ялган оношлох чадвар эзэмшүүлэх (хөхний хоргүй хавдар, мастопатия, хөхний үрэвсэл, хөхний нэвчмэл хорт хавдрыг ялгах, сүрьеэ, томорсон тунгалагын булчирхайнууд, хөхний рентген болон ЭХО дээр гардаг шинж тэмдгийг мэдүүлэх чадвар эзэмшүүлэх, хөхний бэрсүү хавдарт хатгалт хийж, эсийн болон эдийн шинжилгээ хийх арга техникийг харуулан оролцуулна. Хөхний хавдрын сэжиг бүхий өвчтөнг хяналтанд авч илрүүлэх арга барилд сургана. Эмэгтэй хүн хөхөө өөрөө шалгах арга барилд сургах чадвар эзэмшүүлнэ.

Хандлага :

Зайлшгүй эзэмшвэл зохих хандлага:

- Хорт хавдрын сэжигтэй буюу өвчтөнтэй зөв эелдэг зөөлөн харьцаж сэтгэл санааг нь тайвшруулж, шинжилгээг бүрэн төгс хийдэг болох
- Хорт хавдар өвчнөөр өвчлөхгүй байх урьдчилан сэргийлэх бүрэн боломжтой гэдгийг өвчтөнд ба эрүүл хүн амын дунд сурталчилж ойлгуулах
- Хорт хавдрыг эрт илрүүлж, оношлож байж бүрэн эрүүлждэг (эдгэрдэг)гэдгийг өвчтөнд болон ард иргэдэд бүрэн ойлгуулж итгүүлэх
- Хорт хавдар эхний үедээ (2-3 жилийн хугацаанд) хүнд ямарч шинж тэмдэг зовиур илэрэхгүй учраас өөрийгөө эрүүл гэж тооцдог, 35 түүнээс дээш насны бүх хүмүүсийг жилд нэгээс хоёр удаа эмнэлгийн урьдчилан сэргийлэх үзлэгт орж байх зайлшгүй шаардлагатай гэдэгт итгүүлж үнэмшүүлэх
- Өвчтөнг эмчилгээнд оруулахдаа өвчний мөн чанар, өвчтөний дотоод сэтгэхүй болон нотолгоонд суурилсан анагаах ухааны арга барилаар хандаж байх
- Элэгний хавдартай буюу сэжиг бүхий өвчтөнтэй зөв боловсон харьцаж, эмчид өвчтөнг бүрэн итгүүлж, өвчтөнг шинжилгээ оношлогоо эмчилгээнд оруулах чадвар хандлага эзэмшүүлнэ. Өвчтөний сэтгэл санааг бүрэн тайвшруулах чадвар эзэмшүүлнэ.
- Ходоодгы хавдартай буюу сэжиг бүхий өвчтөний шалтгаан, нөлөөлөх хүчин зүйл, эрт үеийн шинж тэмдэг, шинжилгээнүүдийн өөрчлөлтүүд, оношлогоо, ялган оношлогооны талаар мэдлэг, чадвар, хандлага эзэмшүүлэн энэхүү өвчтөний сэтгэл санааг бүрэн тайвшруулах хандлага эзэмшүүлэх.
- Улаан хоолойны хорт хавдрын сэжиг бүхий өвчтөний өвчний шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлүүд, эрт үеийн шинжүүд, эрт илрүүлэлт, шинжилгээ, оношлогоо, ялгах оношлогоо, урьдчилан сэргийлэлт, эмчлэх ерөнхий зарчим аргуудыг мэдэх чадвар эзэмших хандлага эзэмшүүлэнэ, өвчнийг эрт илрүүлж, эмчилгээнд эрт орох бололцоог өвчтөнд олгох, ёс зүйн хандлага буй болгох.
- Шулуун ба бүдүүн гэдэсний хавдрын сэжиг бүхий өвчтөний өвчний шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлүүд, эрт үеийн эмнэлзүйн шинжүүд, эрт илрүүлэлт, шинжилгээ, оношлогоо, ялгах оношлогоо, урьдчилан сэргийлэлт, эмчлэх ерөнхий зарчим аргуудыг мэдэх чадвар хандлага

эзэмшүүлэн, өвчнийг эрт илрүүлж, эмчилгээнд эрт орох бололцоог өвчтөнд олгох, ёс зүйн хандлага буй болгох.

- хөхний хавдрын сэжиг бүхий өвчтөний өвчний шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлүүд, эрт үеийн эмнэлзүйн шинжүүд илрүүлэлт, шинжилгээ, оношлогоо, ялгах, урьдчилан сэргийлэлт, эмчлэх ерөнхий зарчим аргуудыг мэдэх чадвар хандлага эзэмшүүлэн, өвчнийг эрт илрүүлж, эмчилгээнд эрт орох бололцоог өвчтөнд олгох, ёс зүйн хандлага буй болгох.
- Уушигны хавдрын сэжиг бүхий өвчтөний өвчний шалтгаан, нөлөөлөх хүчин зүйлүүд, эрт үеийн эмнэлзүйн шинжүүд, эрт илрүүлэлт, шинжилгээ, оношлогоо, ялгах оношлогоо, урьдчилан сэргийлэлт, эмчлэх ерөнхий зарчим аргуудыг мэдэж, чадвар хандлага эзэмшүүлэн өвчнийг эрт илрүүлж, эмчилгээнд эрт орох бололцоог өвчтөнд олгох, ёс зүйн хандлага буй болгох.
- Эм бэлэг эрхтэний хорт хавдар урьдал эмгэгийг эрт илрүүлэх, урьдчилан сэргийлэх Пап тест, цууны хүчил, люголийн уусмалын сорил, кольпоскопи, эс эдийн мэдлэг чадвар эзэмшүүлнэ.

Арга зүйн стандарт

- Төгсөлтийн өмнөх сургалтаар хавдар судлалын хичээлийг ХСҮТ –ийн зөвлөх клиник ба эмнэл зүйн тасгуудад өвчтөн үзэж, харилцан ярилцаж оношлогоо, эмчилгээнд гар бие оролцож суралцана
- Дадлагын хичээлээр дадлажигч эмчийн хөтөлбөрт заасан сэдвүүдийн дагуу багшийг дагалдан өдөр бүр 4-6 цаг ажиллахдаа амбулатор ба эмнэлэгт өвчтөн үзэж, өвчтөн яагаад өвчилсөн, халгаат хүчин зүйл, онош хожигдолын шалтгаан, оношийн үндэслэл, TNM ба үе шат, оношлогоо, эмчилгээний төлөвлөгөө, урьдчилан сэргийлэлт, эрт илрүүлэх, хянах талаар харилцан ярилцана.
- Лекцийг потокийн оюутнуудыг хамруулан хөтөлбөрт заагдсан сэдвүүдийн дагуу уншина. Лекцийг харилцан ярилцах, асуудал дэвшүүлэх, тайлбарлан таниулах, видео үзүүлэх зэргээр явуулна.

Семинар

- Асуудал дэвшүүлсэн илтгэл / эмнэл зүйн тохиолдол/ бэлтгэж хэлэлцүүлэх хэлбэрээр хэсгийн оюутныг хамруулан семинар явуулна.
- Оюутан бүр хөтөлбөрийн хүрээнд, дадлагажих хичээлийн явцад практикт тохиолдож буй эмнэлзүйн тохиолдлыг бие даан шийдвэрлэхэд гарч байгаа бэрхшээлтэй асуудлыг дэвшүүлсэн илтгэл мөн манай оронд элбэг тохиолддог өмөнгөөр илтгэл бэлтгэж хэлэлцүүлэх, харилцан ярилцах, мэтгэлцэх, жижиг бүлгийн сургалтын хэлбэрээр семинар явагдана. Оюутан бүр багаар бэлтгэсэн илтгэлээ тайлагнаж, тухайн хэсэгт хэлэлцүүлэн, багийн системээр ажиллан, үзэл бодлоо нэгтгэн тайлагнах хэлбэрээр явуулах.
- Семинарыг багш болон оюутан удирдан зохион байгуулах ба баг болж ажиллана. Үүнд : багаар ажиллах арга барилд суралцахдаа ажлаа төлөвлөх, хуваарилах, бэлтгэх, зохион байгуулах, (цаг хугацаа, шийдвэрлэх арга хэлбэрээ тогтоох)
- Семинарт үзүүлэн, шинжилгээний хариу, эмчилгээ оношлогооны шинэлэг мэдээлэл, манай оронд мөрдөгдөж байгаа стандарт, хууль тогтоомж, эмчийн ёс зүйн арга барилыг голлон хэрэглэнэ.

Бие даалтаар :

- Семинар бэлтгэх онолын мэдээллээ цуглуулах, номын санд суух, интернет мэдээлэл цуглуулах
- Өвчтөний талаар асуудал хэлэлцүүлэх бол өвчтөний талаархи мэдээллээ бэлтгэх, түүнтэй холбоотой онолын мэдээллийг бэлтгэх
- Бие даалтыг семинарын төгсгөлд дадлага удирдсан багшид шалгуулж дүгнүүлнэ.

- Бие даалтыг тодорхой сэдвээр шинэ мэдээлэл хийх, өөрт тохиолдсон эмнэлзүйн онцгой тохиолдлуудыг бусдад танилцуулах, судалгааны ажлаа танилцуулах, хөтөлбөрт заагдсан сэдвүүдээр тэмдэглэл хөтлөх, реферат, гарын авлага, жижиг ном, танилцуулга, эссэ бичих замаар биелүүлнэ.

Бие даалтын сэдэв

- Төмсөгний ба бөөрний дээд булчирхайн хавдар
- Яс ба зөөлөн эдийн хавдар
- Гялтан хальсны хортой ба хоргүй хавдар
- Арьсны хавдар ба меланома
- Лимфома
- Лимфогрануломатоз
- Эмчилгээний гаж нөлөөг эмчлэх
- Хэвлийн гялтангийн үсэрхийлэлийн оношлогоо, эмчилгээ

Сонголтоор :

- Хорт хавдрын молекул биологи
- Онкоген
- Хавдрын судасжилт
- Геном
- Үсэрхийлэл ба цөмөрч ургах
- Хавдрын тулгуур эс
- Мэдрэлийн системийн хавдар
- Ген эмчилгээ

Ном сурах бичиг .

- Ганцев. Ш.Х. Онкология (учебник) Москва 2004 он
- Черинков. В.Г. “ Клиническая онкология “ Москва 1999 ,
- Трапезников А.Н. Шайин А.А. “ Онкология “ (учебник)Москва, 1992
- Справочник по онкологии, под ред. Н.Н. Трапезникова, И.В. Поддубной Москва 1996
- Олонтой тохиолддог хавдрын урьдчилан сэргийлэлт, оношлогоо (гарын авлага) 2002 он ДЭХБ –ын орчуулгын ном.
- Б.Гоош бусад, Мэс заслын өвчин 2002
- Хавдрын оношлогоо эмчилгээ (гарын авлага) 1998
- Ошибки в клинической онкологии. Руководство для врачей Москва 1993, 2003 под ред В.И. Чессова АМН, проф А.Х. Трахтонберга
- Philip Rubin ‘ Clinical oncology ‘ 8 the edition 2002, W.B. Saunders company
- Мэс заслын эмгэгүүдийн нэгдсэн сурах бичиг. 2009, 6-р бүлэг
- Хавдар судлалын сурах бичиг – Р. Сандуйжав 2013
- “Онкология” А.А. Шайн 2004, Тюмень
- Руководство по Химиотерапии Опухолевых заболеваний” под ред Н.И. Переводчиковой 2005, Москва
- Детская Онкология “ под ред М.Б. Белогуровой 2002, Санкт-Петербург
- w.w.w. cancer. Gov. / cancer. Org

- De Vita, Hellman, Rosenberg ‘ Cancer; Principles & Practice of oncology ‘ 2 volume set 2008, 2011

12. ГЭМТЭЛ СОГОГ СУДЛАЛ

Энэхүү хөтөлбөр нь АШУҮИС-ийн АУС-ийн төгсөх анги буюу 6-р курсын ДЭС-ийн сургалтаар Гэмтэл согог судлалын хичээлийн судлах үндсэн баримт мөн юм.

Удиртгал:

Осол гэмтэлтэй өвчтөнг гардан үзэж шинжилж, ялган ангилж, анхны тусламж үзүүлж, зохих эмчилгээ хийж, шаардлагатай үед зөв чиг боолт хийж дараагийн шатлалын эмнэлэгт тээвэрлэн хүргэх. Эсвэл нарийн мэргэжилийн эмч иртэл өвчтнийг тогтоон барих арга хэмжээ авах чадвар бүхий ерөнхий мэргэжлийн эмчийн төвшинд мэдлэг эзэмшүүлнэ.

Зорилго:

Орчин үед зонхилон тохиолддон осол гэмтэлтэй өвчтөнг үзэж оношлон, анхан шатны тусламж үзүүлдэг. Тухайн өвчтөний цаашидын эмчилгээний менежментийг зохион байгуулах чадвар мэдлэг бүхий ерөнхий мэргэжлийн эмч бэлтгэхэд оршино.

Зорилт:

- Тулгуур хөдөлгөөний эрхтэний гэмтэлтэй өвчтөнийг судлан үзлэг шинжилгээ хийж анхан шатны тусламж үзүүлэн, зохих эмчилгээ хийж, хяналт тавьж хүндрэлээс урьдчиллан сэргийлэх, дараагийн шатлалын эмнэлэгт зөв тээвэрлэж хүргэх
- Гавал тархи, цээж хэвлийн гэмтэл ба түлэгдэл, хөлдөлт болон бусад золгүй явдлаас осолдож гэмтсэн өвчтөнд анхан шатны тусламж үзүүлэхэд
- Өвчтөний өнөөгийн болон цаашидын тавилангийн талаар өвчтөн болон тэдний ар гэрийнхэнд танилцуулж, сэтгэлзүйн зөвлөгөө өгөх ур чадвар эзэмшүүлэх
- Гэмтэл согогтой өвчтөнг бүртгэх, мэдээллэх, эмнэлэгийн илгээх хуудас олгох, анхан шатны маягтууд хөтлөх ХЧА-ыг зохицуулах зэрэг бичиг баримттай танилцуулж, тэдгээрийн талаар зохих мэдлэг болгох
- Осол гэмтлээс урьдчиллан сэргийлэх талаар ард иргэдэд мэдээ мэдээллийн хэрэгсэлүүдийг ашиглан сурталчиллагаа хийх дадал эзэмших

Хөтөлбөрийн багтаамж:

Нийт 2 долоо хоног хичээллэж 1- кредит биелүүлэх ба контакт цаг 26 цаг, бие даалт 32 цаг нийт 58 цаг багтана. Контакт цагт лекц 4 цаг, семинар 8 цаг, дадлага 16 цаг, өдөрт 6 цагаар 7 хоногт 5 өдөр ажиллана. 7 хоногт лекц 1 удаа 2 цаг, семинар 2 цагаар 4 удаа хийх ба бусад цагуудад эмнэлзүйн асуудал шийдвэрлэнэ.

Хичээлийн агуулга:

Лекцийн хичээлээр

- Ясны бороолох механизм, үе шат, түүнд нөлөөлөх хүчин зүйл бороололтыг идэвхжүүлэх эмийн, уламжлалт, эмийн бус арга /2 цаг/
- Гэмтлийн дараах хүндрэлүүд, тэдгээрээс урьдчиллан сэргийлэх /2 цаг/

Дадлагийн хичээлээр:

- ДЭМБ-ын өвчлөлийн төвшин, гэмтэл-согогийн эзлэх хувь, осол гэмтлээс урьдчиллан сэргийлэх 2002 оны засгийн газрын хөтөлбөр
- Тархи нуруу нугасны гэмтэлтэй өвчтөний гэмтлийн механизмтай танилцах, өвчтөнөө гардан үзэж, илрэх хам шинжүүдийг илрүүлэх, шинэ өвчтөнд хийгдэх шинжилгээг төлөвлөх буюу гарсан хариуг уншиж үнэлэлт, дүгнэлт өгөх, оношлох, эмчилгээ ба шинжилгээний энгийн арга үйлдүүлтэй танилцах зарим төрлийн боолтуудыг бие даан хийнэ. Өвчний хүнд хөнгөнөөс шалтгаалан хийх эмийн эмчилгээний ерөнхий зарчмыг мэдсэн байна. Гэмтлийн дараах ХЧА-ыг зохицуулах заавар журмын мэдлэгтэй болох

- Эгэм дал, атгаал, шуу богтос, сарвуу яснуудын хугарал, мултрал үүсэх гэмтлийн механизмтай танилцах, гэмтлүүдийн үед илрэх хам шинжүүдийг үзэж, илрүүлэх оношоо бататгах, шинжилгээг хийх хариуг унших, мөрний мултралуудын хэлбэр, түүнийг оруулах арга, технологи боолтыг эзэмшиж энгийн хугарал засах буюу чиг боолтуудыг хийж сурах, ХЧА-ыг зохицуулах заавар журамтай танилцах
- Аарцаг сүүж, дунд чөмөг, шилбэ, тавхай яснуудын хугарал, мултар үүсэх механизмтай танилцах, хугарал мултралын үед илрэх хам шинжүүдийг үзэж илрүүлэх, оношоо бататгах, шинжилгээг хийх, хариуг унших, оношлох, гэмтлийн дараа хийх эмчилгээний ерөнхий зарчмыг мэдэх, чиг боолтуудтай танилцан энгийн арга технологийг эзэмших, гипс тавих ба авах арга, гипстэй байх хугацаа, гэмтлийн дараах ХЧА-ын заавар хурмыг мэдэх
- Манай оронд элбэг тохиолддог төрөлхийн түнхний мултрал, майга тавхай, гилжгий хүзүү зэрэг төрөлхийн согогуудыг үзэж эрт илрүүлэх, дээрх согогууд үүсэх шалтгаалан илгээх журмыг мэдэх, гэмтлийн дараа ба бусад өвчний улмаас үүссэн согогууд / сколиоз, мөчдийн контрактур, деформациуд, хуурамч үе гэх мэт/ -ыг оношлох эмчилгээний зарчмыг мэдэх, согогтой өвчтөний ХЧА-ын заавар журамтай танилцах
- Цээж хэвлийн гэмтэлтэй өвчтөнийг үзэж оношлох, эдгээрийг ердийн өвчтөнөөс ялган оношлох, цээж гэрэлд харах буюу хэвлийн ЭХО хийсэн шинжилгээг унших, эмчилгээний ерөнхий зарчмыг мэдэх, яаралтай мэс засал хийх өвчтөнг хугацаа алдалгүй нарийн мэргэжлийн эмчид илгээх
- Хөлдөлт, түлэгдэлт, зөөлөн эдийн битүү гэмтлийг үзэж, оношлох, гэмтлийн үед хийх боолт, чигнүүдийг хийж сурах, төрөл бүрийн шархыг үзэж түүнд анхны тусламж үзүүлэх, энгийн шарханд ариутгал хийж, энгийн шарханд оёдол тавих, боолт хийх
- Гэмтэлийн дараах хүндрэлүүд болох ясны идээт архаг үрэвсэл, хуурамч үе, удаан дарагдалын хам шинж зэргийг ялган таньж дараагийн шатлалын эмнэлэгт шилжүүлэх арга хэмжээ авах.

Семинарын хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө:

- Гэмтлийн дараах чиг боолтуудыг тавих арга аргачлал
- Мултралын үед мэдээгүйжүүлэх, мултрал засах түүнд хийх боолт бэхэлгээ, амьбулториор хянах
- Зарим энгийн хугарлыг гар аргаар засч эвлүүлэх, түүнд хийх бэхэлгээ, амьбулториор хянах
- Гавал тархи-Нуруу нугасны гэмтлийн дараах өвчтөнг хянах эмчилгээний зарчим

Хичээлийн сэдэвчилсэн төлөвлөгөө:

Лекцийн сэдэв:

№	Лекцийн сэдэв	Цаг
1.	Ясны хугарал бороолох механизм, үе шат түүнд нөлөөлөх хүчин зүйл, бороожуулалтыг идэвхжүүлэх эмийн ба уламжлалт, эмийн бус арга	2 цаг
2.	Гэмтлийн дараах хүндрэлүүд тэдгээрээс урьдчиллан сэргийлэх	2 цаг

1. Дадлагын хичээлийн явцад бие дааж судлах, багштайгаа харилцан ярилцах сэдвүүд

№	сэдэв	Цаг
1.	Гэмтэл согогийн өвчтөнгөөс асуумж авах	2 цаг
2.	Гэмтэл согогийн өвчтөнг үзэж үнэлэлт дүгнэлт хийх	2 цаг
3.	Гэмтэл согогтой өвчтөнг шинжлэх оношлох	2 цаг
4.	Гэмтэл согогтой өвчтөнд зөв зохистой яаралтай анхны тусламж үзүүлэх	2 цаг
5.	Гэмтэл согогтой өвчтөнд зөвлөгөө өгөх хяналт тогтоох	2 цаг

Гэмтлийн эмнэлэгт стационарын тасагт ажиллах зарчим

- Өглөөний 08:30 минутанд ажилд ирж ажлын 6 цаг ажиллана

- Ажлын иж бүрэн дүрэмт хувцастай байна
- Эмч багшийн удирдлагын дор тасагт хэвтэж буй 5-8 өвчтөнг бие даан үзэж эмчилнэ өвчний түүхэнд тэмдэглэл хийнэ.
- Өвчний түүх нээх, хөтлөх, эцсийн дүгнэлт бичиж шилжүүлэх маягт хөтлөх
- Өвчтөнүүдээ нэмэлт шинжилгээнд бэлтгэх, шинжилгээг хийхэд биечлэн оролцох
- Өвчтөнийг мэс засалд бэлтгэх \клизм тавих,сэтгэл зүйн бэлтгэл хийх,цусны бүлэг тодорхойлох,тохироо үзэх\
- Өвчтөнгүүдийн боолтонд оролцож бие даан хийх
- Гипс бэлтгэх, тавих авах, үйлдлийг бие даан хийнэ.
- Ясны татлага хийх, мултрал оруулах, хугарал засах зэрэг гардан үйлдлийг эмч багшийн хяналтанд хийнэ.
- Эрчимт эмчилгээнд байгаа өвчтөнг багшийн хамт үзэх
- Зөвлөх эмч, тасгийн эмч нарын хамтарсан үзлэгт оролцох
- Эмч багшийн хамт хагалгаанд туслагчаар оролцох, явцыг биечлэн харах
- Өдрийн хийсэн харсан, үзсэн, биечлэн хийсэн, оролцсон зүйлээ өдөр бүр тэмдэглэл хийж эмч багшаараа гарын үсэг зуруулсан байна
- Стационарт ажиллахдаа эмнэлэгийн үндсэн эмчилгээний тасгуудад 1 удаа жижүүр хийнэ.

Гардан үйлдэл болон үзэж харсан байх ур чадварын төвшинг дараах 4 оноогоор үнэлнэ.

1. Сонссон, дуулсан
2. Харсан
3. Гүйцэтгэсэн ба хамтарч хийсэн
4. Эзэмшсэн байх

13. ЯАРАЛТАЙ ТУСЛАМЖ СЭХЭЭН АМЬДРУУЛАХ

Хичээлийн зорилго

Монгол орны нөхцөлд зонхилон тохиолдох цочмог өвчин эмгэгийг ососл гэмтлийг оношлох, ялган оношлох, амин чухал эрхтэн системийн үйл ажиллагааны алдагдлыг дүгнэх, яаралтай тусламжийг цаг алдалгүй стандартын дагуу үзүүлэх, хүнд өвчтөнийг аюул осолгүй тээвэрлэх, эрчимтэй эмчлэх, дээрх эмгэгүүдээс урдчилан сэргийлэх онолын мэдлэг, практик дадлага, хандлага эзэмшүүлнэ..

Зорилт

- Зонхилон тохиолдох цочмог өвчин эмгэгийг ососл гэмтлийг оношлох, ялган оношлох
- Амин чухал эрхтэн системийн үйл ажиллагааны алдагдлыг дүгнэх
- Амин чухал эрхтэн системийн үйл ажиллагааны алдалтай өвчтөнд яаралтай тусламжийг цаг алдалгүй үзүүлэх онол дадлага эзэмших
- Эмнэлгийн яаралтай тусламжийн хичээл нь эмнэлгийн анхны тусламжийн багц сургалтын үргэлжлэл бөгөөд зүрх судас, амьсгалын эрхтэн системийн үйл ажиллагааны цочмог алдагдал, химийн хордолт, хүрээлэн байгаа орчны хорт нөлөөнөөс үүссэн өвчин эмгэгийг оношлох, яаралтай тусламж үзүүлэх арга барилд сургана.
- Яаралтай тусламж, эрчимт эмчилгээний үеийн эмчийн ёс зүй, харилцааны зарчмуудыг сургах
- Яаралтай тусламж үзүүлэх онол, дадлагыг нотолгоонд тулгуурлан суралцах, мэдлэгээ баяжуулах чадвар эзэмшүүлнэ.

Дадлага

Эмнэлзүйн тохиолдол ажиллах, эмнэлгийн яаралтай тусламж, эрчимт эмчилгээний хэсэгт ажиллах, хүнд өвчтнийг үзэх, асрах, сувилах арга аргачлалд суралцах зэргээр явагдана.

Семинар

Оюутан төвтэй жижиг бүлгээр асуудал дэвшүүлэн шийдвэрлэх замаар ярилцлага зохион явуулж эцэст нь багш дүгнэж мэдлэгийн нэгдсэн, ижил түвшинд хүрнэ.

Бие даалт

Хичээлийн бус цагаар эмнэлгийн яаралтай тусламжийн хичээлээр бие дааж судлах сэдвийн дагуу уншиж товчлол реферат бичих, багшаас зөвлөгөө авч ажиллах.

Бие даалтын сэдэв

- Амьсгалын цочмог дутагдал, шалтгаан, хэлбэрүүд, тахипное, гипокси, яаралтай тусламж, хүчилтөрөгч эмчилгээний аргууд
- Тархинд шигдээс үүсэх, цус харвах хэлбэрүүд, оношлох, эмчлэх аргууд, уналт таталын хам шинж, эмчилгээ
- Гэмтлийн үед үзүүлэх яаралтай болон анхны тусламжийн стандарт
- Ус эрдсийн болон хүчил шүлтийн тэнцвэр алдагдал, шалтгаан, оношлогоо, яаралтай засварлах аргууд

- Цээжээр өвдөх үеийн ялган оношлох, яаралтай тусламж

Уншиж судлах ном, гарын авлага

А. Үндсэн сурах бичгүүд:

- С.А. Сумин “ Неотложное состояние”. 2001. Москва. Медицина
- Малышева В.Д., Интенсивная терапия, реанимация, первая помощь., “Медицина” 2000

Б. Бусад сурах бичгүүд:

- А.А. Бунятян “Руководство по анестезиологии” 1997
- Michael B.Dobson. Anesthesia at the District Hospital. 2000
- А.П. Зильбер “Клиническая физиология для анестезиолога”
- Пауль Л. Марино” Интенсивная терапия” 1998
- Е.А. Дамир и др. “Квалификационные тесты по анестезиологии и реаниматологии /1, 2 часть/ 1997
- А. А. Цыганий. “Карманный справочник анестезиолога”Англи хэлнээс орчуулсан, Киев, 2001
- Дэвид М. Габа и др. “Критические ситуация в анестезиологи” Англи хэлнээс орчуулсан, 2000
- Earle W. Wilkins, JR, Emergency Medicine

14. ХАЛДВАРТ ӨВЧИН СУДЛАЛ

Хичээлийн зорилго

Монгол оронд зонхилон тохиолддог халдварт өвчнүүдийн эмгэгийг ерөнхий мэргэжлийн эмчийн түвшинд оношлох, эмчлэх, хянах, зөвлөлгөө өгөх, урьдчилан сэргийлэхэд шаардлагатай онолын мэдлэг, практик чадвар, хандлага эзэмшүүлнэ.

Оюутны эзэмшвэл зохих мэдлэг

- Монгол улсын Халдварт өвчинтэй тэмцэх үндэсний хөтөлбөрийн агуулгыг ойлгож, үүний дагуу ерөнхий мэргэжлийн эмчийн гүйцэтгэх үүргийг мэдсэн байна.
- Дэлхий дахинд Шинээр болон дахин сэргэж байгаа халдваруудын тухай ерөнхий мэдлэгтэй болно.
- Цусан суулга, сальмонеллез, урвах тахал, улаан бурхан, гахай хавдар, салхин цэцэг, менингококкт халдварын оношлогоо, хяналтын талаар мэдлэг эзэмшинэ.
- Вируст гепатит болон гэдэсний халдварт өвчний дараах хяналтын талаар мэдлэг эзэмшинэ.
- Боом, галзуу, татран, хөхүүл ханиад, сахуу, тарваган тахал өвчний халдвар судлал, эмнэлзүй, голомтонд авах арга хэмжээг мэддэг болно.
- Халдварт өвчний үед тохиолдох эгзэгтэй байдлуудын оношлогоо, анхны тусламж

Эзэмшвэл зохих чадвар

- Хэвлийн доод хэсгээр өвдөх хамшинжийг оношлох эмчлэх
- Сальмонеллез, цусан суулга, урвах тахал өвчний хэвшинжит хүндрэлгүй хэлбэрийг оношлох, эмчлэх
- Цочмог А, В, С, Д вируст гепатит өвчний хэвшинжит хүндрэлгүй хэлбэрийг оношлох, эмчлэх
- Улаан бурхан, улаанууд, улаан эсэргэнэ, ёлом өвчний хэвшинжит хэлбэрийг оношлох, эмчлэх
- Менингококкт халдварыг оношлох, анхны арга хэмжээнүүдийг авч чаддаг
